

The background of the entire page is a complex geometric pattern. It features a large, stylized letter 'G' on the right side, filled with a brown diamond-shaped grid. To the left of the 'G' and extending across the bottom is a pattern of smaller, scattered brown, blue, and teal diamonds. Faint, thin grey lines crisscross the background. In the bottom left corner, there is a logo for Golomt Bank, consisting of a blue square with a white 'G' inside, followed by the text 'ГОЛОМТ БАНК' in blue and 'Сайн сайхныг санхүүжүүлнэ' in a smaller, italicized blue font.

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

ЖИЛИЙН
ТАЙЛАН 2019

АГУУЛГА

ЭРХЭМСЭГ ОРШИХУЙ, АЛСЫН ХАРАА 2019 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ УДИРДЛАГЫН БАГ, БҮТЭЦ

Удирдлагын баг
Байгууллагын бүтэц

ЭДИЙН ЗАСАГ, БАНКНЫ СЕКТОР

Эдийн засгийн орчин
Банкны сектор

САНХҮҮГИЙН ҮР ДҮН ДИЖИТАЛ БАНК, ИННОВАЦ ИРГЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛ АРИЛЖАА, ХӨРӨНГИЙН МЕНЕЖМЕНТ ГАДААД ЭХ ҮҮСВЭР, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Олон улсын бизнес харилцаа
Гадаад худалдааны санхүүжилт
Тогтвортой хөгжлийн санхүүжилт


ХҮНИЙ НӨӨЦ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА КОМПАЕНСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТУЗ-ийн бүрэлдэхүүн
Засаглалын бүтэц

ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН

жилийн
ТАЙЛАН 2019

3



БИДНИЙ
АЛСЫН ХАРАА



Дэлхийн жишиг
Монголын банк

БИДНИЙ
ЭРХЭМСЭГ
ОРШИХУЙ







Хөгжлийн
ГОЛОМТ

БИДНИЙ
СТРАТЕГИ



Харилцагч
ТӨВТЭЙ банк



Голомт банкны ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ 2019

ЖИЛИЙН
ТАЙЛАН 2019 7

Олон улсын тэргүүлэх туршлагыг салбартаа түүчээлэн нэвтрүүлсээр ирсэн Голомт банк 2019 онд технологийн хөгжилд тулгуурласан дижитал шилжилтийн давлагааг өрнүүлж, хиймэл оюун ухаанд суурилсан Шинэчлэгдсэн Интернэт банк, Смарт банкны үйлчилгээг нэвтрүүлж, Монгол Улсад анх удаа Дата анализ дээр суурилсан “Миний санхүү” хувийн санхүүгийн туслах үйлчилгээг танилцууллаа.



**30 мянган
харилцагч**
виртуал картын
хэрэглэгч боллоо



Интернэт банк болон
Смарт банкны шинэчилсэн
**5.0 хувилбарыг
танилцууллаа**



**Дижитал
цалингийн зээл**
үйлчилгээг
нэвтрүүллээ



SocialPay
аппликейшнаар 2.1
тэрбум төгрөгийн төлбөр
тооцоо хийгдэж, виртуал
картын хэрэглэгч

**30,000
боллоо**



Global Banking &
Finance сэтгүүлээс
**Монгол улсын
шилдэг
дижитал банк**



ICT Expo
2019
**Шилдэг
дижитал
үйлчилгээ**

Infosys®
**INFOSYS CLIENT
INNOVATION
AWARD 2019**-ийн

Product innovation
төрөлд “SocialPay”
хэтэвч шалгарлаа



Хиймэл оюун ухаанд
суурилсан дижитал
банкны үйлчилгээг
**салбартаа анхлан
нэвтрүүллээ**



Нийт гүйлгээний 93%
онлайн сувгаар дамжиж,
жилд дунджаар
**11 сая орчим гүйлгээ
хийгдэж байна**



Global Finance сэтгүүлээс
**МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ
ДИЖИТАЛ БАНК**
шагнал хүртлээ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Даргын МЭНДЧИЛГЭЭ

Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс банкны үйл ажиллагааг бэхжүүлэх хүчин чармайлтаа тасралтгүй үргэлжлүүлж, стратегийн түвшинд удирдлагын чадварыг улам сайжруулж, боловсронгуй болгох тал дээр хичээл зүтгэл гарган ажиллалаа.



**Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид,
харилцагчид, түншүүд, хамтран
ажиллагсад аа,**

2019 оны санхүүгийн жилийн эцсээр Голомт банкны жилийн тайланг танд толилуулж байгаадаа таатай байна. Монгол Улсын эдийн засаг, зах зээлийн орчин сүүлийн жилүүдэд дараалан эерэг, өсөлттэй гарсан ч 2018 онд 7.2 хувь байсантай харьцуулахад тайлант онд буюу 2019 онд ДНБ-ий өсөлт 5.1 хувьд хүрч, саарч эхлэв.

Өнгөрсөн оны эхээр гадаадын шууд хөрөнгө оруулалтын эерэг урсгал ажиглагдаж байсан ч жилийн эцсээр цэвэр экспортын бууралт болон гадаад өрийн хэмжээ ДНБ-ээс хоёр дахин нэмэгдсэн зэрэг нь эдийн засагт сөрөг нөлөөг авчирлаа.

Эдийн засаг агшиж, бизнесийн өсөлт удааширч эхэлсэн нь банкны салбарыг ч тойрсонгүй. Гэсэн ч энэ саад бэрхшээлийг үл харгалзан Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс банкны үйл ажиллагааг бэхжүүлэх хүчин чармайлтаа тасралтгүй үргэлжлүүлж, стратегийн түвшинд



удирдлагын чадварыг улам сайжруулж, боловсронгуй болгох тал дээр хичээл зүтгэл гарган ажиллалаа.

2019 оны дунд үед Төлөөлөн удирдах зөвлөл Ноён Норихико Като Голomt банкны Гүйцэтгэх захирлаар томилсон билээ. Түүний хувьд Япон, АНУ, Европ, Ойрхи Дорнод зэрэг санхүүгийн гол төв болсон олон улсын банкны секторт 30 гаруй жил ажилласан арвин их туршлагатай төдийгүй, Монголын банкны салбарт ч удирдлагын багийг ахлан ажиллаж байсан туршлагатай нэгэн юм.

Ийнхүү удирдлагын багт шинэчлэл явагдсантай холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөл банкны хэрэгцээ шаардлагад тулгуурлан хэд хэдэн бүтцийн өөрчлөлтүүдийг хийлээ. Шинэ арга барил, шинэ менежментийг хэрэгжүүлснээр бизнесийн өсөлтөд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр банк даяарх бүхий л үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх, үр нөлөөг сайжруулахад ихээхэн түлхэц болж өгсөн юм.

2020 оны хувьд Ковид-19 вирус дэлхий даяар тархаж, цар тахлын хэмжээнд хүрсний улмаас бүх улс орон, бүхий л хүн төрөлхтөн хамгийн сорилттой, хэцүү цаг үеийг туулж байна. Өмнө нь бидэнд тулгарч байгаагүй хүнд үед Голomt банк иргэддээ үйлчлэх уламжлалт соёлоо хадгалж, сорилттой цаг үеийг хамтдаа даван туулахын тулд харилцагчид, үйлчлүүлэгчдээ дэмжин ажиллаж, боломжит бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргээ биелүүлж байгаа билээ.

Өнгөрч буй онд бидний хамтрагчид, харилцагчид, хувь нийлүүлэгчдийн дэмжлэг, Голomt банкны нийт хамт олны итгэл, зүтгэлийн үр дүнд ололт бүтээлээр дүүрэн нэгэн жилийг үдэж чадлаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэрийн өмнөөс бидний хамтдаа хүрсэн өнөөдрийн амжилтын хэлхээ жилээс жилд үргэлжлэн улам батжин бэхжиж, алсаа харсан шинэлэг санаачлагууд дор илүү өндөр оргил өөд хүрнэ гэдэгт гүнээ итгэлтэй буйгаа илэрхийлэхэд таатай байна.

Хүндэтгэсэн,



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга,
Ч. Мөнхцэцэг

Гүйцэтгэх Захирлын МЭНДЧИЛГЭЭ

2019 онд Голомт банк бүтэц зохион байгуулалтын цөөнгүй өөрчлөлтийг хийж хэрэгжүүлэн, хорооны бүтцийг тэлснээр засаглалын тогтолцоог хүчирхэгжүүлэхээс гадна нээлттэй хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, ил тод байдлыг дэмжсэн нь банкны өдөр тутмын үйл ажиллагаанд ч мөн үр дүнгээ өглөө.



Монгол Улсын ДНБ-ий өсөлт 2017 онд 5.4%, 2018 онд 7.2%-д хүрч сэргэж байсан ч 2019 онд 5.1% болон агшихад түүхий эдийн үнэ буурч, уул уурхайн салбарын өсөлт саарч, ашигт малтмалын экспорт буурсан зэрэг нь голчлон нөлөөллөө. 2018 онд банкны системийн хэмжээнд зээлийн хэмжээ огцом өссөнтэй холбоотойгоор Төв банкнаас хэрэглээний зээлд тавих болзлуудыг чангатгаж, арилжааны банкнуудад 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх шаардлага тавьсан.

Улмаар 2019 онд эдийн засгийн өсөлт удааширсан үед Голомт банк зээлийн өсөлтөө сайтар хянаж, зээлийн багцыг 3.9% -иар нэмэгдүүлснээр 3.3 тэрбум төгрөгт хүрсэн бол харилцагчаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 11.3% -иар өсөж, 4.9 тэрбум төгрөгт хүрлээ.

Бид эх үүсвэрийн хяналтаа сайжруулснаар өнгөрсөн жилд цэвэр хүүний орлогыг 24.1% -иар өсгөж 212 тэрбум төгрөгт хүргэх чадавхтай байсан хэдий ч зээлийн сангийн зардал 2018 онд 66.2 хувьтай байсантай харьцуулахад даруй 104.8 хувиар өсөн 135 тэрбум төгрөгт хүрсэнтэй холбоотойгоор чанаргүй зээлээ бууруулахад идэвхийлэн анхаарч ажиллалаа. Үр дүнд нь цэвэр хүүний орлого 76.4 тэрбум төгрөгт хүрсэн нь 2018 онд 104.6 тэрбум төгрөг байсантай харьцуулахад 26.9 хувиар буурсан үзүүлэлт болсон бол татварын дараах цэвэр ашиг мөн өмнөх онд 53.5 тэрбум төгрөг байснаас 69.5 хувиар буурч 16.3 тэрбум төгрөгт хүрсэн зэрэг нь 2019 он Голомт банкны хувьд тооноос илүү чанарт, эрсдэлийн хяналтад анхаарсан жил байсныг илтгэж байна.

2019 онд Голомт банк бүтэц зохион байгуулалтын цөөнгүй өөрчлөлтийг хийж хэрэгжүүлэн, хорооны бүтцийг тэлснээр засаглалын тогтолцоог хүчирхэгжүүлэхээс гадна нээлттэй хэлэлцүүлгүүдийг зохион



байгуулж, ил тод байдлыг дэмжсэн нь банкны өдөр тутмын үйл ажиллагаанд ч мөн үр дүнгээ өгсөн юм.

Өнгөрсөн онд банкнаас хараат бус эрсдэлийн удирдлага нь шаардлагатай тохиолдолд цаг тухайд нь арга хэмжээ авах зорилгоор банкны бүхий л эрсдэлийг тодорхойлж, хянах үйл ажиллагаагаа улам сайжруулсан бол хүний нөөцийн удирдлагын хувьд гүйцэтгэлийн үнэлгээ, нөхөн олговрын тогтолцоог боловсронгуй болгож, дунд болон ахлах менежерүүдэд зориулсан сургалтын шинэ хөтөлбөрүүдийг нэвтрүүллээ. Мөн зээлийн үйл ажиллагаа болон зээлийн багцыг сайжруулах ажлуудыг хийж гүйцэтгэн, банк цаашдын өсөлтийн үндэс суурийг илүү хүчирхэгжүүлэхийн тулд шаргуу ажилласан жил болсныг онцлон тэмдэглэж байна.

Монгол Улсын системийн тэргүүлэх банкны хувьд Голомт банк нь байгууллагын болон иргэд, жижиг дунд банкны харилцагчдад санхүүгийн цогц үйлчилгээг өндөр түвшинд үзүүлэхийг эрмэлзэж ажилладаг билээ. Бид байгууллагын банкны зах зээлд хамгийн хүчирхэг тоглогчийн байр сууриа хадгалсаар ирсэн нь иргэдэд зориулсан банкны үйлчилгээнд ч мөн давамгайлах чухал суурь болж өгсөн юм. Голомт банк орон даяар салбар, тооцооны төвүүдээ өргөжүүлэн иргэдэд зориулсан банкны үйлчилгээнд илүүтэй төвлөрч ажиллалаа. Мөн орон сууцны зээлийн үйлчилгээ, мэргэжлийн зөвлөхийн үйлчилгээг үзүүлж, орон сууцжуулах төсөл хөтөлбөрүүдийг дэмжин санхүүжүүлснээр иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд бодит хувь нэмрээ оруулж байна. Түүнчлэн Кастодиан банкны үйл ажиллагаа болон Голомт Капитал ХХК-ийн хамтын ажиллагаа зэргээр харилцагчдын бүхий л төрлийн санхүүгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилго тавин ажиллаж байна.

Өнгөрсөн онд бид мэдээллийн технологийн хөгжлийг дараагийн шатанд авчрах хөгжүүлэлтүүдээ үргэлжлүүлэн, хиймэл оюун ухаанд суурилсан олон шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг нэвтрүүлсний дүнд "Global Finance" сэтгүүлээс Голомт банканд "Монгол Улсын Шилдэг дижитал банк" шагнал олгосон амжилт ололтоор дүүрэн жил боллоо. Бид бизнесийн үйл ажиллагааны менежментийг илүү үр нөлөөтэй байлгаж, харилцагчдад хэрэглэхэд хялбар, үр дүнтэй байлгахын тулд мэдээлэл технологийн системүүдийг бүхий л түвшинд өргөнөөр ашиглаж байгааг дуулгахад таатай байна.

Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч Голомт банк НҮБ-ын Байгаль орчин, санхүүгийн санаачилгын "Хариуцлагатай банкны зарчмууд"-ын үндэслэгч банкнуудын нэг болсон нь 2019 оны бас нэгэн онцлох үйл явдал байлаа. Монгол Улсад "Ногоон зээл"-ийн санаачилгыг анхлан гаргасан Голомт банк Тогтвортой санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгаль орчинд ээлтэй, нийгэмд хор хөнөөлгүй бүхий л бизнес, бүтээн байгуулалтыг дэмжин, өөрийн үйл ажиллагаагаараа харилцагчид болон нийгэмдээ манлайлан ажиллахаар гарын үсэг зурсан юм.

Дэлхий даяар Covid-19 вирус дэгдсэний улмаас хүн төрөлхтөн томоохон сорилтуудтай нүүр тулах болсныг дурдахгүй өнгөрч боломгүй. Энэхүү цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөг тооцоход хэдий эрт байгаа ч, Голомт банкны хувьд уг сорилтын ард хамтдаа даван гарахын төлөө харилцагчдадаа хамгийн шилдэг үйлчилгээг үзүүлэн, хичээнгүйлэн ажиллахыг зорьж байна.

Голомт банк үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ой 2020 онд тохиож байгаа билээ. Түүхт ойгоо угтан нийт харилцагч, түншүүд болон хувьцаа эзэмшигч нартаа бидний үйл ажиллагааг үргэлж дэмжин хамтран ажилладагт, мөн банкныхаа нийт ажилтнууддаа үргэлжид шаргуу хөдөлмөр, хичээл зүтгэл гарган ажилладагт нь чин сэтгэлээсээ талархал илэрхийлье.

Бидний өмнө зураих уртаас урт он жилүүдэд та бүхэнтэй хамтран ажиллахдаа үргэлж таатай байх болно. Эрхэм харилцагч, түнш, хамтрагчдынхаа хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхолд бүрэн нийцсэн банк санхүүгийн шилдэг, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг цаашид илүү хөгжүүлэн сайжруулж, хамгийн сайн засаглалын тогтолцоо, нээлттэй, ил тод байдлаа бэхжүүлэн ажиллахаа илэрхийлж байна.

Хүндэтгэсэн,



Гүйцэтгэх Захирал
Норихико Като







Удирдлагын баг,
БҮТЭЦ

УДИРДЛАГЫН БАГ 2019

14 ГОЛОМТ
БАНК



Норихико Като

Гүйцэтгэх
захирал



Г.Ганболд

Ерөнхийлөгч



Т.Нямсүрэн

Гүйцэтгэх
захирлын орлогч



М.Сайнбилэг

Мэдээллийн технологи
хариуцсан захирал



Ж.Хишигжаргал

Хөрөнгө оруулалт,
санхүүгийн
байгууллагын
газрын захирал



Х.Пүрэвдорж

Захиргааны
газрын
захирал



Т.Отгон

Эрсдэлийн
удирдлагын
газрын захирал



А.Одонбаатар

Аудит хариуцсан
захирал



С.Мөнхтуяа

Санхүүгийн
удирдлагын
газрын захирал



Б.Баяртбилэг

Зээлийн газрын
захирал



Д.Бадрал

Байгууллагын
банкны газрын
захирал



Ц.Байгалмаа

Иргэд, жижиг
дунд банкны
газрын захирал



М.Наранхуу

Бизнес процесс
менежментийн
газрын захирал



Г.Уянга

Хүний нөөцийн
удирдлагын
газрын захирал



О.Батцэнгэл

Мэдээллийн
технологийн
газрын захирал




Ё.Пүрэвбат

Бүртгэл
тооцооны
газрын захирал

16 ГОЛОМТ
БАНК







Эдийн засаг, БАНКНЫ СЕКТОР

Худалдаа, үйлчилгээ, боловсруулах салбарын борлуулалт өссөн ч худалдааны дайны улмаас түүхий эдийн үнэ буурснаар уул уурхайн салбарын өсөлт бууралттай жил болов. 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр эдийн засаг 5.1 хувиар өслөө.



ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН


ЭДИЙН ЗАСАГ ӨСӨХӨД ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ, БОЛОВСРУУЛАХ САЛБАР ГОЛЛОН НӨЛӨӨЛӨВ

2019 онд Монгол Улсын эдийн засаг 5.1 хувиар өссөн бөгөөд эдийн засгийн өсөлтөд худалдаа, үйлчилгээ, боловсруулах салбар голлон нөлөөллөө. Харин уул уурхайн салбарын хувьд 1 хувиар буурсан нь "Оюу толгой" ХХК-ийн зэсийн баяжмал дахь агууламж багассан, худалдааны дайнаас шалтгаалан түүхий эдийн үнэ буурсантай холбоотой. Бодит секторын өсөлттэй хэдий ч хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчин 3.8 хувиар буурч, шинэ аргачлалаар тооцсон ажилгүйдлийн түвшин 8.1 хувьд хүрэв.

20 ГОЛОМТ
БАНК

	Үзүүлэлт	Нэгж	2018	2019	2019/2018	Нөлөө
Бодит сектор	ДНБ (2010 зэрэгцүүлэх)	Их наяд төг	18.1	19.0	+5.1%	Эерэг
	Ажилгүйдлийн түвшин	%	6.6	8.1	+1.5 p.p.	Сөрөг

ДНБ




ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ 2019 ОНД 8 ХУВИАР БУУРАВ


Төв банкны зүгээс мөнгөний уламжлалт бодлогын арга хэрэгслээс илүүтэй макро зохистой бодлогыг хэрэгжүүлэв. Хэдийгээр бодлогын хүү 11 хувь хэвээр байсан ч хэрэглээний зээлд тавьсан хязгаарлалт нь зээлийн хэт халалтыг багасгаж, улмаар хэрэглээний зээл 2019 онд 8 хувиар буурсан.

	Үзүүлэлт	Нэгж	2018	2019	2019/2018	Нөлөө
Мөнгөний бодлого	Инфляц	%	8.1%	5.2%	-2.9 p.p.	Эерэг
	Мөнгөний нийлүүлэлт	Их наяд төг	19.5	20.8	+6.8%	Эерэг
	Бодлогын хүү	%	11%	11%	-	Нейтраль
	Валютын ханш (MNT/USD)	Төгрөг	2637.3	2727.3	+3.4%	Сөрөг

Ханш



Жилийн инфляц



СОНГУУЛИЙН ЖИЛ ОЙРТОЖ БУЙТАЙ ХОЛБООТОЙГООР 2.1 ИХ НАЯД ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛТАЙ ТӨСӨВ БАТЛАВ

2016 оноос хойш түүхий эдийн үнийн өсөлттэй холбоотой төсвийн орлого өсөж, Олон улсын валютын сан /ОУВС/-ийн хөтөлбөрийн нөлөөгөөр төсвийн сахилга бат харьцангуй сайжирч байсан ба 2018 онд 3 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Гэвч сонгуулийн жил ойртож буйтай холбоотой 2019 онд төсөв 628 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, 2020 онд 2.1 их наяд төгрөгийн алдагдал бүхий төсвийг батлав.


Сангийн бодлого	Засгийн газрын орлого	Тэрбум төг	9,225.9	10,801.6	+17.1 %	Эерэг
	Засгийн газрын зардал	Тэрбум төг	9,222.9	11,429.4	+23.9%	Сөрөг
	Төсвийн тэнцэл	Тэрбум төг	3.0	-627.8	-209.3%	Сөрөг

СААРАЛ ЖАГСААЛТАД ОРСОН, ДАЛД УУРХАЙН САНХҮҮЖИЛТ ХОЙШИЛСОН ЗЭРЭГ НЬ ТӨГРӨГИЙН ХАНШ СУЛРАХАД ХҮРГЭВ


2016 оноос хойш тасралтгүй өсөж байсан түүхий эдийн үнэ худалдааны дайны нөлөөгөөр аажмаар буурч эхэлсэн. Гадаад орчны тодорхой бус байдлын голлох нөлөө нь манай улсын төлбөрийн тэнцэлд нөлөөлж, улмаар валютын ханшаар эдийн засагт нөлөөлдөг. 2019 онд төлбөрийн тэнцэл эерэг гарсан ч саарал жагсаалтад орсон, “Оюу толгой” ХХК-ийн далд уурхайн санхүүжилт хойшилсон зэрэг хүчин зүйлс нь төгрөгийн ханш ам.долларын эсрэг сулрахад хүргэв.

Гадаад сектор	Экспорт	Сая ам.долл	7,011.8	7,055.6	+8.7%	Эерэг
	Импорт	Сая ам.долл	5,875.0	6,127.4	+4.3%	Эерэг
	Худалдааны тэнцэл	Сая ам.долл	1,137.0	1,429.3	+31.3%	Эерэг
	Төлбөрийн тэнцэл	Сая ам.долл	-141.7	452.9	+420%	Эерэг
	Валютын албан нөөц	Сая ам.долл	3,549.1	4,348.6	+22.5%	Эерэг

Гадаадын шууд хөрөнгө оруулалт



Гадаад худалдаа



ЭДИЙН ЗАСАГТ БОЛСОН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

- “Оюу толгой” ХХК-ийн далд уурхайн төсөл 36 сараар хойшилж, нэмэлт 1.9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай болов. (2019.07)
- Монгол Улс саарал жагсаалтад багтав. (2019.10)
- 2.1 их наяд төгрөгийн алдагдал бүхий улсын төсөв батлагдав. (2019.11)

БАНКНЫ СЕКТОРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Банкны секторын нийт актив 2019 онд 35.9 их наяд төгрөгт хүрч, ДНБ-ий 97.3 хувьтай тэнцлээ. 2017 оноос эхэлсэн банкны салбарын реформ 2019 онд ч мөн үргэлжлэв. Тус реформын хүрээнд Монголбанкнаас банкнуудад активын чанарын үнэлгээ хийгдэж, улмаар системийн хэмжээнд банкнууд шат дараатайгаар өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх үүрэг аван ажиллав.

	Нэгж	2018	2019	2019/2018
Банкны актив	Тэрбум төг	33,053	35,859	15%

ЗЭЭЛИЙН ЧАНАРГҮЙДЛИЙН ХУВЬ

Монголбанк иргэдийн хэрэглээний зээлд хязгаарлалт тавьсан нь банкнуудын зүгээс иргэдэд олгож буй хэрэглээний зээлийг бууруулж, бизнесийн зээл өсгөх хөшүүрэг болов. Улмаар нийт зээлийн үлдэгдэл 5.1 хувиар өсч, 18.0 их наяд төгрөгт хүрлээ. Зээлийн багцын чанар 2018 онд активын чанарын үнэлгээтэй холбоотой огцом муудсан ч 2019 онд эргэн сайжирсан. Тухайлбал, чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт 2018 оноос 0.3 нэгж хувиар буурч, 10.1 хувьд хүрээд байна.

Үзүүлэлт	Нэгж	2018	2019	2019/2018
Зээлийн өрийн үлдэгдэл	Тэрбум төг	17,725	18,096	5%
Хэвийн	Тэрбум төг	14,592	15,447	6%
Хугацаа хэтэрсэн	Тэрбум төг	849	824	-3%
Чанаргүй	Тэрбум төг	1,785	1,825	2%
Чанаргүй зээлийн харьцаа	%	10.4%	10.1%	-0.3 p.p.


ЭХ ҮҮСВЭР

Эх үүсвэр талаасаа банкны системийн хадгаламж 10.5 хувиар өсөж, 14.6 их наяд төгрөгтэй тэнцэж байна. Банкны системийн долларжилтаас сэргийлж, Монголбанкны зүгээс валютын заавал байлгах нөөцийн хэмжээг 3 нэгж хувиар өсгөж, 15 хувьд хүргэв.

Үзүүлэлт	Нэгж	2018	2019	2019/2018
Харилцах, төгрөг	Тэрбум төг	3,361	3,302	-2%
Харилцах, валют	Тэрбум төг	2,268	2,324	3%
Хадгаламж, төгрөг	Тэрбум төг	10,156	11,079	9%
Хадгаламж, валют	Тэрбум төг	3,020	3,484	15%
Банкны өөрийн хөрөнгө	Тэрбум төг	3,260	3,031	-7%

- Хэрэглээний зээлийн хязгаарлалт үйлчилж эхлэв. (2019.01)
- Капитал банк дампуурав. (2019.04)
- Валютын заавал байлгах нөөцийг нэмэгдүүлэв. (2019.12)





Санхүүгийн ҮР ДҮН

Голомт банкны нийт актив 6.6 их наяд төгрөгт хүрч, зах зээлийн 18.5 хувийг эзэлж байна. Харилцагчийн эх үүсвэрийн хэмжээгээр тогтвортой өсөлтийг үзүүлж, 4.9 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд нийт зах зээлийн 20 орчим хувийг тогтвортойгоор хадгаллаа.



ГОЛОМТ БАНКНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮН


2019 ОНЫ САНХҮҮГИЙН ГОЛ АМЖИЛТУУД

- Банкны нийт актив 6.6 их наяд төгрөгт хүрч, зах зээлийн 18.5 хувийг эзэлж байна.
- Харилцагчийн эх үүсвэрийн хэмжээгээр тогтвортой өсөлтийг үзүүлж, 4.9 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд нийт зах зээлийн 20 орчим хувийг тогтвортойгоор хадгаллаа.
- Активын чанарын удирдлагыг оновчтой хэрэгжүүлснээр NPL харьцааг 5.4 хувиас 4.3 хувь болгож буурууллаа.
- Банкны 2020 оны үйл ажиллагааны орлого (свопын үнэ цэнийн нөлөө хассан) өнгөрсөн онтой харьцуулахад 8 хувь өсөж, 250 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд цэвэр ашиг 16.3 тэрбум төгрөгт хүрлээ.
- Банк өөрийн хөрөнгийн хэмжээгээ шат дараатайгаар нэмэгдүүлсээр байгаа бөгөөд өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон Монголбанкны бусад шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллаж байна.


БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ

2019 онд Голомт банкны нийт актив 9 хувиар өсөж, 6.6 их наяд төгрөгт хүрсэн бол харилцагчийн эх үүсвэр 11 хувиар өсөж, 4.9 их наяд төгрөгт хүрээд байна. Харилцагчийн эх үүсвэрийн өсөлтийн 70 хувийг байгууллагын эх үүсвэрийн өсөлт, 30 хувийг иргэдийн эх үүсвэрийн өсөлт эзэлж байна.

Нийт актив (тэрбум төг)




Харилцах, хадгаламж (тэрбум төг)




2019 онд цэвэр зээлийн хэмжээ өнгөрсөн онтой харьцуулахад 4 хувиар өсөж, 3.3 их наяд төгрөгт хүрсэн ба зээлийн бүтцээ хадгалж, зээлийн чанарыг сайжруулахад төвлөрч ажилласны үр дүнд чанаргүй зээлийн харьцаа 5.4 хувиас 4.3 хувь болж буурсан.

Мөн банк өөрийн хөрөнгийн хэмжээгээ 5 хувиар нэмэгдүүлж, өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон бусад зохицуулагч байгууллагуудын шаардлагыг ханган ажиллаж байна.

Цэвэр зээл (тэрбум төг)



Өөрийн хөрөнгө (тэрбум төг)




АШИГТ АЖИЛЛАГАА

2019 онд Голомт банкны үйл ажиллагааны орлого (свопын үнэ цэнийн нөлөө хассан) 8 хувиар өссөн бөгөөд энэ нь цэвэр хүүний орлогын өсөлтөөр тайлбарлагдаж байна. Актив пассивын тогтвортой удирдлагын үр дүнд цэвэр хүүгийн ахиуц харьцааг өнгөрсөн оны түвшинд хадгалж чадлаа. Хэдийгээр цэвэр ашгийн хэмжээгээр өмнөх оноос буурсан ч энэ нь эрсдэлээс хамгаалах санг өндөр дүнгээр байгуулсантай холбоотой юм.

Үйл ажиллагааны орлого (тэрбум төг)




Цэвэр хүүгийн ахиуц




ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээлийн төвлөрөл, төлбөрийн чадвар, гадаад валютын эрсдэлтэй холбоотой бүхий л үзүүлэлтээр Монголбанкнаас тавьдаг шалгуурыг бүрэн хангаж ажиллалаа.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ



Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар



ГОЛОМТ БАНКНЫ 5 ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ҮР ДҮН

Үзүүлэлтүүд (сая төгрөг)	2015	2016	2017	2018	2019
Балансын үзүүлэлтүүд (сая төгрөг)					
Нийт актив	3,804,842	4,658,343	5,204,584	6,081,113	6,643,136
Нийт харилцагчийн харилцах, хадгаламж	2,079,801	2,803,328	3,453,920	4,402,648	4,900,642
Зээлээр авсан болон зээлийн эх үүсвэр	1,014,935	1,195,870	757,897	715,853	916,032
Цэвэр зээл	2,013,611	2,034,860	2,318,058	3,183,724	3,306,694
Нийт өөрийн хөрөнгө	428,181	453,707	488,675	605,578	634,505
Орлогын тайлангийн үзүүлэлтүүд (сая төгрөг)					
Хүүгийн орлого	314,830	331,900	409,220	493,961	577,892
Хүүгийн зардал	(213,295)	(246,416)	(287,230)	(323,255)	(366,007)
Цэвэр хүүгийн орлого	101,534	85,484	121,990	170,706	211,885
Цэвэр хүүгийн бус орлого	58,454	63,200	8,615	135,621	81,026
Свопын үнэ цэнийн нөлөө	41,041	22,376	(43,217)	74,551	43,070
Үйл ажиллагааны орлого	159,988	148,684	130,605	306,327	292,911
Үйл ажиллагааны орлого -свопын нөлөө хассан	118,947	126,308	173,822	231,775	249,841
Үйл ажиллагааны зардал	(75,362)	(77,251)	(85,583)	(110,093)	(122,006)
Үйл ажиллагааны ашиг	84,626	71,433	45,021	196,234	170,905
Үйл ажиллагааны ашиг -свопын нөлөө хассан	43,585	49,057	88,238	121,682	127,835
Зээл, санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал, үнэ цэнийн бууралт	(51,900)	(58,686)	(36,947)	(94,034)	(146,010)
Барилга байгууламжийн үнэ цэнийн бууралт			(20,158)	(26,600)	-
Татварын өмнөх ашиг	32,726	12,746	(12,083)	75,600	24,895
Татварын зардал	(6,742)	(7,473)	6,930	(22,054)	(8,590)
Татварын дараах ашиг	25,985	5,274	(5,153)	53,546	16,305
Санхүүгийн бүтцийн харьцаанууд					
Нийт харилцах, хадгаламж / Нийт актив (%)	54.7%	60.2%	66.4%	72.4%	73.8%
Өөрийн хөрөнгө (1-р зэрэглэл)/ Нийт актив (%)	8.3%	6.7%	6.2%	7.2%	6.5%
Цэвэр зээл / Нийт актив (%)	52.9%	43.7%	44.5%	52.4%	49.8%
Ашигт ажиллагааны харьцаанууд					
Дундаж активын өгөөж (%)	0.7%	0.1%	#N/A	1.0%	0.3%
Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж /1-р зэрэг/ (%)	8.7%	1.7%	#N/A	16.1%	3.3%
Цэвэр хүүгийн ахиуц (%)	4.2%	2.8%	3.3%	4.1%	4.1%
Зардал, орлогын харьцаа (%)	47.1%	52.0%	65.5%	35.9%	41.7%
Зардал, орлогын харьцаа -свопын үнэ цэнийн нөлөө хассан (%)	63.4%	61.2%	49.2%	47.5%	48.8%
Шалгуур үзүүлэлтүүд					
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ >12% (2019 оноос өмнө >14%)	16.6%	14.8%	14.4%	15.4%	14.9%
Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлтүүд:					
Нийт гадаад валютын хувьд < +/-30% (2019 оноос өмнө < +/-40%)	12.0%	15.0%	16.3%	4.2%	12.7%
Нэгж гадаад валютын хувьд < +/-15%	10.7%	7.5%	11.8%	1.9%	0.8%
Нэг зээлдэгчид олгосон зээлийн харьцаа <20%	18.2%	18.5%	16.8%	15.3%	15.0%
Холбогдох этгээдэд олгосон зээлийн харьцаа <5%	3.9%	4.6%	4.2%	3.8%	4.4%
Холбогдох этгээдэд олгосон нийт зээлийн харьцаа <20%	17.0%	17.0%	17.9%	16.6%	15.6%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар >25%	38.1%	44.8%	44.5%	36.7%	32.6%
Үндсэн хөрөнгийн харьцаа <8%	4.7%	5.1%	4.8%	3.3%	3.7%

Дижитал шилжилтийг МОНГОЛД

Хэрэглэгчийн зан төлөв, хэрэглээнд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэхэд хялбар болгон, хиймэл оюун ухаанд суурилсан нэмэлт функцуудыг шинээр нэвтрүүлж, өнгө дизайны шинэ шийдлийг хүргэлээ.

”



ДИЖИТАЛ БАНК

Голомт банк харилцагч нартаа зориулан ДИЖИТАЛ БАНК 5.0 үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлээ. Шинэчлэлийн хүрээнд банкны дижитал сувгууд болох Интернэт банк, Смарт банк үйлчилгээний шинэ хувилбарыг харилцагчдадаа хүргээд байна.

Хэрэглэгчийн зан төлөв, хэрэглээнд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний боломжуудыг хэрэглэхэд хялбар болгон шинэчлэхдээ хиймэл оюун ухаанд суурилсан нэмэлт функцуудыг шинээр нэвтрүүлж, өнгө дизайны шинэ шийдлийг хүргэлээ.

Дижитал банкны онцлох өсөлтүүд



ХИЙМЭЛ ОЮУН УХААН, ХАРИЛЦАГЧИЙН ЗАН ТӨЛӨВТ СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

Монголын банкны салбарт анх удаа нэвтрүүлсэн хэрэглэгчийн санхүүг өмнөөс нь хөтлөх ухаалаг хөтөч "Миний санхүү" цэс нь технологид суурилан ажилладгаараа онцлог бөгөөд хамааралгүй орлого зардлыг хасаж, засварлан бодит байдлаар хянах боломжийг харилцагчдад олгосон.

Интернэт банк болон Смарт банк аппликэйшний шинэчлэгдсэн боломжууд



ДИЖИТАЛ ХЭТЭВЧ SOCIALPAY АППЛИКЭЙШН

- Харилцагчид дурын банкны картаа Голомт банкны дижитал хэтэвч **SocialPay** аппликэйшнд бүртгүүлэн төлбөр тооцоондоо шууд ашиглах боломжтой болсон нь банкны салбартаа анхдагч болсон.
- Хэрэглэгч худалдан авалт хийхдээ дижитал хэтэвчээрээ **QR** код ашиглан төлбөр тооцоо хийх боломжийг анхлан нэвтрүүлснээр SocialPay дээрх дурын картыг сонгон төлбөр тооцоогоо хийх боломжтой боллоо.
- Монголын анхны олон улсын эрхтэй **Виртуал картыг** SocialPay аппликэйшнд амжилттай нэвтрүүлснээр харилцагч заавал салбар дээр өөрийн биеэр картаа захиалан авч, төлбөр тооцоондоо ашиглах байдлыг дараагийн шатанд гаргалаа.

Хэрэглэгчдийн хамгийн түгээмэл ашигладаг үйлчилгээнүүд

 Олон улсын нислэгийн билет	 Олон улсын төмөр замын билет	 Монгол орон даяар амралт болон зочид буудал
 Бүх төрлийн үзвэр үйлчилгээний тасалбар	 Бүх кино театруудын үзвэрүүд	 Цаг үеийн трэнд фестивал үзвэр үйлчилгээ

КАРТЫН БҮТЭЭГДЭХҮҮН



The Color card

Техник технологи хурдацтай хөгжихийн хэрээр насанд хүрээгүй ч банкны карт хэрэглэх боломжтой санхүүгийн хэрэгслүүд гарч байгаагийн нэг нь Голомт банкны 10-22 насны хүүхэд залууст зориулсан шинэлэг дизайн, дэвшилтэт NFC технологи бүхий олон улсын эрхтэй THE COLOR Card юм.

Сонгодог карт төрлөө нэмэв

Дансаа, дизайнаа, валютаа сонгодог карт UnionPay төгрөг, юанийн валютаар төрлөө нэмлээ. Visa, MasterCard, Union Pay брэндээр төгрөг, ам.доллар, юанийн валютаас сонгох боломжийг харилцагчдадаа олгосон.

MasterCard, Visa, UnionPay брэндийн картууддаа зайнаас унших NFC технологийг нэвтрүүлэв

Онцлох үр дүн

 Кредит карт зах зээлийн 42%	 Нийт дебит картын тоо 430.000	 Нийт картын гүйлгээний өсөлт 17.5%	 Картаар төлбөр хүлээн авагч байгууллагын ПОС терминалын тоон өсөлт 57.5%
 Өөртөө үйлчлэх банкны загварыг гарган 40 CRM зах зээлд нэвтрүүлэв ATM	 ATM, CDM 351	 1850 ПОС машин нэмэгдэв 1850	 332 сайтад картаар төлбөр төлөх боломжийг бий болгов 332

Шинээр нэвтрүүлсэн үйлчилгээ

- Inflight буюу offline гүйлгээ хийх үйлчилгээг МИАТ ТӨХК-тай хамтран нэвтрүүлэв
- Картаар үйлчлэгч байгууллагуудад дуудлага, хүсэлт, хуулга харах Gmerchant аппликэйшний iOS үйлдлийн системд зориулсан хувилбарыг нэвтрүүлэв
- ПОС-ын орлого барьцаалсан зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэв

Зах зээлд эзлэх амжилт



Картын
брэнд
олгогч
байдлаар

Зах
зээлд
1-р
байр



Кредит
карт

Зах
зээлд
1-р
байр



Дебит
карт

Зах
зээлд
2-р
байр



ПОС,
АТМ
2-р
байр

32 ГОЛОМТ
БАНК

ӨГӨГДЛИЙН ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТ, АНАЛИЗ

Голомт банк дата өгөгдлийн засаглалыг хэрэгжүүлж ажиллахаар Дата удирдлагын хэлтэс байгууллаа. Нэгжийн гол зорилго нь дата анализ, дата майнингийн аргачлалыг нэвтрүүлж, шийдвэр гаргалтыг сайжруулах, стратегийг гаргахад нөлөөлөх, стандартчилсан бодлого засаглалыг хэрэгжүүлж ажиллахад оршино.

Датад суурилсан соёл

Нийт банкны нэгжүүдийн 75% нь ахисан дата анализын үр дүнг ашиглаж байна. Дата анализаар зөвхөн шийдвэр гаргалтад нөлөөлөн сайжруулаад зогсохгүй өгөгдлийн шинжилгээ хийхэд шаардлагатай сүүлийн үеийн техник технологийн шийдлүүдийн талаар мэдлэг олгох сургалт явуулж байна.

Ахисан түвшний анализ ба машин сургалт

Голомт банкны картаар үйлчлэгч байгууллагуудад зориулж хөгжүүлсэн Мерчант платформ нь байгууллагуудад харилцагчдынх нь талаар дэлгэрэнгүй мэдээллийг олгож, цаашдын борлуулалтын таамаглалыг харуулдгаараа онцлогтой.

Мэдээллийн технологийн засаглалын COBIT 5 тогтолцоо хэрэгжүүллээ

Монголд анх удаа Мэдээллийн технологийн засаглалын COBIT 5 тогтолцоог нэвтрүүлж, ISACA-ийн албан ёсны COBIT 5 Assessor байгууллага болох Process Logic-оор баталгаажуулах үнэлгээг амжилттай хийлгэлээ. Ингэснээр банкны Удирдлагын хорооны дэргэд Мэдээллийн технологи ба Дижитал шилжилтийн хороог байгуулж, гол 10 процессын чадамжийн түвшинг нэгээс хоёр хүртэлх түвшингээр сайжруулж, процессын 60 хувийг гуравдугаар түвшинд хүргэлээ.



Иргэд, жижиг дунд

БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ХӨГЖИЛД

Иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчдийн хөгжилд хувь нэмэр оруулан, иргэдийн зах зээл, үл хөдлөх хөрөнгийн зах зээл, харилцагчийн үйлчилгээнд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг нэвтрүүллээ.



ИРГЭД, ЖИЖИГ ДУНД БАНКНЫ БИЗНЕС

2007 оноос хойш нийт 35,598 харилцагчид зээл олгож, 124,600 иргэнийг орон сууцтай болгосон байна. 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харилцагчдын зээл нийт зах зээлийн 24.9 хувийг эзэлж байна.

Иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчдийн хөгжилд

 125,000 ИРГЭН Үндэсний хуримтлалын хөтөлбөрт нэгдэв	 ЗОРИЛТОТ ХАДГАЛАМЖ Олимпын тоглолтыг хуримтлалаараа үзэх зорилтот хадгаламжийн шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэв	 1 МИНУТ Дижитал цалингийн зээлийг анхлан нэвтрүүлэв
 ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН багцыг 2 ДАХИН нэмэгдүүлэв	 4 САЛБАРТ Харилцагч төвтэй шинэ бизнес моделиор өөрчлөн зохион байгуулав	 ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛААР ТЭРГҮҮЛЭГЧ Хөрөнгийн даатгалын зуучлалын үйлчилгээгээр тэргүүлэв
 107 ГУЛДМАЙН бүтээгдэхүүн шинээр нэвтрүүлэн борлуулж эхлэв (Алтан, мөнгөн гулдмай)	 ДИЖИТАЛ СУВГААР авах даатгалын зуучлалын үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэв	
 УТСАН БОРЛУУЛАЛТЫН ТӨВИЙГ банкны үндсэн лавлах төвөөс тусад нь байгуулав. Нийт 10 төрлийн үйлчилгээг 45,000 харилцагчид үзүүлэв	 ТАКСИ ДУУДЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭ UBCab такси дуудлагын үйлчилгээний төлбөрийг SocialPay-ээр төлөх боломжийг нэвтрүүлэв	

ЭВЕНТ БОРЛУУЛАЛТ

Банкны үйлчилгээг харилцагчийн байгаа газарт очиж хүргэх “Шууд борлуулалтын алба” шинээр байгуулав. 40 гаруй зах худалдааны төв, 20 гаруй их дээд сургууль, 32 хамтран ажилладаг байгууллага, Улаанбаатар хотын 50 салбартаа “Happy week” арга хэмжээ, агентийн борлуулалт хийж нийт 117,000 бүтээгдэхүүн үйлчилгээ борлуулав.

NEXT CHAMPIONS 2019

Өөрийн өнгө аяс, бүтээгдэхүүн үйлчилгээ, шинэлэг байдлаараа зах зээлд байр сууриа эзэлсэн томоохон бизнесүүдийн төлөөллүүд өөрсдийн амжилт, туршлага, инновацаас жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хуваалцдаг “Next champions 2019” арга хэмжээг хоёр дахь жилдээ зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 600 гаруй бизнес эрхлэгч оролцож, бага хүүтэй, урт хугацаатай нэмэлт санхүүжилт хийх үйлчилгээ санал болгон ажилласнаараа онцлог болсон.

NEXT CHAMPIONS
POWERED BY GOLOMT BANK | FORUM '19



БИЗНЕС ФОРУМ

Орон нутгийн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, банкны үйлчилгээг илүү ойртуулах зорилготой Бизнес форумыг Орхон аймаг, Баян-Өлгий аймаг, Өмнөговь аймагт зохион байгуулав. 750 гаруй бизнес эрхлэгчийг хамруулсан тус арга хэмжээгээр нийгэм эдийн засгийн шинэ мэдлэг мэдээлэл хүргэхээс гадна, байгууллагын дотоод менежмент, хүний нөөц, санхүүгийн удирдлагыг оновчтой, үр ашигтай хийх зөвлөмж, мэдлэгийг хүргэв. Мөн орон нутгийн зах зээл, бизнестэй танилцаж нэмэлт санхүүжилт, банкны үйлчилгээний уян хатан нөхцөлийг газар дээр нь олгож ажилласан нь банкны үйлчилгээг орон нутгийн бизнес эрхлэгчдэд улам ойртуулсан арга хэмжээ боллоо.



ЖИЛИЙН
ТАЙЛАН 2019

35

НӨХӨРСӨГ ХӨЛБӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН

Монгол Улсад суух Дипломат төлөөлөгчийн газар хоорондын жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг нөхөрсөг хөлбөмбөгийн тэмцээнийг 10 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээн нь банкны төдийгүй Монгол Улсын гадаад харилцаа, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болдог ба энэ удаад 16 багийн 250 тамирчид, 500 гаруй хөгжөөн дэмжигч оролцлоо.



PROJECT FORUM 2019

“FEPDI-Үл хөдлөх хөрөнгийн төсөл хэрэгжүүлэгчдийн институт” зохион байгуулсан үл хөдлөх хөрөнгийн төсөл хэрэгжүүлэгчдийн анхдугаар чуулган “Project Forum 2019” арга хэмжээнд санхүүгийн түнш, хамтран зохион байгуулагч байгууллагаар оролцлоо.

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2007 оноос хойш нийт 35,598 харилцагчид 1.92 их наяд төгрөгийн зээл олгосноос 124,600 иргэнийг орон сууцтай болгосон байна.

2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харилцагчдын зээл нийт зах зээлийн 24.9 хувийг эзэлж байна.

360° үнэлгээ

Зах зээл дэх үл хөдлөх хөрөнгийн төслүүдийн өрсөлдөх чадварын үнэлгээг тогтоох, сайн төслүүдийг илрүүлж, тэдэнтэй хамтын ажиллагааг бий болгон өргөжүүлэх, төслүүдийн онцлогт тохирох бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх суурь судалгаа болох зорилготой 360° үнэлгээг 2018 оны 09 сараас нэвтрүүлж эхэлснээс хойш 15 сарын хугацаанд 43 төсөлд үнэлгээ хийсэн.


ҮХХЗЗ-ийн улирлын судалгаа

360° үнэлгээ хийхэд шаардлагатай баазыг бүрдүүлэх, банкны хэмжээнд орон сууцны оффисийн, амины орон сууцны чиглэлүүдэд жишиг үнийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэдэг ҮХХЗЗ улирлын судалгаа тогтмолжиж, дата баазын бүрдүүлэлт амжилттай хийгдсэнээр орон сууц 100 хувь, оффис 95 хувь, амины орон сууцны дата бүрдүүлэлт тус тус 95 хувь болж, банкны олон улсын аудитын байгууллагын шаардлагын дагуу барьцаа хөрөнгийн үнэлгээ гаргаж өгөх ажилд томоохон дэмжлэг үзүүлсэн.

Luxlife event 2019

Нийслэлийн өндөр зэрэглэлийн орон сууцны төслүүдийг зорилтот сегментийн харилцагчдад танилцуулах, өндөр зэрэглэлийн сайн төслүүдтэй хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, төслүүдээр дамжуулан өндөр сегментийн харилцагчдад өөрийн эх үүсвэрийн зээл олгох зорилго бүхий уг арга хэмжээнд ҮХХЗЗ дээрх хамгийн нэр хүндтэй, өндөр зэрэглэлийн шинэ 10 төсөл оролцож, 2500 гаруй VIP харилцагч оролцсоноор төслүүдээс бодит борлуулалтууд хийгдсэн.

Орон сууцны зээлийн багц - Зах зээлд эхлэх хувь (тэрбум.төг)



Homeland Орон сууцны төв

Өндөр зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгийн зах зээл дээрх гол тоглогч болж тухайн сегментэд харгалзах харилцагчдыг төвлөрсөн цогц бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ дамжуулан татах, нэмэгдүүлэх, түргэн шуурхай төвлөрсөн үйлчилгээг зорилтот харилцагчдад хүргэхэд чиглэн ажилладаг Homeland орон сууцны төв 7 сарын хугацаанд 95 харилцагчийн 12.6 тэрбум төгрөгийн моргейжийн зээл гаргасны 96 хувь нь өөрийн эх үүсвэрийн зээл байгаа нь банкны системийн хэмжээнд нэгдүгээрт бичигдэж байна.



Өөрийн эх үүсвэрийн орон сууцны зээлийн өсөлт



Өөрийн эх үүсвэрийн орон сууцны зээлийн багц

295 тэрбум төгрөгт хүрсэн



Нийт орон сууцны зээлийн 71 хувь буюу

250 тэрбум төгрөгийн зээлийг олгосон



Арилжааны банкнуудын олгосон орон сууцны зээлийн

25% эзэлж байна

ХАРИЛЦАГЧИЙН ДУУ ХООЛОЙ

Харилцагчийн үйлчилгээний төв нь харилцагчийн дуу хоолойг дэлхийн хаанаас ч 24/7 цагаар хүлээн авч, чанар стандартыг баримтлан ажиллаж байна.

2019 онд харилцагч хүссэн газраасаа холбогдож, мэдээлэл үйлчилгээ авах сувгийг өргөжүүлэн 9 сувгийн үйлчилгээ үзүүлдэг боллоо.

2019 онд Харилцагчийн дуу хоолойн хэлтэст 1,014,710 харилцагч хандсан.

- Лавлах төвд утсаар 754,117 харилцагч хандсанаас 93.86 хувьд нь нэг удаагийн хандалтаар үйлчилж асуудлыг нь шийдвэрлэсэн.
- Нийт амжилттай дуудлага 3.18 хувиар өссөн.
- Автомат хариулагчид 114,723 харилцагч хандан мэдээлэл авсан.
- Цахим сувагт хандсан 145,870 харилцагчтай 54 секундын дотор холбоо тогтоон асуудлыг нь шийдвэрлэсэн.

Банкны хэмжээнд бүртгэгдэж буй нийт гомдлын тоо буурлаа



2019 онд ХДХУА-д бүртгэгдсэн гомдол

11%



Мэдээлэл технологийн гэмтэл журам батлагдсанаар масс гомдол

41%



Газар нэгжүүдэд бүртгэгдэж буй гомдол

94%



Масс гэмтэл

21%



Харилцагчийн гомдол шийдвэрлэсэн хугацаа

1:39 Цаг



Салбар тооцооны төвүүдийн гомдол

11%



Системийн тасалдлын цаг

122.7 цагаар тус тус буурсан

ЖИЛИЙН
ТАЙЛАН 2019

37

Харилцагчийн үйлчилгээний төвд харилцагч халамжлах үйлчилгээг тогтмолжууллаа

Дахин холбогдолт үүсгэсэн, үйлчилгээгээ бүрэн авалгүй дуудлага тасарсан, холбогдож чадаагүй харилцагчтай эргэн холбогдож халамжлах үйлчилгээг тогтмолжуулсан.

Амжилттай дуудлагаас дахин холбогдолтын эзлэх хувь 23.73 хувь байсан бол дахин холбогдолтын дундаж үзүүлэлт 12.89 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Дахин холбогдолт үүсгэх эрсдэлээс сэргийлэх, 1 стандартаар харилцагчдад мэдээлэл өгөх зорилгоор Харилцагчийн үйлчилгээний төвийн суваг бүрийн 98 үйлчилгээ тус бүр дээр ярианы алхам боловсруулж, ТОП хандалтын үйлчилгээний алхмыг гаргаж ажиллалаа.

Хүчирхэг бизнесийг МОНГОЛД

Байгууллагын
эх үүсвэрийн
багц 54.7 хувиар
буюу 600 тэрбум
төгрөгөөр өсөж,
1.7 их наяд
төгрөгт хүрэв.
Зээл олголт 2.1
их наяд төгрөгт
хүрч, системийн
20.5 хувийг эзэлж
байна.



БАЙГУУЛЛАГЫН БАНКНЫ БИЗНЕС

Байгууллагын эх үүсвэрийн багц 54.7 хувиар буюу 600 тэрбум төгрөгөөр өсөж, 1.7 их наяд төгрөгт хүрэв. Зээл олголт 2.1 их наяд төгрөгт хүрч, системийн 20.5 хувийг эзэлж байна.

Байгууллагын банкны өсөлт, үр дүн



Эх
үүсвэрийн
багц
54.7%↑

1.7
их наяд
төгрөг



Зээл олголт
системийн
20.5%



Хүүгийн
орлого
18.6%↑

130
тэрбум
төгрөг



Хүүгийн
бус
орлого
72.4%↑

11
тэрбум
төгрөг

40 ГОЛОМТ
БАНК

Санхүүжүүлэлт



7 тэрбум
үнэ бүхий эм
боловсруулах (+50%)



15 нэр төрлийн
432 тонн
сүүн бүтээгдэхүүн



6'400 тонн
хаягдал дахин
боловсруулах



51 сая
өндөгний савлагаа
автоматжуулалт

Нийт 82 байгууллагад 1,2 их наяд төгрөгийн баталгаа гаргасан

ХАРИЛЦАГЧИЙН АРГА ХЭМЖЭЭ

Financial Management Convention 2019

Монголын томоохон бизнесийн байгууллагын 500 шилдэг санхүүчдийг хамарсан FMC Санхүүгийн Форум арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.



Алтны форум 2019

2019 онд Голомт банкны зохион байгуулсан Алтны форумд ашигт малтмалын салбарын бизнес эрхлэгч, алт олборлогч томоохон компаниудын төлөөлөл бүхий 150 гаруй зочид төлөөлөгч оролцсон.



Motivation club

Топ аж ахуйн нэгжийн удирдлагыг хамруулсан "Motivation Club" спортлог арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.



Нэг бүс Нэг зам

Голомт банк Гадаад Харилцааны яам, Bank of China-ийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газартай хамтран "Нэг бүс Нэг зам" арга хэмжээг Монгол Улсад хэрэгжиж буй төслүүд, түүний гүйцэтгэгч Хятадын Төрийн өмчит компаниудын дунд амжилттай зохион байгууллаа.

САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

Барилгын салбарт

Барилгын 3 төсөлд 230 тэрбум төгрөгийн санхүүжилт хийснээр нийт 1550 айлын өндөр зэрэглэлийн орон сууц бий болов.

- Sky Garden, Garden City, Бара Тэнгэрийн Ам зэрэг шинэлэг шийдэлтэй томоохон барилгын төслүүдийг санхүүжүүлэн ажиллав.



Дэд бүтцийн салбарт

- М Си Эс Интернэйшнл ХХК нь Голомт банкны баталгааг үндэслэн “Сайншанд салхин парк” 55МВт-н төслийн дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр ажилласан. 100 мянган айл өрхийн цахилгаан хэрэглээг хангах чадалтай уг станц 2019 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр эрчим хүчний сүлжээнд холбогдон ашиглалтад орсон.
- М Си Эс Интернэйшнл ХХК болон Япон улсын Mitsubishi Hitachi Power Systems компанитай хамтарсан консорциум Улаанбаатар хотын ДЦС-4 ТӨХК-ийн үр ашгийг дээшлүүлэх төслийг Голомт банкны баталгааг үндэслэн амжилттай хэрэгжүүллээ. Төслийн нийт өртөг 4,2 тэрбум иен буюу төгрөгөөр 105 тэрбум төгрөг юм.
- М Си Эс Интернэйшнл ХХК болон Шарп корпорацийн хамтарсан консорциум Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдахаар төлөвлөгдөж буй “Замын-Үүд Гэгээн” 15 МВт-ын нарны цахилгаан станц”-ын төслийг Нарантээг компанитай гэрээ байгуулан хэрэгжүүлж байна. Дээрх төсөлд Голомт банк банкны зарим үйлчилгээгээр хамтарсан.
- М Си Эс Интернэйшнл ХХК-ийн гүйцэтгэсэн Хөшигийн хөндийн “Бөхөг” 15 МВт нарны цахилгаан станц нь Монгол Улсын хоёр дахь том нарны станц болж байна. Дээрх төсөлд Голомт банк зарим бүтээгдэхүүнээр хамтарсан.
- Вайтфиникс ХХК нь Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 14, 18, 19-р хороо, СБД-ийн 13, 14-р хорооны нийт 2234 өрхийг цэвэр, бохир, дулааны шугам, дэд бүтцээр хангах төслийн гүйцэтгэгчээр ажиллаж байгаа ба уг төслийн банкны баталгаа болон эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэд Голомт банк хамтран ажилласан.

42 ГОЛОМТ
БАНК



Худалдаа, Үйлчилгээний салбарт

2000 гаруй шинэ ажлын байр бий болгох боломж олгосон.

- ХУД-т шинээр нээгдсэн “И-Март 3” сүлжээ дэлгүүр төслийг санхүүжүүлэв.
- Ажил хэрэгч хотын хэв маягт тохирсон “CU конвениенс” сүлжээ дэлгүүрт санхүүжилт олгов.
- Дэлхийн томоохон конвениенс сүлжээ дэлгүүр болох Circle К-ийн Монгол дахь албан ёсны франчайз эрхийг Circle К ХХК 2017 онд авсан бөгөөд улмаар Circle chain ХХК франчайз эрхийн дагуу 2019 онд нээж, Голомт банк хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлж ажиллав.

- Харилцаа холбооны салбарын томоохон төлөөлөл Юнител компани Голомт банкны санхүүжилтээр үйл ажиллагаагаа өргөжүүлэн 2019 оны хагас жилийн байдлаар нийт идэвхтэй хэрэглэгчдийн тоо нь 35 хувь болж өссөн ба энэ нь өмнөх оны мөн үеэс 3 хувиар өссөн үзүүлэлт юм.
- Мөнхийн Үсэг группийн хэрэгжүүлж буй байгаль орчинд ээлтэй, хаягдал цаас цуглуулж, дахин боловсруулсан цаасан хайрцаг үйлдвэрлэх “Эко Цаас” төслийн санхүүжилтийг олгосон.



ЖИЛИЙН
ТАЙЛАН 2019

43

Үйлдвэрлэлийн салбарт

Үйлдвэрлэлийн салбарт нийт 5 төсөлд санхүүжилт олгосон

- Монос фарм ХХК-ийн GMP үйлдвэрт дахин санхүүжилтийн зээлийг олгосон.
- Тэсо Корпорацийн салбар компани болох Милко ХХК-д сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийг өргөтгөх, шинэ төрлийн бүтээгдэхүүн гаргаж экспортлох, малчид фермерүүдээс сүү худалдан авалтыг дэмжих зорилгоор хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн зээлийн санхүүжилт олгосон.
- Ханбогд Кашимер ХХК-ийн жилд 100,000 ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх шинэ сүлжмэлийн үйлдвэрт санхүүжилт олгон хамтран ажиллав.
- Түмэн Шувуут ХК-д өндөг боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн урт хугацаат санхүүжилтийг шийдвэрлэсэн. Улмаар импортыг орлуулж, дотоодын үйлдвэрлэгчийн өндөгний нийлүүлэлтийн тоо, чанарт сайжруулалт бий болох боломжтой болсон.



Уул уурхайн салбарт

5 төсөлд 130 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноор 225МВт –ын хүчин чадлыг нэмэгдүүлж 30'000 Айлын дулааныг хангах боломжийг бүрдүүлсэн.

- М Си Эс Проперти ХХК-ийн Голомт банкны санхүүжилтээр хийж хэрэгжүүлж буй “Оюу толгойн гүний уурхайн чухал байгууламж” төсөл нь Азийн Барилгын инженерүүдийн зохицуулах зөвлөлийн гүйцэтгэх хорооны “Civil Engineering Project Award” номинацид 2019 оны шилдэг төслөөр шалгарлаа. Дээрх шагналыг Монгол Улсаас анх удаа тус компани авснаараа онцлогтой.
- М Си Эс Интернэйшнл ХХК нь Голомт банкны баталгаа, санхүүжилтийг авснаар тус сайт дээр байрлах 58МВт-ын хүчин чадал бүхий дулааны станцыг өргөжүүлэн 72 МВт болгож, амжилттай хүлээлгэж өглөө.
- "Оюу толгой" төслийн туслан гүйцэтгэгч "Премиум Групп" ХХК тогтвортой үйл ажиллагааг хангахад санхүүжилтийг олголоо. "Премиум Групп" ХХК нь "Оюу толгой" төсөл дээр 2.1 сая хүн цаг аюул осолгүй ажилласан амжилтанд хүрсэн.
- Монгол Улсад анх удаа ХБНГУ-ын Sennebogen Maschinenfabrik үйлдвэрийн 875R маркын нүүрс ачигчийг Голомт банк ХБНГУ-ын Euler HERMES даатгалтай Commerzbank AG-ийн урт хугацаатай зээлээр санхүүжүүлэв. Уг нүүрс ачигч нь байгаль орчинд ээлтэй, орчны тоосжилт үүсгэхгүй, түлшийг 80 хувь үр ашигтай зарцуулах өндөр бүтээмжтэй цоо шинэ технологийг дотоодын уул уурхайн салбарт нэвтрүүлсэн.



Агаарын тээврийн салбарт

Голомт банк агаарын тээвэрт санхүүжилт олгосноор жилд 12'000 хүн, 1'000 тонн ачаа тээвэрлэх боломжтой болов

- Грандмед эмнэлгийн түргэн тусламжийн зориулалтаар ашиглах нисдэг тэрэгний /АНУ-аас/ санхүүжилтийг зохицуулсан.
- МИАТ-ийн Wings Aviation LLC-ийн BOING737300EB төрлийн онгоцны түрээсийн төлбөрт зориулан Stand by LC-г гаргав.
- Хүннү Эйр ХХК-ийн шинэ Embraer-190 маркын хөлөг онгоцны санхүүжилтэд оролцов.



IPO төслийн хүрээнд Түмэн шувууд, Монос хүнс IPO хийж 21.4 тэрбум төгрөг татан төвлөрүүлж 115%-иар давж биелүүлэв

- МОНОС ХҮНС ХХК-ийн 6.8 тэрбум төгрөгийн санхүүжилттэй IPO төслийг амжилттай босгов.
- Түмэн Шувуут ХХК-ийн IPO дээр хамтран ажиллаж, нийт 10 тэрбум төгрөгийн санхүүжилт босгов.





Валютын ЗАХ ЗЭЭЛД

Голомт банк сүүлийн 3 жилийн хугацаанд Монгол Улсын гадаад валютын нөөцийг бүрдүүлэхэд өөрсдийн хувь нэмрээ оруулан тэргүүлэгч банкны үүргээ нэр төртэйгээр биелүүллээ.



АРИЛЖАА, ХӨРӨНГИЙН МЕНЕЖМЕНТ

Дотоод арилжаа

2019 онд банк валютын зах зээл дээрх валют арилжаа болон харилцагчдаа ханшийн эрсдэлээс хамгаалах чиглэлээр идэвхтэй ажиллаж, зах зээлд эзлэх хувиа 30 хувьд хадгаллаа. Үүний сацуу Монголбанкны валютын цахим арилжааны системд улирал бүр үндсэн дилерээр сонгогдож, банк хоорондын валютын захыг амжилттайгаар идэвхжүүлэн ажиллав. Тайлант онд валют арилжааны эргэлт өмнөх онтой харьцуулахад 14 хувиар өссөн бөгөөд дотоодын зах зээл дээрх тэргүүлэгч байр сууриа улам бататгалаа. Мөн банк хоорондын зах зээл дээр ханшийн эрсдэлээс хамгаалах санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг амжилттайгаар борлуулан, найдвартай түншийн харилцаагаа зузаатган ажиллалаа.

Гадаад арилжаа

2019 онд Голомт банк нийт зах зээлийн 65 хувь буюу 8.46 тонн цэвэр алтыг худалдан аваад байна. Ийнхүү сүүлийн 3 жилийн хугацаанд уг зах зээлд тэргүүлэгч байр сууриа хадгалж Монгол Улсын гадаад валютын нөөцийг бүрдүүлэхэд өөрсдийн хувь нэмрээ оруулан тэргүүлэгч банкны үүргээ нэр төртэйгээр биелүүллээ. Өнгөрсөн гурван жилийн хугацаанд бид харилцагчдад хамгийн ая тухтай, эрсдэлгүй, түргэн шуурхай, мэргэжлийн үйлчилгээгээр хангаж Монголын алтны зах зээлд үйлчилгээний шинэ стандартыг тогтоож чадлаа.

Биет алтны арилжаа



Алт худалдан
авалт
Зах
зээлийн

65%

Гибрид хадгаламж

Олон улсын хөрөнгийн зах зээлд арилжаалагдаж буй хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнтэй холбосон гибрид хадгаламжийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлээд дөрвөн жилийн хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд бүтээгдэхүүний нөхцөлийг дөрвөн удаа шинэчлэн сайжруулсны үр дүнд 2020 онд алтны гибрид хадгаламжийн хүү 2 дахин өсөөд байна. Мөн хувьцааны ханштай уясан гибрид хадгаламжийн дээд хүү 40 хувьд хүрсэн бол алтны хадгаламжийн хүү 30 хувьд хүрчээ. Ийнхүү бид харилцагчдын хөрөнгийг гадаад зах зээлд хөрөнгө оруулах байдлаар өсгөх дэлхийн жишиг хөрөнгийн удирдлагын үйлчилгээгээ үзүүлсээр байна.

Гибрид хадгаламжийн хүү 7 сарын дотор 29.7 хувиар өсөв.

Мэдээлэл судалгаа

Голомт банк нь харилцагчдаа олон улсын зах зээлийн арилжаа, хөрөнгө оруулалтанд идэвхтэй оролцуулж гадаад зах зээлээс ашиг олох боломжийг бүрдүүлэх зорилгоор зах зээлийн мэдээлэл, дүн шинжилгээг тогтмол хугацаатайгаар бэлтгэн ажилладаг. Үүнд түүхий эд, валют, хувьцаа болон макро эдийн засгийн судалгаанууд багтаж байна.

Global Investor хөтөлбөр

Уг хөтөлбөрийг Нөөцийн удирдлагын газрын санаачилгаар 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдөр эхлүүлсэн бөгөөд олон улсын санхүүгийн зах зээлээс ашиг олохыг зорьж буй харилцагчдын мэдээлэл, мэдлэгийг нэмэгдүүлэх, олон улсын зах зээлээс хэрхэн ашиг олох гарцыг таниулах зорилготой юм.

Хөтөлбөрийн хүрээнд 2019 оны 05 дугаар сарын 03-нд Global Investor арга хэмжээг харилцагчдад зориулан зохион байгуулж нийт 200 гаруй харилцагчид хөрөнгө оруулалтын боломжууд, гибрид хадгаламж, амжилтын кейсийг танилцуулсан.



ЖИЛИЙН
ТАЙЛАН 2019

49

Сургалт

Мэргэжлийн шинжээчдийн бодит туршлагыг суурь ба техник шинжилгээтэй хослуулснаараа онцлогтой тус сургалтаар суралцагч бүр 2 сая орчим төгрөгөөр Хятадын Industrial and Commercial Bank of China (ICBC) болон Industrial and Commercial Bank of China (CCB)-ны банкны хувьцааны ханштай уясан гибрид хадгаламжийг нэг жилийн хугацаатай хийснээрээ дэлхийн санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийж бодит үр дүн, арилжааны мэдрэмжийг авснаараа онцлогтой. ICBC банкны ханш 5.00 хонконг доллараас эхэлсэн бол CCB-ийн ханш 5.75 хонконг долларын ханштай эхэлсэн. Энэ хугацаанд ICBC-ийн ханш 5.92 хонконг долларт хүрсэн бол CCB-ийн ханш 6.61 хонконг долларт хүрч тус бүр харгалзан 18.4 хувь болон 14.9 хувь өссөн байна.





Гадаад харилцаа, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД

2019 онд олон улсын нэр хүнд бүхий 29 харилцагч банкаар
дамжуулан харилцагчдын гадаад төлбөр тооцоог түргэн шуурхай
саадгүй гүйцэтгэх боломжийг бүрдүүллээ.



ОЛОН УЛСЫН БИЗНЕС ХАРИЛЦАА

ГАДААД ЭХ ҮҮСВЭР, ЗЭЭЛИЙН ШУГАМУУД

Гадаад худалдааны санхүүжилтийн уян хатан боломжуудыг харилцагчдадаа санал болгох зорилгоор 2019 онд Голомт банк олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа тэлж, санхүүжилт болон зээлийн шугамуудаа нэмэгдүүлэн ажиллалаа. Энэхүү ажлын хүрээнд ОХУ-ын IBEC, IIB, Transkapital, Хятад улсын Bank of Inner Mongolia, ABOC, АНУ-ын USDA, Cargill, Герман улсын Oddo BHF, Нидерланд улсын ING болон Турк улсын Aktif зэрэг банкнуудын баталгаа, зээлийн шугамуудыг нийт 65 сая ам. доллараар тус тус нэмэгдүүллээ.

КОРРЕСПОНДЕНТ БАНКНЫ ХАРИЛЦАА

Голомт банк нь 2019 онд олон улсын нэр хүнд бүхий 29 харилцагч банкаар дамжуулан харилцагчдын гадаад төлбөр тооцоог түргэн шуурхай саадгүй гүйцэтгэх боломжийг бүрдүүлэн ажиллалаа. Мөн шинээр Сингапур улсын OCBC банк болон ОХУ-ын Transkapitalbank банкнуудад SGD, USD, EUR, RUB валютын корреспондент данснуудыг тус тус шинээр нээж гадаад төлбөр тооцооны тогтвортой байдлыг хангаж ажилласны зэрэгцээ Transkapitalbank-тай бэлэн зузаатгал болон валют арилжааны чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгууллаа.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Голомт банк нь 2019 онд Монгол дахь Япон улсын бизнес консулд гишүүнээр элсэж хоёр улсын бизнес эрхлэгч байгууллагуудаа дэмжин ажиллахаар боллоо.
- Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Монгол, Орос, Хятад улсын банкнуудын дугуй ширээний уулзалт 2019 онд Москва болон Шанхай хотуудад тус тус зохион байгуулагдсан бөгөөд системийн чухал банкны хувьд туршлага солилцон амжилттай оролцлоо.
- Харилцагчдынхаа бизнесийг дэмжих зорилгоор Голомт банк БНХАУ-ын Bank of Inner Mongolia банктai хамтран хоёр банкны барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй харилцагч байгууллагуудын бизнес уулзалтыг Хөх хотод зохион байгуулж харилцан туршлага солилцох боломжийг бүрдүүллээ.
- Голомт банк нь олон улсын хамтын ажиллагаагаа улам өргөжүүлж Беларусь улсын Belagroprombank-тай Гадаад худалдааны санхүүжилтийн хүрээнд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.



Гадаад харилцаа хамтын ажиллагаатай банк санхүүгийн байгууллагууд



ЖИЛИЙН
ТАЙЛАН 2019 53

Олон улсын байгууллага дахь гишүүнчлэл



Корреспондент банкнуудын жагсаалт

БАНКНЫ НЭР	МӨНГӨН ДЭВСГЭРТ	СВИФТ КОД	ДАНСНЫ ДУГААР
KOOKMIN BANK, Korea	USD	CZNBKRSE	819-8-USD-0-15
OCBC BANK, Singapore		OCBCSGSG	503-474157-301
SBER BANK, Russia (Moscow)		SABRRUMM	301-11840100000000840
KEB HANA, Korea		KOEXKRSE	963-THR-313-01-2
SHINHAN BANK, Korea		SHBKKRSE	0102245USD01
BANK OF CHINA, China (Erlian)		BKCHCNBJ880	155-605293946
BAOSHANG BANK, China (Baotou)		BTCBCNB	002-105599800020
CHINA CONSTRUCTION BANK, China (Erlian)		PCBCCBNJNME	NRA15014150500220100181
ICBC BANK, China (Huhhot)		ICBKCNBJNMA	061-0040629200061234
BANK OF INNER MONGOLIA, China (Huhhot)		HSSYCNBH	115-914236000000184
CHINA CITIC BANK, China (Huhhot)		CIBKCNBJ010	727-1111486000000181
BERLINER SPARKASSE, Germany (Berlin)		BELADEBE	10050000/3270000250
BANK OF CHINA, Hong Kong		BKCHHKHH	012-87560121220
VTB BANK, Russia		VTBRRUMM	301-11840155550000104
TRANSKAPITALBANK, Russia		TJSCRUMM	301-11840000000000210
RUSSIAN AGRICULTURAL BANK, Russia	EUR	RUAGRUMM	301-11840300000000006
DBS Bank, Singapore		DBSSSGSG	0710-000182-01-5
COMMERZBANK, Germany		COBADEFF	400 878 506 501
RAIFFEISEN BANK, Austria		RZBAATWW	1-55 076 335
BERLINER SPARKASSE, Germany		BELADEBE	10050000/6630008373
TRANSKAPITALBANK, Russia	CNY	TJSCRUMM	301-11978600000000210
AGRICULTURAL BANK OF CHINA China (Huhhot)		ABOCCNB050	059-99901040000053
BANK OF CHINA, China (Erlian)		BKCHCNBJ880	154-005293944
CHINA CONSTRUCTION BANK, China (Erlian)		PCBCCBNJNME	150-01658408052502177
BAOSHANG BANK, China (Baotou)		BTCBCNB	002-105599800010
ICBC BANK, China (Huhhot)		ICBKCNBJNMA	061-0040609200054391
BANK OF INNER MONGOLIA, China (Huhhot)		HSSYCNBH	115-901236000000122
BANK OF COMMUNICATIONS, China (Huhhot)		COMMCNSHHHH	151-899991010003021570
CHINA CITIC BANK, China (Huhhot)		CIBKCNBJ010	727-1110186000000155
BANK OF CHINA, Hong Kong	JPY	BKCHHKHH	012-87560118495
MIZUHO, Japan		MHCBJPJT	6740010
SMBC, Japan		SMBCJPJT	4374
MUFG Bank, Japan	RUB	BOTKJPJT	653-0432881
VTB BANK, Russia		VTBRRUMM	301-11810655550000126
SBER BANK, Russia (Irkutsk)		SABRRU66	301-11810618000000001
SBER BANK, Russia (Moscow)		SABR RUM 012	301-11810800000000840
RUSSIAN AGRICULTURAL BANK, Russia		RUAGRUMM	301-11810200000000013
TRANSKAPITALBANK, Russia	GBP	TJSCRUMM	301-11810700000000210
COMMERZBANK, Germany		COBADEFF	400 878 506 500
COMMERZBANK, Germany	CHF	COBADEFF	400 878 506 500
KOOKMIN BANK, Korea	KRW	CZNBKRSE	819-8-KRW-0-17
KEB HANA, Korea		KOEXKRSE	0963FRW001000054
SHINHAN BANK, Korea		SHBKKRSE	0102245KRW01
OCBC, Singapore	SGD	OCBCSGSG	713-470888-001
ANZ, Australia	AUD	ANZBAU3M	920660AUD00001
COMMERZBANK, Germany	CAD	COBADEFF	400 878 506 500
OCBC BANK, Singapore	HKD	OCBCSGSG	503-257156-201
BANK OF CHINA, Hongkong		BKCHHKHH	012-875-60115674
mBANK, Poland	PLN	BREXPLPW	IBAN: PL 52 114 000 000 000 114 851 001 001

ГАДААД ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТ

Гадаад худалдааны санхүүжилтийн хувь



Импортын
аккредитивийн
зах
зээлийн **30%**



Гадаад
баталгааны
зах
зээлийн **29%**
эээлж
байна



Монгол Улсын худалдааны
хамгийн том түнш
улс болох БНХАУ руу нээгдэж
буй нийт аккредитивийн

50%
Голомт банк
гүйцэтгэв

Япон, Солонгос, Турк, Дани, Герман, Чех, Польш, Испани, Итали зэрэг орнуудын бараа, бүтээгдэхүүний худалдан авалтыг аккредитив, гадаад баталгааны үйлчилгээгээр дамжуулан гүйцэтгэсэн нь харилцагч байгууллагуудын гадаад худалдааны бараа эргэлтийг сайжруулах, санхүүжилтийн өртгийг бууруулахад дэмжлэг үзүүлэв.

Гадаадын түнш банкнуудтай хамтран 187 тэрбум төгрөгийн дүн бүхий импортын барааны худалдан авалтуудыг санхүүжүүлэв

- International Investment Bank, International Bank for Economic Cooperation олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, 106 тэрбум төгрөг бүхий импортын бараа бүтээгдэхүүн, франчайзингийн үйлчилгээг хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэхэд хамтран ажиллав.
- Commerzbank AG, ING bank, ODDO BHF AG, SMBC, Atlantic Forfaitierungs AG, Transkapitalbank болон БНХАУ-ын ICBC, Baoshang, Bank of Inner Mongolia банкнуудтай хамтран барилгын түүхий эд материал, автомашин, тоног төхөөрөмж, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний импортыг USD, EUR, CNY, JPY валютуудаар санхүүжүүлэв.

ХБНГУ-ын экспортын санхүүжилтийн агентлагийн даатгалтай, урт хугацаат санхүүжилтийг хийж гүйцэтгэв

ХБНГУ-ын EULER HERMES-ийн даатгалын хүрээнд байгальд ээлтэй уул уурхайн тоног төхөөрөмжийг дотоодын уул уурхайн салбарт нэвтрүүлэхэд Commerzbank AG-тай хамтран ажиллав.

Хятадын түнш банкнуудтай хамтран ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортыг амжилттай санхүүжүүллээ

- БНХАУ-ын банктай байгуулсан 100 сая юанийн, хөнгөлөлттэй нөхцөлтэй санхүүжилтийн гэрээний хүрээнд нүүрсний экспортыг санхүүжүүллээ.
- Түүхий эд худалдан авах, боловсруулах үйл ажиллагаа, экспортын гаалийн бүрдүүлэлтэд зориулан экспортын өмнөх санхүүжилт, нийлүүлэлт, тээвэрлэлт, зар сурталчилгаанд зориулан экспортын дараах санхүүжилтийн зээлийг олгох нөхцөлтэй хамтын ажиллагааны гэрээг гадаадын нэр хүндтэй банкнуудтай байгуулсан.
- Гадаадын нэр хүндтэй банкнуудын баталгааг үндэслэн 24.5 тэрбум төгрөгийн дүн бүхий дотоод баталгааны үйлчилгээ үзүүлэв.
- Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт оролцогч гадаадын аж ахуй нэгж байгууллагуудад зориулан гадаадын банкны баталгааг үндэслэн тендер болон гүйцэтгэлтийн баталгаа нээх үйлчилгээг түргэн, шуурхай хийж гүйцэтгэв.

ЖИЛИЙН
ТАЙЛАН 2019 **55**

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН САНХҮҮЖИЛТ



Голомт Банк уур амьсгал, тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр болов.

Голомт Банк нь НҮБ-ын Хариуцлагатай банкны зарчмуудыг санаачлан боловсруулсан анхдагч 28 банкны нэг бөгөөд Ази Номхон далайн бүсийн орнуудын банкнуудын төлөөлөгчөөр сонгогдон бүс нутгийнхаа банкнуудыг уг санаачилгад нэгдэхийг уриалан ажиллаж байна.

56 ГОЛОМТ
БАНК

Монголын хөдөө аж ахуйн салбарыг дэмжихээр Голомт банк нь Монгол Улсын Хөгжлийн Банкны “Ноолуур хөтөлбөр 2019”, Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэй “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” хөтөлбөрүүдтэй амжилттай хамтран ажиллаж байна.

Монгол Улсын Хөгжлийн Банктай “Ноолуур хөтөлбөр 2019”-ийн хүрээнд хамтран ажиллаж, 42 тэрбум төгрөгийн санхүүжилтийг ноолуурын аж ахуй эрхлэгчдэд дамжуулан олгосон. Тус хөтөлбөрийн үр дүнд нийт 866 тн ноолуурын түүхийг эд бэлтгэж, 1,205 ажлын байрыг хадгалж, 107 байнгын ажлын байрыг бий болгоод байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй хөдөө аж ахуйн салбарыг дэмжих төсөлтэй Голомт банк 4 дэх жилдээ хамтран ажиллаж, 2019 онд 12 тэрбум төгрөгийн зээл олгож, эдгээр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэгч тэргүүлэх банк болов.

Голомт Банк Нидерландын Hands-On B.V сантай хамтран жижиг, дунд бизнесийг дэмжих цахим санхүүжилтийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна.

Голомт банк Нидерландын Hands-On B.V сантай хамтран жижиг дунд бизнесийг дэмжих цахим санхүүжилтийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд финтек шийдлийг ашиглан сангийн цахим платформоор 2019 онд нийт 4.5 тэрбум төгрөгийн зээлийг бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгож 50 гаруй ажлын байр шинээр бий болгоод байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн “Ажлын байр нэмэгдүүлэх төсөл”-ийг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газартай хамтран 2017-2019 онуудад амжилттай хэрэгжүүлж дууслаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эх үүсвэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтийг дэмжих, болон ажлын байр бий болгох зорилгоор малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэн, аж ахуй нэгжүүдэд зээл олгох үйл ажиллагааг Голомт банк 2017-2019 онуудад амжилттай хэрэгжүүлэв. Төслийн хүрээнд 20 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1,784 иргэн, аж ахуй нэгжүүдэд олгож, 4,406 ажлын байрыг хадгалж, 3,811 ажлын байрыг шинээр бий болгоход Голомт банк хувь нэмрээ оруулав.

“Хариуцлагатай Банкны Зарчмууд Танилцуулга Форум”-ыг анх удаа зохион байгууллаа

Голомт Банк нь Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоотой хамтран “Хариуцлагатай Банкны Зарчмууд Танилцуулга Форум”-ыг анх удаа зохион байгуулж эдгээр зарчмуудын зорилго болон тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө зэргийг бүс нутгийнхаа банк санхүүгийн байгууллагуудад танилцуулах зорилгоор, мөн бусад банк, санхүүгийн салбарын оролцогчдыг Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг дэмжиж ажиллахыг уриаллаа.







Ажилчдынхаа ур чадварыг САЙЖРУУЛАХАД

Нийт ажилтнуудынхаа ур чадварыг сайжруулах, байгууллагын соёлоо бэхжүүлэх, ажилтнуудынхаа нийгмийн асуудал, эрүүл мэнд, идэвх оролцоог нэмэгдүүлэх, сурч хөгжих боломжоор хангах, оюутан сурагчидтай хамтран ажиллах чиглэлээр олон төрлийн хөтөлбөр, арга хэмжээнүүдийг санаачлан хэрэгжүүллээ.



ХҮНИЙ НӨӨЦ

Голомт банк 2019 оны байдлаар нийт 2400 гаруй ажилтантай болсноос 85 гаруй хувийг 35-аас доош насны Y, Z generation залуус бүрдүүлж байна. Энэ онд бид Хүний нөөцийн бодлогоо шинэчлэн батлуулж, хөдөлмөрийн харилцаа, сонгон шалгаруулалт, сургалт хөгжил, Ерөнхий боловсролын болон Их дээд сургуулиудтай хамтран ажиллах, ажилтны гүйцэтгэлийн үнэлгээ, шагнал урамшуулал, цаг бүртгэл, ажилтны ур чадвар зэрэг Хүний нөөцийн бодлогын баримт бичгүүдээ дахин шинэчлэн сайжрууллаа.

Нийт ажилтнуудынхаа ур чадварыг сайжруулах, байгууллагын соёлоо бэхжүүлэх, ажилтнуудынхаа нийгмийн асуудал, эрүүл мэнд, идэвх оролцоог нэмэгдүүлэх, сурч хөгжих боломжоор хангах, оюутан сурагчидтай хамтран ажиллах чиглэлээр олон төрлийн хөтөлбөр, арга хэмжээнүүдийг санаачлан хэрэгжүүлсэн.

Их дээд сургуулиудын хамтын ажиллагаа

2019 онд шинээр их дээд сургууль төгссөн 200 гаруй оюутныг ажлын байраар хангаж, МУИС-Бизнесийн сургууль, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, Мандах Их Сургуультай хамтран ажиллаж байна.

Шагнал урамшуулал

Банкны 2400 гаруй ажилтнаас ажил үүргээрээ бусдыгаа манлайлсан дараах ажилтнуудыг шагнаж урамшууллаа.

- Голомт банк нь 2017 оноос эхэлсэн Шилдгийн шилдэг буюу “Од” ажилтнуудаа шалгаруулдаг уламжлалтай. 2019 онд бусдыгаа онцгой манлайлсан Сентрал Тауэр салбарын захирал Г.Содчимэгт 2 өрөө шинэ орон сууц, Байгууллагын Банкны Газар-Уул уурхай, дэд бүтцийн хэлтсийн Ахлах корпорэйт менежер Б.Сугар-Эрдэнийг Renault Arkana автомашинаар тус тус шагнаж урамшууллаа.



- Шилдгээр шалгарсан 10 ажилтнаа мөнгөн шагналаар урамшуулж, үр бүтээлтэй ажиллаж буй 20 гаруй ажилтнаа мөн шалгаруулан Гадаадад аялах эрхээр, 25 ажилтныг АНЭУлсын Дубай хотод 7 хоногийн хугацаанд аялах амрахаар шагнасан.

АЖИЛТАНД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ажилтнуудын эрүүл мэндийн хөтөлбөр

2019 онд ажилтнуудынхаа эрүүл мэндийг өдөр тутамд хянан заавар зөвлөгөө өгөх, үзлэг шинжилгээ хийх Анагаах ухааны магистр зэрэгтэй их эмчтэй болсноор төвийн нэгж болон бүх салбар тооцооны төвүүдэд биечлэн очиж, оффисын ажилтнуудад тулгардаг асуудлуудаар сургалт орж, 700 гаруй ажилтан хамрагдлаа. Сард 1-2 удаагийн эрүүл мэндийн зөвлөмжийг цахим хэлбэрээр бэлтгэн явуулж байна.

Ажилтны хөнгөлөлт хангамжийн багц

Ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор хөнгөлөлттэй үнээр үйлчлэх спорт чөлөөт цаг, эмнэлгийн үйлчилгээ, худалдаа үйлчилгээ, сургалтын чиглэлийн нийт 25 байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Спорт арга хэмжээ

Голомт банкны дэргэдэх Спорт хамтлаг нь жилд дунджаар 15 орчим тэмцээн, уралдаан, спортын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, дэмжиж ажилладаг. Голомт банк нь жил бүр уламжлал болгон бүх ажилтнуудыг хамарсан цасны баяр, адал явдалт спорт явган аяллыг 23 дахь жилдээ амжилттай зохион байгуулаад байна.

G-mommy's event арга хэмжээ

Жирэмсний амралттай буюу хүүхдээ асарч буй ажилтнууддаа зориулан G-Mommy's event арга хэмжээг Голомт банкнаас зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нийт 90 гаруй жирэмсний амралттай байгаа ажилтнууд оролцсон. Арга хэмжээний гол зорилго нь нэг талаас хүүхдээ асарч буй ээжүүдийг хөгжүүлэх, мэдээ мэдээлэл өгөх, өөр хоорондоо мэдлэгээ хуваалцаж уулзахад оршдог.



Goodvibes 2.0

Хүний Нөөцийн Удирдлагын Газраас 2018 оноос эхлэн ажилтнуудынхаа хүүхдүүдрүү чиглэсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба энэхүү хөтөлбөр эхэлснээс хойш 50 гаруй хүүхэд хамрагдаад байна. Хөтөлбөрийн гол зорилго нь ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, ажилтнуудын хүүхдүүдийн зуны амралтыг зөв боловсон өнгөрүүлэхэд туслахад оршино. 2019 оны хувьд нийт 6 сарын хугацаанд 9 төрлийн сургалт зохиогдсон ба ажилтнуудын 30 хүүхэд идэвхтэй хамрагдаж, батламжаа гардан авсан.

Ахмадын баяр

Голомт банканд тогтвор суурьшилтай, өндөр бүтээмжтэй ажиллаж байгаад өндөр насны амралтаа авсан нийт ахмад ажилтнууддаа зориулан жилд 2 удаа буюу Цагаан сар, Ахмадын баяраар хүлээн авалт зохион байгуулан ажиллаж байна.

62 ГОЛОМТ
БАНК

Сургалт хөгжил

	Гадаад сургалт		Оролцогчдын тоо	141		Гадны сургалт		Оролцогчдын тоо	1,295
	Дотоод сургалт		Оролцогчдын тоо	2,547		Дижитал сургалт		Оролцогчдын тоо	1,283
	НИЙТ		Оролцогчдын тоо	5,266					

Салбар тооцооны төвийн ажилтнуудыг бэлтгэх сургалтын хөтөлбөрүүд

Голомт банк Салбар тооцооны төвийн ажилтнууддаа дотооддоо тусгай хөтөлбөрийн дагуу бэлтгэдэг бөгөөд 2019 онд салбар тооцооны төвийн Теллер, Банкир, Харилцааны менежер, Хянагч нягтлан бодогч зэрэг бэлтгэх сургалтууддаа цогцоор нь онол практик хосолсон аргачлалаар шинэчиллээ. Ингэснээр шинээр бэлтгэгдэж буй ажилтнууд танхимын сургалтаар олж авсан мэдлэгээ практик дээр туршиж, ажлын байранд шаардлагатай мэргэжлийн ур чадварын мэдлэгээ бие даан суралцах боломжийг бий болгосноороо онцлогтой юм.

Шинэ ажилтны чиглүүлэх хөтөлбөр

Голомтын гэр бүлд шинээр нэгдсэн шинэ ажилтнууддаа зориулж банкны үнэт зүйлс, соёлд дасан зохицуулах, шинэ ажилтны бүтээмжийг дэмжих зорилго бүхий 90 хоногийн чиглүүлэх хөтөлбөрийг шинээр боловсруулан зохион байгуулж эхэллээ.

Удирдах ажилтны хөгжлийн хөтөлбөр

Шинээр томилогдсон удирдах ажилтнуудынхаа удирдах ур чадварыг хөгжүүлэх сургалтуудыг шат дараатайгаар хэрэгжүүлдэг бөгөөд удирдах ажилтнуудад хүний нөөцийн удирдлагын суурь ойлголт өгөх “Non HR manager” сургалт болон удирдах ур чадвар хөгжүүлэх “People management” хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлж 38 удирдах ажилтан хамрагдлаа.

Дотоод сургагч багшийн хөтөлбөр

Дотоод сургагч багш нараа чадавхижуулах ажлын хүрээнд 53 сургагч багш нарыг дотоод бэлтгэх болон гадны хөгжүүлэх хөтөлбөрүүдэд хамруулав.



Ажилтнуудыг хөгжүүлэх хөтөлбөр

- Ажилтны тасралтгүй хөгжлийн хүрээнд "Knowledge sharing" сургалтыг шинээр санаачлан 4 удаа амжилттай зохион байгуулж 74 ажилтан хамрагдлаа.
- Ажилтнуудын англи хэлний мэдлэгийг сайжруулах ажлын хүрээнд Faro Edu-тэй хамтарсан хөтөлбөрт 40 ажилтнаа хамруулав.
- Борлуулалтын ажилтнуудын мэргэжлийн болон ерөнхий ур чадварыг хөгжүүлэх "Pro sales 2019" уралдааны хүрээнд 8 удаагийн сургалтад 121 ажилтан 1365 хүн/цагийн сургалтыг зохион байгуулав.
- Ажилтнуудын тасралтгүй хөгжүүлэх ажлын хүрээнд "Миний хөтөч" дижитал сургалтын платформыг хөгжүүлж 234 сургалтын контентийг боловсруулан ажилтнууддаа хүргэж нийт 1283 ажилтан хамрагдлаа.



Нийгмийн САЙН САЙХАНД

Хариуцлагатай банкны
зарчмуудын стратегийн
түвшний хүрээнд тогтвортой
хөгжил, нийгмийн сайн
сайхны төлөө, уур амьсгалын
өөрчлөлтийн эсрэг тасралтгүй
хувь нэмэр оруулан ажиллахаа
мэдэгдлээ.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

ХАРИУЦЛАГАТАЙ БАНКНЫ ЗАРЧМУУДЫГ ҮНДЭСЛЭГЧ БАНКНУУДЫН НЭГ БОЛЛОО

Голомт банк 2019 оны 9 сарын 22-ны өдөр Нью Йорк хотноо “Хариуцлагатай банкны зарчмууд”-ыг үндэслэгч банкнуудын нэг болж, өөрийн үйл ажиллагааг “Тогтвортой хөгжлийн зорилтууд” болон “Парисын гэрээний уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг зорилтуудтай” уялдуулахаа тунхаглалаа.

Голомт Банк нь “Хариуцлагатай банкны зарчмууд”-д албан ёсоор гарын үсэг зурснаар 47 их наяд долларын хөрөнгөтэй дэлхийн 130 банкнаас бүрдсэн банкны холбоонд нэгдэж тогтвортой ирээдүйг бий болгоход үнэтэй хувь нэмэр оруулах зорилтоо бататгасан юм.

Хариуцлагатай банкны зарчмуудын стратегийн түвшний хүрээнд Голомт банк тогтвортой хөгжил, нийгмийн сайн сайхны төлөө, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тасралтгүй хувь нэмэр оруулан ажиллахаа мэдэгдлээ.



ГОЛОМТ БАНКНЫ НЭРЭМЖИТ ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙГ 15 ДАХЬ ЖИЛДЭЭ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

- “Судлаач оюутан-2019” хөтөлбөрт хамрагдсан 24 оюутнаас шилдэг 8 оюутанд бүтэн жилийн сургалтын тэтгэлэг
- 2020 оны “Судлаач оюутны хөтөлбөр”-т хамрагдах эрхийн бичгээр шилдэг 7 оюутанг тус тус шалгаруулсан.

Үндэсний хэмжээний тэтгэлэгт хөтөлбөрийг анхлан санаачлан хэрэгжүүлсэн Голомт банк жил бүр 100 шилдэг оюутныг тодруулж, тэтгэлэг олгохоос гадна банкны судлаач оюутны багт ажиллах, цаашлаад тус банкны үндсэн ажилтан болох давуу талыг олгосоор ирсэн.



МОНГОЛ УЛСЫН МОРИН ХУУРЫН ЧУУЛГЫН АЛБАН ЁСНЫ ТҮНШЭЭР АЖИЛЛАЖ БАЙНА

Үндэсний язгуур урлагийг түгээн дэлгэрүүлэх, дэлхий дахинд сурталчлах зорилгоор Голомт банк нь Монгол Улсын Морин хуурын чуулгын албан ёсны түнш, Ерөнхий ивээн тэтгэгчээр 7 дахь жилдээ ажиллаж байна. Мөн Монголын сонгодог урлагийг түгээх, сурталчлах зорилгоор Дуурь бүжгийн эрдмийн театрт жил бүр дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.



ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛД ЗОРИУЛСАН НЭВТРҮҮЛЭГ, ХӨТӨЛБӨРИЙГ БЭЛТГЭН ХҮРГЭЛЭЭ

Эдийн засгийн мэдлэг мэдээлэл, хувь хүний болон өрхийн санхүүгийн хэрэгцээг хэрхэн шийдвэрлэх талаарх цогц мэдлэгийг олгох зорилгоор “98,9 Бизнес радио”-тай хамтран “Таны санхүүгийн боловсролд” нэвтрүүлгийг бэлтгэн хүргэж байна.

МОНГОЛЫН АНХНЫ ИРГЭНИЙ НОМЫН САНГИЙН ЕРӨНХИЙ ИВЭЭН ИТГЭГЧЭЭР АЖИЛЛАВ

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 17 хороонд иргэний номын сангийн анхны загварыг ашиглалтад оруулж, Монголд нутагшуулах, олон улсын жишгээр хөгжүүлэх ажлыг “Хүүхдийн Оюуны Боловсролыг дэмжих Төв” ТББ, “Beyond books” төслийн багтай хамтран ажиллаж, Ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллав. Тус номын сан ашиглалтад орсноор Чингэлтэй дүүргийн 5434 хүүхэд ая тухтай орчинд чөлөөт цагаа өнгөрөөн, хараа хяналтгүй байдлаасаа болж төрөл бүрийн осол, гэмт хэрэгт өртөх эрсдэл буурч, номын сангийн хөтөлбөрүүдээр дамжуулан хичээлийн хоцрогдлоо арилгах, бүтээлч сэтгэлгээ, авьяас чадвараа хөгжүүлэх боломж бүрдэж байна.

68 ГОЛОМТ
БАНК



Эрсдэлээс ХАМГААЛАХАД

Төвлөрлийн эрсдэлийг бууруулах үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд зээлийн багцын эрсдэл өндөртэй томоохон зээлүүдийг бууруулж байгууллага болон иргэдийн зээлийн багцын оновчтой бүтцийг бий болголоо.



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Голомт банкны зээлийн эрсдэлийн удирдлага нь банкны зээлийн үйл ажиллагаанаас үүсч болох зээл чанаргүйдэх болон зээлийн багцын төвлөрлийн эрсдэлийг оновчтой түвшинд барихад чиглэгддэг.

Голомт банк нь зээлийн үйл ажиллагаандаа зохицуулагч байгууллагаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллахын зэрэгцээ зээлийн эрсдэлийг тооцох аргачлалуудыг улам баяжуулж зан төлөвийн скоринг, урьдчилсан скорингийг шинээр боловсрууллаа. Түүнчлэн барьцаа хөрөнгийн үнэлгээний загварыг Олон улсын үнэлгээний стандартад (IVS) нийцүүллээ.

Төвлөрлийн эрсдэлийг бууруулах үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд зээлийн багцын эрсдэл өндөртэй томоохон зээлүүдийг бууруулж байгууллага болон иргэдийн зээлийн багцын оновчтой бүтцийг бий болголоо. Цаашид эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон Базелийн хорооны зөвлөмжүүдийн хэрэгжилтийг улам сайжруулж ажиллахаар төлөвлөж байна.

Зээлийн эрсдэлийн удирдлагын соёл

Үр ашигтай зээлийн эрсдэлийн удирдлага нь зээлийн эрсдэлийн зохистой соёлыг бий болгохыг шаарддаг. Банкны зээлийн эрсдэлийн аппетит болон зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь энэхүү соёлыг бий болгох чухал элементүүд болдог.

Зээлийн эрсдэлийн удирдлагын аппетит, эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Банк стратеги, бизнесийн үйл ажиллагаандаа хүлээн зөвшөөрөх эрсдэлийн төрөл, түвшинг зээлийн эрсдэлийн аппетит гэнэ. Зээлийн эрсдэлийг удирдах зарчим, хэм хэмжээг тодорхойлсон бодлого, журмууд, зээлийн эрсдэлийг удирдах, хянах арга хэрэгслүүд болон зээлийн үйл ажиллагаанд оролцогч банкны ажилтнууд бүгд зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлдэг.

Зээлийн эрсдэлийн удирдах арга зүй

Банк зээлийн эрсдэлийн удирдлагын арга, хэрэгслийг зээлдэгчийн болон зээлийн багцын гэсэн 2 түвшинд боловсруулж хэрэгжүүлдэг. Зээлдэгч бүрийн эрсдэлийг удирдах аргачлал хөгжүүлэх болон банкны өдөр тутмын зээлийн үйл ажиллагааны процессыг нэг бүрчлэн тодорхойлох, оновчтой зохион байгуулах чиг үүргийг Зээлийн Газар хариуцдаг. Тус газраас 2019 онд харилцагчийн мэдээллийн санд тулгуурлан корпорейт зээлдэгчдийн рейтинг тогтоох аргачлалыг, SME (бичил, жижиг) зээлдэгчийг зэрэглэх модель, скорингийг, Ритейл зээлдэгчийн application болон зан төлөвийн скорингийг тус тус хөгжүүллээ. Үүнээс гадна орчин үеийн дэвшилтэд технологи дээр суурилсан Machine learning зээлийн скоринг, alternative зээлийн скоринг, collection зээлийн скоринг зэргийг боловсруулан туршиж байна.

Эрсдэлийн удирдлагын газар нь зээлийн багцын түвшинд эрсдэлийг үнэлэх аргачлалыг хөгжүүлдэг бөгөөд 2019 онд зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцоход ашигладаг байсан алдагдалд



суурилсан (зээлийн түүхэн эрсдэлийн параметрууд болох: PD, LGD, LIP) загварын оронд ирээдүйг таамагласан хүлээгдэж буй алдагдлыг тооцох загварыг (макро эдийн засгийн индикатрууд, түүний таамаглал, шилжилтийн матриц, зээлийн stage-ийг нэмж оруулсан) улам боловсронгуй болголоо.

Төвлөрлийн эрсдэлийг удирдах

Зохистой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд зээлийн эрсдэлийг тараан байршуулсан багц бүрдүүлэхийг эрмэлзэж, хувь хүн болон холбоотой этгээдүүдэд их хэмжээний зээл олгохоос зайлсхийж зээл олгох хязгаарлалтуудыг тогтоодог. Эдгээр нь:

- Нэг этгээдийн төвлөрлийн хязгаарлалт
- ТОП20, ТОП40 зээлдэгчдийн төвлөрлийн хязгаарлалт
- Эдийн засгийн салбарын хязгаарлалт
- Зээлдэгчийн сегментийн хязгаарлалт
- Зээлийн бүтээгдэхүүний төвлөрлийн хязгаарлалт

Зээлийн стресс тест

Зээлийн стресс тестийг Монголын Улсын эдийн засагт голлох нөлөөтэй валютын ханш, түүхий эдийн үнэ болон барилга, уул уурхай зэрэг томоохон салбаруудын гүйцэтгэл зэргээр олон хувилбарт сценари шинжилгээ боловсруулж, төсөөлөл дээр үндэслэн банкны зээлийн багцын төлөвлөгөөнд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх нөөц хувилбар боловсруулж, гүйцэтгэлийг тогтмол эргэн хянадаг.

Зээлийн хяналт, мониторинг

Зээлийн хяналтыг зээлдэгчийн болон зээлийн багцын гэж 2 ангилдаг ба зээл нэг бүрийн хувьд банкны салбар, нэгжүүд зээл олгогдсоноос хойш 2 төрлийн хяналтыг гүйцэтгэдэг.

Зээлийн зарцуулалтын хяналт

Энэ төрлийн хяналт нь зээлдэгч банканд урьдчилан танилцуулсан зориулалтын дагуу зээлийг ашигласан эсэхийг тодорхойлоход чиглэгдэнэ.

Зээлийн явцын хяналт

Уг хяналт зээлийн олгосон дүнгээс хамаарч зайны болон газар дээрх гэж ангилагдах бөгөөд зээлдэгчийн зээлжих зэрэглэл, watch list, бүтэц өөрчлөгдсөн зээл эсэхээс хамааран явцын хяналт хийх давтамж ялгаатай байдаг.

Зээлийн газрын Мониторингийн хэлтэс нь салбар нэгжүүдийн зээлийн эргэн хяналт хэрхэн хэрэгжиж буйг газар дээрх болон түүврийн аргаар тогтмол мониторинг хийдэг. Зээлийн эргэн хяналтаас гадна тус нэгж дараах хяналтуудыг тодорхой давтамжтайгаар хэрэгжүүлдэг. Үүнд:

- Судалгаа, шийдвэр гаргалтын гүйцэтгэл, чанарын хяналтыг улирал бүр
- Хэрэг бүртгэл, эргэн хяналт, өр цуглуулах процессын хяналтыг сар бүр хийж, гүйцэтгэлийг хэмжиж, хагас жил тутамд Зээлийн хороонд танилцуулж чиглэл авдаг.

Эрсдэлийн удирдлагын газар зээлийн багцын чанарын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд зээлийн багцыг зээлдэгчийн сегмент, зээлийн бүтээгдэхүүн, зээлийн засгийн салбар, зээлдэгчийн нас, хүйс зэрэг маш олон үзүүлэлтээр ангилж зээлийн багцыг хараат бусаар шинжилж сар бүр Зээлийн хороонд, улирал бүр Эрсдэлийн удирдлагын хороонд тайлагнадаг.



Тусгай активын удирдлага

Банк хэвийн бизнесийн харилцаагаар төлүүлэх боломжгүй, мэргэшсэн өр барагдуулагчдыг ажиллуулан төлүүлэх шаардлагатай чанаргүй зээл, түүнтэй адилтгах активыг барагдуулж банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлэхийн тулд Эрсдэлийн удирдлагын газрын Тусгай активын хэлтсийн мэргэшсэн баг ажиллаж байна.

Барьцаа хөрөнгийн бодлого

Банкны барьцаа хөрөнгийн бодлогын дагуу зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив болон бусад хүлээж болзошгүй үүрэгт зээлдэгч болон гуравдагч этгээдээс үүргийн гүйцэтгэлийг хангуулах баталгаа болгож барьцаа авдаг. Барьцааны төрөл, онцлогоос хамаарч хөрөнгийн үнэлгээний арга зүй / Зах зээлийн хандалт буюу харьцуулалтын арга, Өртөгийн арга болон бусад аргууд/ болон үнэлгээний загваруудыг үнэлгээндээ ашиглахаас гадна хөрөнгийн үнэлгээ хийж буй үнэлгээчдийн хараат бус байдал, баримтлах ёс зүй болон Үнэлгээний Олон Улсын Стандартын (IVS) дагуух бусад шаардлагуудыг хангасан барьцаа хөрөнгийн цогц бодлогыг хэрэгжүүлж байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлт санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнэ, ирээдүйн мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлж байгаа эрсдэл юм. Хүү, валютын ханш, хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлт эсвэл зах зээлийн ямар нэгэн хөдөлгөөнөөс хамаарч банкны нээлттэй байгаа позицод зах зээлийн эрсдэл нэмэгддэг.

Зах зээлийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилтуудын нэг нь банкны бизнесийн стратегид тусгасан эрсдэлийн аппетитын хүрээнд хөрөнгийн удирдлагын бизнесийг хараат бусаар нийцүүлэн ажиллуулах юм. Энэхүү зорилтод хүрэхийн тулд Зах зээлийн удирдлагын хэлтэс нь хөрөнгийн удирдлагын бизнес нэгж болон бусад дэмжих нэгжүүдтэйгээ нягт хамтран ажилладаг билээ.

Тайлант хугацаанд санхүүгийн зах зээлд валютын ханш, хувьцаа, түүхий эдийн үнийн хэлбэлзэл зэрэг эрсдэлүүд тулгарсан ч банк зах зээлийн эрсдэлийн удирдлагын оновчтой бодлого хэрэгжүүлснээр болзошгүй алдагдлаас хамгаалж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам бэхжүүлэн ажиллалаа.

ХӨРВӨХ ЧАДВАРЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь бэлэн мөнгө эсвэл бусад хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөөр санхүүгийн өр төлбөрийг гүйцэтгэхэд хүндрэл үүсэх эрсдэл юм.

Тайлант хугацаанд банкны бизнес төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу банк богино болон урт хугацаанд өндөр хөрвөх чадвар бүхий позицыг барих бодлогыг амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа. Банкны хөрвөх чадвар 2019 оны туршид зохицуулагч байгууллагаас тогтоосон шаардлага болон банкны өөрийн эрсдэлийн аппетитуудаас хангалттай өндөр түвшинд байлаа. Базелийн хорооноос тогтоосон стандартын дагуу банк богино хугацааны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор хөрвөх чадварын хүрэлцээтэй байдлын харьцаа (LCR), дунд урт хугацааны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцааг (NSFR) тогтмол ашиглаж ажиллалаа.

Банкны хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг улам сайжруулах, учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор банкны дотоод бодлого, журам, аргачлал, хүндрэлийн үеийн төлөвлөгөөг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүллээ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь банкны дотоод үйл ажиллагаа, системүүдийн хяналтын хангалтгүй байдал, гадаад орчны таагүй нөлөөлөл болон хүний хүчин зүйлээс шалтгаалан эрсдэлийн зохистой түвшинг хангаж чадахгүй болохыг хэлнэ.

Тайлант хугацаанд банкны нэгжүүдийн үйл ажиллагааны эрсдэлийг үр дүнтэй удирдах, хянах зорилгоор “Эрсдэл хяналтын өөрийн үнэлгээний аргачлал”-аар нэгжүүдийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлон бууруулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж ажиллаа. Эрсдэлийн түлхүүр үзүүлэлт (key risk indicator)-үүдийг эрсдэл эзэмшигч нэгжүүд хэрхэн хянаж, эрсдэлийн удирдлагыг оновчтой зохион байгуулсан байдлыг үнэлж дүгнэлээ.

Гадаад хүчин зүйлээс хамаарсан мэдээллийн технологийн эрсдэлийн үр дүнтэй зохистой удирдлагын хүрээнд нийлүүлэгчийг ангилах, хянах, гүйцэтгэлийн чанарыг үнэлэх эрсдэлийн үнэлгээний арга аргачлалыг Мэдээллийн технологийн газартай хамтран сайжруулав.

Банкны хэмжээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж, төслийн үйл ажиллагаанаас үүсч болох эрсдэлийг бууруулах, процесст суурилсан эрсдэлийн үнэлгээнүүдийг тухай бүр хийж зөвлөмж чиглэл өгөн ажиллаж байна.

Мөн ажилтан бүрийн эрсдэлд хандах хандлагыг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх ажлуудыг танхимын болон онлайн сургалтуудаар дамжуулан хэрэгжүүлж байна.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА

- Голомт банк нь Дэлхийн жишиг Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бий болгохыг зорин ажиллаж байгаа ба Олон улсын нэр хүнд бүхий Мэдээллийн аюулгүй байдлын ISO27001, Төлбөрийн картын аюулгүй байдлын PCI-DSS стандартуудыг хангаж, үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлэн сертификатаа гардан авсан. Мөн хувь хүний өгөгдөл хамгааллын хуулийн хэрэгжилтийг хангах, өгөгдөл хамгааллын процессыг бий болгохоор GDPR буюу Европын холбооны хувь хүний өгөгдөл хамгаалах тухай хуулийн шаардлагыг амжилттай хэрэгжүүлж, баталгаажуулах аудитыг хийлгэн сертификат авсан.



ISO 27001 болон PCI DSS стандартуудын баталгаажуулах аудит 2019 оны эхний хагас жилд амжилттай хийгдэж дууссан.

- Голомт банкны Мэдээллийн аюулгүй байдлын хөндлөнгийн аудитыг олон улсын мэдээллийн аюулгүй байдлын тэргүүлэх үйлчилгээ үзүүлэгч Thales eSecurity компаниар Мэдээллийн аюулгүй байдлын хүн, технологи, процессдоо аудит хийлгүүлсэн.
- Кибер халдлагатай тэмцэхийн тулд аюулгүй байдлын мэргэжилтнүүд байнга шинэ технологи, шийдлүүдээс суралцаж, дадлага сургуулилт хийх нь чухал байдаг. Энэхүү сургуулилтын нэг хэсэг болсон “Fortinet Cyber Range 2019” тэмцээн 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдөр RedRock Conference Center & Resort-д амжилттай болж өндөрлөлөө. Тус тэмцээнийг Fortinet болон



Ай Ти Зон компаниуд хамтран зохион байгуулж, Монголын топ компаниуд болох Оюу толгой, Хаан Банк, Хас Банк, Голомт Банк, Юнител, Үндэсний Дата Төв, Төрийн Банк, Богд Банк зэрэг байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын экспертүүд оролцлоо. Тэмцээний гүйцэтгэлийн үр дүн нь Real-Time дашбоард дээр шууд дамжуулагдсан бөгөөд тэмцээний ялагчаар Голомт Банкны Мэдээллийн аюулгүй байдлын "Guardian" баг шалгаран багаараа Хонг-Конг улсад зохион байгуулагдах "Fortinet 361° Security Forum 2019"-д оролцох эрхээр шагнуулсан.



КОМПЛАЕНС

Голомт банк нь харилцагч байгууллага, иргэдэд үзүүлж
буй санхүүгийн үйлчилгээг мөн түүнчлэн хамтран
ажилладаг дотоодын болон олон улсын байгууллагуудтай
хийж буй хамтын ажиллагааг хэвийн, тасралтгүй, олон
улсын стандарт шаардлагад нийцтэйгээр хүргэж байна.



КОМПЛАЕНСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Голомт банк нь дотоодын болон олон улсын эрх бүхий байгууллагуудаас гаргасан хууль тогтоомж, дүрэм журам, стандарт шаардлага болон тэдгээрт нийцүүлэн боловсруулсан банкны өөрийн бодлого, журам, засаглалын кодекс, ёс зүйн код болон бусад стандарт, зарчмуудыг хэрэгжүүлж ажилладаг ба энэхүү чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх зорилгоор Комплаенсийн хэлтэс буюу хэрэгжилт хариуцсан нэгжийг Гүйцэтгэх захирлын шууд удирдлаганд ажиллах бүтэц зохион байгуулалттайгаар үүсгэн байгуулсан.

Голомт банк нь харилцагч байгууллага, иргэдэд үзүүлж буй санхүүгийн үйлчилгээг мөн түүнчлэн хамтран ажилладаг дотоодын болон олон улсын байгууллагуудтай хийж буй хамтын ажиллагааг хэвийн, тасралтгүй, олон улсын стандарт шаардлагад нийцтэйгээр хүргэж байна.

2019 ОНЫ ОНЦЛОХ ҮР ДҮНГҮҮД

Голомт банкны комплаенсийн үйл ажиллагаанд олон улсын байгууллагын үнэлгээ хийгдлээ

Олон улсын санхүүгийн корпораци (IFC) нь Голомт банкны комплаенс, түүн дотроо мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод үйл ажиллагаанд олон улсын стандартуудад тулгуурлан боловсруулсан үнэлгээний аргачлалаар 2019 оны 2-р сард туршилтын үнэлгээ хийсэн. Уг цоо шинэ үнэлгээний аргачлалыг IFC нь дэлхийд анх удаа хэрэгжүүлсэн ба үнэлгээнд хамрагдах анхны байгууллагаар Голомт банкийг сонгосон. IFC нь Голомт банкны Комплаенсийн үйл ажиллагааг "Боловсронгүй" хэмээн үнэлсэн нь Голомт банк Дэлхийн жишиг Монголын банк болох стратегидээ ихэд ойртсон болохыг харууллаа.

Голомт банкны ажилтнуудын Ёс зүйн форум зохион байгуулагдлаа

Голомт банк нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс батлагдсан Комплаенсийн бодлогын хүрээнд Комплаенсийн Төлөөлөгч нарын хөтөлбөрийг 2016 оноос эхлэн хэрэгжүүлж ирсэн. Комплаенс ба ёс зүй, мэдээллийн аюулгүй байдлын удирдлагыг банканд үр дүнтэй хэрэгжүүлэх, аливаа гарч болох ёс зүйн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг "Ёс зүйн төлөөлөгч нарын хөтөлбөр" болгон цар хүрээг нэмэгдүүлэхийн хамт Ёс зүйн форумыг амжилттай зохион байгууллаа. Хөтөлбөрийн хүрээнд нийт 140 ажилтан сонгон шалгаруулалтаар тэнцэн ёс зүйн төлөөлөгчөөр томилогдсон бөгөөд цаашид банкны комплаенс ба ёс зүй, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр үлгэрлэн манлайлж ажиллахыг батлан Ёс зүйн тангараг өргөсөн.



Голомт банкны баримт бичиг боловсруулах стандарт 1 шат ахилаа

Банк 2019 онд Банкны баримт бичиг боловсруулах стандартыг олон улсын тэргүүн туршлагад нийцүүлэн шинэчлэх, баримт бичгүүдийн нийцлийг хангах төслийг амжилттай хэрэгжүүлсэн.



Голомт банкны ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ

Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн нийт
оролцогч талуудын
төлөөллийг
оролцуулж
эрх ашгийг
тэнцвэржүүлсэн
шийдвэр гаргалт
тогтолцоог
бүрдүүлэн ажиллаж
байна.

”

ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

78 ГОЛОМТ
БАНК



ТУЗ-ийн дарга

Ч.Мөнхцэцэг

Хатагтай Ч.Мөнхцэцэг нь 1988 онд Зөвлөлтийн 3-р бүрэн дунд сургууль, 1993 онд Политехникийн их сургуулийг уул уурхайн цахилгаан механикийн инженер, 2001 онд АНУ-ын Жонс Хопкинсийн их сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн. 2015 онд Англи Улсын Оксфордын их сургууль, 2016 онд АНУ-ын Харвардын их сургуулиудад мэргэжил дээшлүүлсэн. 1996 онд ажлын гараагаа Монголын хөрөнгийн биржээс эхэлж, Дэлхийн банк, Азийн сан зэрэг газруудад ажиллаж байсан. 2010 оноос Тойм сэтгүүлийг эрхлэн гаргаж байсан бөгөөд 2012 оны 12 сараас Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдож, 2013 оны 12 сараас Голомт банкны ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байна.



ТУЗ-ийн гишүүн

Урс Э.Шварценбах

Ноён Урс Э.Шварценбах нь Швейцар Улсын Цюрих хотын Худалдааны коллежийг дүүргэж, 1968 онд Зүрих, 1972 онд Лондон дахь Юнион банканд ажилласан. 1976 оноос өөрийн бизнесийг эхэлсэн бөгөөд 2000 онд Канадын Нова Скотиагийн St. Francis Xavier University-ийн хүндэт доктор цолоор шагнагдсан. Ноён Урс Э.Шварценбах нь 2010 оны 1 сараас Швейцар Улсад амьдарч байгаа ХБНГУ-ын иргэдийг төлөөлөн Монгол Улсын Хүндэт консулаар өргөмжлөгдсөн. Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр 2011 оноос эхлэн ажиллаж байна.



ТУЗ-ийн гишүүн

Ж.Үнэнбат

Ноён Ж.Үнэнбат нь 1985 онд ОХУ-ын Москвагийн Эдийн засаг статистикийн дээд сургуулийг эдийн засагч, статистикч мэргэжлээр төгссөн. 1994 онд АНУ-ын Колумбын их сургуульд олон улсын эдийн засгийн харилцааны магистрын зэрэг хамгаалсан, дэд профессор цолтой. 1990 оноос Монголбанканд ажиллаж эхэлсэн бөгөөд 1996–2000 онд Монголбанкны Ерөнхийлөгч, 2000–2006 онд Монголын банкны холбооны Гүйцэтгэх захирал, 2009 оноос Компанийн засаглалын хөгжлийн төвийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж ирсэн. Мөнгөний бодлогын чиглэлээр судалгааны олон ажил хийсэн, банк санхүүгийн чиглэлээр арвин туршлага хуримтлуулсан нэгэн юм.



ТУЗ-ийн гишүүн

Д.Мөнхтөр


Ноён Д.Мөнхтөр нь 1997 онд МУИС-ийн ЭЗС-ийг Санхүүгийн удирдлагын бакалавр зэрэгтэй, 2009 онд АНУ-ын Оклахомагийн их сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр дүүргэсэн. 1996 оноос Голомт банканд туслах ажилтнаас эхлэн эдийн засагч, Эзэлийн газрын захирал, Бүртгэл тооцооны газрын захирал, Тэргүүн дэд захирлын үүрэгт ажлыг хашиж байсан. 2012 оноос ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.



ТУЗ-ийн хараат бус гишүүн

Жэймс Б.Двайер

Ноён Жэймс Б.Двайер нь Нотр Дам их сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр, Колумбын их сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн ба мэргэшсэн санхүүгийн шинжээч юм. Тэрээр 1970 оноос хойш UBS банкны Компанийн нэгдэл, компани худалдан авах процесс хариуцсан захирал зэрэг Нью-Йоркийн Wallstreet-д байрлалтай санхүүгийн байгууллагуудад хөрөнгө оруулалтын банкир хийж байсан туршлагатай. Ноён Двайер 2001 онд Худалдаа Хөгжлийн банк болон Хаан банкны хувьчлалын ажиллагаанд оролцохоор Монголд анх хөл тавьж, Хойд Америкийн бизнес зөвлөлд Үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байгаад 2007 онд Монголын бизнесийн зөвлөлийг үүсгэн байгуулсан. Тэрээр Мандал даатгал болон Mongolia Growth Group ХХК-уудад ТУЗ-ийн хараат бус гишүүн, Mongoljin private capital-ийн Гүйцэтгэх бус ТУЗ-ийн дэд дарга, Монголын боловсролын сангийн ТУЗ-ийн дарга, Ерөнхийлөгчийн албыг хашдаг.



ТУЗ-ийн хараат бус гишүүн

Антонио Л.Абелло

Ноён Антонио Л.Абелло нь Испанийн Барселоны их сургуулийг хуульч мэргэжлээр, IESE бизнесийн сургуулийг бизнесийн удирдлагын магистр цолтойгоор төгссөн. Барселоны хуулийн холбооны мэргэшсэн хуульч, CEFFAS стандартын дагуу Мэргэшсэн санхүүгийн аналит (CFA) зэрэгтэй. Кредит свисс, Голдмэн сакс болон Парибас банкуудад бонд болон хөрөнгийн санхүүжилт хариуцсан удирдах түвшний албан тушаалуудыг хашиж байсан. Сингапур болон Лондон хотын хөрөнгө оруулалтын тэргүүлэгч банкуудад 20 гаруй жил ажилласан, олон улсад өндрөөр үнэлэгддэг туршлагатай банкируудын нэг юм. Тэрбээр Turms Advisors LLP фирмийг үүсгэн байгуулагч, партнераар ажилладаг. 2014 онд Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдсон.



ТУЗ-ийн гишүүн

Л.Болормаа

Хатагтай Л.Болормаа (CFA) нь МУИС-ийг Банк санхүүгийн чиглэлээр бакалавр, Virginia Polytechnic Institute and State Их Сургуулийг Олон улсын эдийн засагч, Япон улсын Олон Улсын Их Сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгссөн. Л.Болормаа нь 1992 онд ажлын гараагаа Ардын Банкнаас эхэлж, Герман улсын Deutsche Bank-ны АНУ-ын Нью-Йорк хот болон Японы Токио хот дахь салбаруудад хөрөнгө оруулалт, олон улсын зах зээл, эрсдэлийн удирдлага чиглэлээр ажиллаж байсан. 2015 оноос Голомт Файнэншил Групп ХХК-д ажиллаж байсан ба банк санхүүгийн 20 гаруй жилийн туршлагатай. 2020 оны 3-р сараас Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.



ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ

“Дэлхийн жишиг Монголын банк” болох Голомт банкны алсын хараанд бүх үйл ажиллагаа бизнесийн стандартаар хүрэхээр зорьж байгаа бөгөөд зохистой засаглалын тогтолцооны хувьд мөн энэхүү зорилгод хүрэхээр амжилттай ажилласаар ирлээ. Аливаа байгууллагад ТУЗ-ийн манлайлал засаглалын тогтолцоо сайжруулахад нэн чухал байдгийг ойлгон хэрэгжүүлдэг Голомт банкны ТУЗ банкны үйл ажиллагааг удирдан чиглүүлэхэд идэвхтэй оролцож, нөгөө талдаа ТУЗ-ийн хяналтыг өндөр байлгахад анхаарч байна.

ТУЗ-ийн шийдвэр гаргалт тэнцвэртэй мөн оновчтой байх тогтолцоог бүрдүүлэхэд анхаарч мэргэшсэн болоод туршлага бүхий зохистой баг бүрдүүлэн нийт оролцогч талуудын төлөөллийг ханган ажиллаж байна.

Голомт банкны засаглалын тогтолцоо



2019 оны эцсийн байдлаар Голомт банкны хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн

- Голомт Файнэншил Групп ХХК - 86.63%
- Swiss-MO Investment AG - 8.22%
- Голомт Инвестмэнт Лимитэд - 4.06%
- АХЭХ-ийн хүрээнд хувьцаа эзэмшигчид - 1.09%

Голомт банк нь энгийн хувьцаанаас гадна Давуу эрхийн хувьцаатай ба тус хувьцааг Монгол Улсын иргэн М.Зоригт эзэмшдэг болно.

Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний дийлэнх хувийг нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдээс ангид жижиг хувьцаа эзэмшигчид болон Хараат бус гишүүд эзэлж байна. Энэ нь Голомт банкны ТУЗ-ийн тогтолцоо нэг талын нөлөөнд автсан шийдвэр гаргах эрсдэлгүй хамгийн

эрүүл гэдгийн баталгаа юм. ТУЗ-ийн удирдан чиглүүлэх үндсэн ажлын нэгийг гүйцэтгэхэд өндөр хувь нэмэр оруулахуйц банк санхүүгийн өөр өөр талбараар мэргэшсэн мэргэжилтнүүдээр зөвлөлөө бүрэлдүүлсэн ба Дотоод аудитын газар, Аудит хариуцсан Захирал нарыг ТУЗ-өөс томилон удирдаж хяналтын тогтолцоогоо зохистой байдлаар бүрдүүлж ажиллаж байна.

2019 онд Голомт банкны ТУЗ нийт 19 удаа ээлжит болон ээлжит бус байдлаар хуралдаж, нийт 60 асуудлыг хэлэлцэн зөвлөлдөж 48 асуудал шийдвэрлэн Тогтоол гаргасан байна.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Эрсдэлийн удирдлагын хороо

Голомт банкны Эрсдэлийн удирдлагын хороо нь ТУЗ-ийн 1 гишүүдээс бусад бүх гишүүдийн бүрэлдэхүүнтэй (бүх хараат бус гишүүд оролцдог мөн тус хорооны дарга ТУЗ-ийн Хараат бус гишүүн томилогдсон) ажилладаг ба дунджаар сард 1 удаа хуралдаж банкны нийт эрсдэлийг зохистой байдлаар тодорхойлж, эрсдэлийн хүлээн зөвшөөрч болох хэм хэмжээг тогтоон, хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаардаг болно.

Банкны нийт эрсдэл буюу санхүүгийн, санхүүгийн бус эрсдэл, Зээлийн, үйл ажиллагааны болон комплаенсийн эрсдэлүүдийг удирдах асуудлыг банкны бодлогын хэмжээнд хангаж ажиллах, хэрэгжилтийг хянах гол чиг үүрэгтэй учраас тус хорооны дүрэмд тусгагдаж, бүтцээр хангагдсанаар Эрсдэл хариуцсан захирал нь тус хороонд тайлагнах шугамтай болно. Тиймээс Эрсдэл хариуцсан захирлын гол анхаарч ажиллах асуудал гэх зэрэг жилийн төлөвлөгөөтэй танилцаж үүрэг зөвлөмжөөр хангаж ажилладаг.

Тайлант хугацаанд нийт 17 удаа хуралдаж нийт 50 асуудал хэлэлцсэн байна.

Эрсдэлийн Удирдлагын Хорооны зөвлөмжийн дагуу ТУЗ нь дараах гол бичиг баримтуудыг батлан ГУ-д хэрэгжүүлэх чиг үүрэг өгч хянадаг болно. Үүнд:

1. Risk Appetite Framework/Risk Appetite Statement Эрсдэлийн аппетитын бодлого бичиг баримт
2. Эрсдэлийн лимитүүд
3. Зээлийн бодлого
4. Зээлийн хорооны дүрэм
5. Комплаенсийн бодлого
6. Засаглалын кодекс дах бодлогын бичиг баримтууд:
 - a. Ёс зүйн дүрэм
 - b. Авлигын эсрэг бодлого
 - c. Сонирхлын зөрчилтэй асуудлыг шийдвэрлэх журам
 - d. Мэдээллийн тэнцвэртэй байдлын бодлого
 - e. Луйврын эсрэг бодлого
 - f. Улс төрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бодлого
 - g. Зөрчлийн мэдээлэх тухай бодлого – шүгэл үлээх

Эрсдэлийн удирдлагын хорооны тогтмол авдаг тайлангууд:

1. Эрсдэлийн тайлан
 - Санхүүгийн эрсдэл:
 - Зах зээлийн эрсдэл
 - Зээлийн эрсдэл
 - Зээлийн багцын мэдээлэл /сар бүрээр/



- Санхүүгийн бус эрсдэл:
 - Үйл ажиллагааны эрсдэлийн тайлан
 - Комплаенсийн эрсдэлийн тайлан
 - МУТСТэмцэх үйл ажиллагааны тайлан
- 2. Гүйцэтгэх удирдлагын түвшний Эрсдэлийн удирдлагын хорооны тайлан
- 3. Зээлийн хорооны шийдвэрийг хянах
- 4. Эрсдэлийн бодлогын хэрэгжилт – RAF/RAS эрсдэлийн метриксүүдийн хэрэгжилт

Засаглал, Ёс зүй, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хороо

Тус хороо нь Голомт банкны Засаглалын кодекс болон түүнд багтсан бүх бодлогуудын хэрэгжилтийн асуудлыг хамардаг ба Гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх, цалин хөлс, урамшууллын системийг боловсруулах, батлахад ТУЗ-д санал, зөвлөмж өгч ажилладаг болно. Хороо нь ТУЗ-ийн гишүүд, банкны гүйцэтгэх удирдлагатай холбоотой шалгаруулалт, цалин, урамшууллыг зөв зохистой тодорхойлж, тэдний ажлын үр дүнг хэлэлцэж, дүгнэх, ТУЗ-д санал болгох, зөвлөх зорилго, үүрэгтэй хороо юм.

Тус хороо нь улиралд 1 ээлжит хурлын товтой ба энэ нь жилийн эхэнд батлагдаж төлөвлөгддөг. Мөн хэлэлцэх асуудлаас хамаараад тухай бүр ээлжит бус хурал зарлан хуралдуулж ажиллаж байна. Мөн хороо нь ТУЗ-ийн Гүйцэтгэх захиралтай хийх гэрээн дээр ажилласан ба мөн шинэ Гүйцэтгэх захирлаас ТУЗ-ийн зүгээс хүлээх хүлээлт гэх зэрэг гүйцэтгэх удирдлагын томилгоо, хариуцлага, урамшууллын тогтолцоог бүрдүүлэхэд анхаардаг.

Банкны эрх бүхий албан тушаалтан буюу Газрын захирлаас дээш албан тушаалтай нийт Гүйцэтгэх Удирдлагын багийн гишүүдтэй Гүйцэтгэх захирал контрактын гэрээ байгуулж ажиллах чиг үүргийн хэрэгжилтийг хянаж, олгох цалин урамшууллыг тодорхойлох, Гүйцэтгэлийг үнэлэх зарчим аргачлал зэрэг дээр хяналт тавьж ажилладаг.

Тус хорооны зөвлөмжийн дагуу ТУЗ-өөс батлагдсан бодлогууд нь:

1. Хүний нөөцийн бодлого
2. Цалин, урамшууллын бодлого

Түүнээс гадна банкны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангахтай холбоотой журам дүрэмтэй танилцаж, хянан хэлэлцэж зөвлөмжөө өгч ажиллаж байна. Тиймээс банкны борлуулалт болон төвийн нэгжийн цалингийн систем, тэдгээрийн гүйцэтгэлд суурилсан урамшууллын систем, сонгон шалгаруулах журам, ажилтанд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох журам, ажилтнуудын халамж тэтгэмжийн журам гэх зэрэг холбоотой бичиг баримтуудтай танилцаж санал өгдөг. Мөн дараах хүний нөөцтэй холбоотой явцын тайлангуудтай танилцдаг болно.

Ирэх жилийн Хүний нөөцийн төлөвлөгөө, цалин урамшууллын зардлыг энэхүү хороогоор урьдчилан хэлэлцэж саналаа өгсний дараа нэгдсэн банкны төсөв, төлөвлөгөөнд тусгагддаг болно. Хүний нөөц хариуцсан захирлаас хүний нөөцтэй холбоотой гол анхаарал асуудлууд, хийх ажлын төлөвлөгөө зэргийг мөн авч танилцдаг.

Тус хороо нь 2019 онд нийт 7 удаа хуралдаж 20 асуудал хэлэлцсэн.

Аудитын хороо

Голомт банкны Аудитын хороо нь 2019 онд 5 гишүүнтэй ажилласан бөгөөд хараат бус гишүүн Жеймс Б.Двайер нь 2019 оны 1 дүгээр сарын 31-нд Аудитын хорооны даргаар томилогдон ажиллаж байна.




Аудитын хороо нь дараах үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлдэг.

- Санхүүгийн тайлантай холбоотой
- Дотоод хяналтын тогтолцоотой холбоотой
- Дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой
- Хөндлөнгийн аудитын үйл ажиллагаатай холбоотой
- Тайлагналын үйл ажиллагаатай холбоотой
- Бусад үйл ажиллагаатай холбоотой

2019 онд хэлэлцсэн асуудлууд

Аудитын хороо нь 2019 онд ээлжит болон ээлжит бусаар нийт 11 удаа хуралдан, 55 асуудлыг хэлэлцэж, холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.

Хэлэлцсэн асуудлууд



Аудитын хороо нь шаардлагатай тохиолдолд хорооны эрхлэх асуудлын хүрээнд тусгайлсан хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах, банкны нууцад хамаарах баримт, материалтай танилцах, холбогдох албан тушаалтнаар мэдээлэл гаргуулах эрхтэй байна. Дотоод аудитын болон хөндлөнгийн аудитын тайлан, илэрсэн зөрчил, зөвлөмжүүд нь Аудитын хороонд шууд тайлагнагддаг.

Аудитын хороо нь сар бүрийн санхүүгийн үзүүлэлтүүдийг хянаж, Удирдлагын багт үүрэг, зөвлөмж өгдөг. Мөн хөндлөнгийн аудитын тайланг хэлэлцэж, батлах саналыг ТУЗ-д хүргүүлж ажилладаг. Аудитын хороо нь нягтлан бодох бүртгэлийн стандарт, хууль эрх зүйн орчинд гарч буй санхүүгийн тайлагналд нөлөө үзүүлэхүйц өөрчлөлтүүдийн талаар байнгын мэдээлэлтэй байдаг.

Аудитын хороо нь Дотоод аудитын газрын эрх, үүргийг тусгасан дүрэм, үйл ажиллагааны журам, эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөгөөг хэлэлцэж, холбогдох саналыг ТУЗ-д хүргүүлдэг. Мөн Дотоод аудитын үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг, үйл ажиллагаандаа олон улсын стандарт, арга аргачлалыг ашиглаж буй эсэхийг болон аудитын тайлан, тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянадаг. Аудитын хороо нь Аудит хариуцсан захирлыг томилох, чөлөөлөх саналыг ТУЗ-д хүргүүлж, ажлын гүйцэтгэлийг үнэлж, цалин урамшууллыг тогтоодог.

Дотоод аудитын үйл ажиллагаа

Дотоод аудитын газрын алсын хараа нь Чанар нь баталгаажсан аудитын үйлчилгээ, эрхэм зорилго нь Итгэлт зөвлөгч байдаг бөгөөд дүрэмд тусгагдсаны дагуу Эрсдэлд суурилсан, хараат бус, бодит баталгаажуулалт хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар Банк, түүний нэгж, үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэн нэмэх, зорилгодоо хүрэхэд нь туслах үндсэн зорилготой.

Дотоод аудитын газар нь Гүйцэтгэх удирдлагаас хараат бус байх бөгөөд дотоод аудитын газрын зорилго, хамрах хүрээ, эрх, үүрэг хариуцлагыг Дотоод аудитын газрын дүрэмд тусгаж, Төлөөлөн удирдах зөвлөл баталсан байдаг.

Дотоод аудитын газрын ажилтнууд нь банкны ёс зүйн кодыг дагаж мөрдөхөөс гадна аудиторын ёс зүйн кодыг дагаж мөрддөг. Дотоод аудитын газар нь Олон улсын Дотоод аудиторуудын институтээс гаргасан Олон улсын мэргэжлийн практикийн хүрээнд үйл ажиллагаагаа бүрэн нийцүүлэх зорилгоор 2019 онд баримт бичгүүдээ шинэчлэн батлуулсан.

Дотоод аудитын газар нь дараах үндсэн чиг үүрэгтэй

- Банкны засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо нь үр дүнтэй хэрэгжиж байгаад баталгаажуулалт хийх, үнэлэх
- Банкны стратеги зорилгыг хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэл буюу стратегийн эрсдэлийн удирдлагын оновчтой байдлыг үнэлэх
- Банкны Гүйцэтгэх удирдлага, ажилтан, гэрээт ажил үүрэг гүйцэтгэгчид нь холбогдох хууль, бодлого, дүрэм, журам, засаглалын стандарт, тогтоол, шийдвэрүүдийг биелүүлж байгаа эсэхийг баталгаажуулах
- Банкны нэгж, үйл ажиллагаа, систем, төсөл хөтөлбөрүүд нь үр дүнтэй хэрэгжиж буй эсэхийг үнэлэх, мөн хууль, бодлого, дүрэм, журам, засаглалын стандарт, тогтоол, шийдвэрүүдтэй нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах
- Гүйцэтгэх удирдлагын хүсэлтээр үйл ажиллагааг сайжруулах, шалгах зорилго бүхий зөвлөх үйлчилгээ үзүүлэх

Аудит хариуцсан захирал нь Аудитын хороо болон Төлөөлөн удирдах зөвлөлд ямар нэгэн хязгаарлалтгүйгээр харилцах бөгөөд банкны бөгөөд банктай холбоотой бүхий л төрлийн тайлан мэдээлэл, баримт бичиг, бүртгэлийн систем, программ зэрэг бүх төрлийн электрон болон цаасан мэдээлэлд ямар нэгэн хязгаарлалтгүйгээр хандах, холбогдох удирдлага, албан тушаалтнаар гаргуулан авах бүрэн эрхтэй байдаг.

Дотоод аудитын газар нь эрсдэлд суурилсан арга аргачлалыг үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд хамгийн өндөр эрсдэлтэй нэгж, үйл ажиллагаанд аудит хийдэг. 2017 оноос эхлэн эрсдэлийн үнэлгээг хийхдээ Дотоод аудиторуудын институт (IIA Global)-ын санал болгож буй аргачлалуудаас Тусгайлсан эрсдэлийн үнэлгээний загварыг сонгож, 3+9 зарчим буюу эрсдэлийн үнэлгээг улирал бүр хийх, уг үнэлгээнд үндэслэж аудитын төлөвлөгөө улирал бүр өөрчлөгдөх боломжтой байх зарчмыг баримталж байна. Эрсдэлийн үнэлгээг хийхдээ шинэ бизнес, шинэ бүтээгдэхүүнийг тухай бүр хамруулдаг.

Голомт банкны Дотоод аудитын газар нь ажлын тайлан, аудитын төлөвлөгөө, зөвлөмжийн биелэлтийг ТУЗ, Аудитын хороонд улирал бүр тайлагнадаг бөгөөд аудитын тайланг Гүйцэтгэх захиралд мэдэгдэж, шаардлагатай сайжруулах ажлуудыг цаг тухайд нь хийлгэдэг.



Дотоод аудитын газрын онцлох үйл явдлууд



Шинэ бүтцээр ажиллаж эхлэв



Эжайл аудит, скрам менежментийн аргыг нэвтрүүлж, хэрэглэж эхлэв



PwC Czech-тэй хамтарсан аудит хийж зөвлөмж өгөв



Зайны аудитын хүрээ, аргачлал давтамжийг сайжруулав



Журам, заавар, арга аргачлалыг шинэчилж олон улсын стандартад нийцүүлэв



Аудитын үйл ажиллагаанд дата анализийг нэвтрүүлж мэргэшсэн багийг бэлтгэв



Зайны аудит, Хүний нөөцийн удирлагын арга аргачлалыг банкны бодлогын нэгжүүдэд шилжүүлэв



Банкны хэмжээнд 400 гаруй ажилтанд ёс зүй дотоод хяналтын чиглэлээр сургалт зохион байгуулав

2019 онд, Зайны аудит, Чанарын баталгаажуулалтын хэлтсийг шинээр байгуулан, чанарын баталгаажуулалтын мэргэшсэн багийг бий болгож, Чанарын баталгаажуулалт, сайжруулах хөтөлбөрийн хүрээнд дотоод үнэлгээг анх удаа хийлээ.

- СТОУС9-ийн дагуу үнэ цэнийн бууралт тооцох үйл ажиллагаа
- Зээлийн рейтинг, скоринг
- Эрсдэлийн аппетитын тогтолцоо
- Барьцаа хөрөнгийн удирдлага
- Стресс тест зэрэг үйл ажиллагаа

PwC Czech-тэй хамтран хийсэн эдгээр ко-соурсад аудитаар банкны үйл ажиллагааг Олон улсын стандартад нийцүүлэх 53 зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд Дотоод аудитын газрын аудитуудаас гадна Эрсдэлийн удирдлагын газар, Зээлийн газрын мэргэжилтэн, удирдлагуудад мэдлэг нэмсэн үр дүнтэй аудит боллоо.



ГОЛОМТ БАНК

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн
Санхүүгийн тайлангууд болон Хараат бус аудиторын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31



Байгууллагын талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр

Голомт Банк (цаашид “Банк” гэх) нь 1995 оны 03 сарын 06-ны өдрийн Бодь Интернэйшнл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр Бодь Интернэйшнл ХХК-ийн 100%-н охин компани болон анх үүсгэн байгуулагдсан.

Гэрчилгээ ба Лиценз

Банк нь 2005 оны 12 сарын 05-ны өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас 2075377 тоот регистрийн дугаар бүхий 9016001014 тоот Улсын Бүртгэлийн гэрчилгээг авсан.

Банк нь 1995 оны 03 сарын 06-ны өдөр банкны үйл ажиллагаа эрхлэх 25 тоот Тусгай зөвшөөрлийг Монголбанкнаас авсан.

Төлөөлөн Удирдах Зөвлөл

Ч.Мөнхцэцэг	ТУЗ-ийн дарга
Урс Е.Шварценбах	ТУЗ-ийн гишүүн
Д.Мөнхтөр	ТУЗ-ийн гишүүн
Ж.Үнэнбат	Хараат бус гишүүн
Лопез Абелло	Хараат бус гишүүн
Жэймс Б.Двайер	Хараат бус гишүүн

Гүйцэтгэх Удирдлага

К.Норихико	Гүйцэтгэх захирал
Г.Ганболд	Ерөнхийлөгч
Т.Нямсүрэн	Гүйцэтгэх захирлын орлогч болон зээл хариуцсан захирал
М.Сайнбилэг	Мэдээлэл технологи хариуцсан захирал
М.Чимэгмөнх	Санхүү удирдлагын газрын захирал
Д.Бадрал	Байгууллагын банкны газрын захирал
Ц.Байгалмаа	Иргэд, жижиг дунд банкны газрын захирал
Б.Баяртбилэг	Зээлийн газрын захирал
Г.Уянга	Хүний нөөцийн удирдлагын газрын захирал
М.Наранхүү	Бизнес процесс менежментийн захирал
О.Батцэнгэл	Мэдээллийн технологийн газрын захирал
Ё.Пүрэвбат	Бүртгэл тооцооны газрын захирал
Х.Пүрэвдорж	Захиргааны газрын захирал
Ж.Хишигжаргал	Хөрөнгө оруулалт санхүүгийн байгууллагын газрын захирал

Хаяг

Голомт Банк
Голомт Банкны төв байр
Сүхбаатарын талбай 5, Ш/х-22
Улаанбаатар 15160, Монгол улс

Аудитор

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК
Сентрал Тауэр, 6-р давхар, 601
Сүхбаатарын талбай, СБД-8
Улаанбаатар 14200, Монгол улс

Хараат бус аудиторын тайлан

Голомт банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчид болон Төлөөлөн удирдах зөвлөлд

Бидний дүгнэлт

Бидний дүгнэлтээр, Голомт банк ХХК ("Банк" гэх)-ийн санхүүгийн тайлангууд нь 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал хийгээд мөн тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

Бид юунд аудит хийсэн талаар

Дараах бүрэлдэхүүн бүхий Банкны санхүүгийн тайлангуудад бид аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдлын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн мөнгөн гүйлгээний тайлан; болон
- нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд болон бусад тайлбар мэдээллээс бүрдсэн санхүүгийн тайлангуудын тодруулга

Дүгнэлтийн үндэслэл

Бид Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн *Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага* хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Хараат бус байдал

Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЭСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЁЗД)-ийн дагуу Банкнаас бид хараат бус болно. Бид НБОУЭСЗ-ийн МНБЁЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.



Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, бодитойгоор тайлагнах болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлангууд бэлтгэхэд шаардлагатай гэж удирдлага тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага Банкны үйл ажиллагааг цаашид тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, тухайн чадамжид нөлөөлөх нөхцөл байдлын талаар зохистой үед тодруулах болон Банкны үйл ажиллагааг татан буулгах, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл зогсоохоос өөр сонголтгүй болсноос бусад тохиолдлуудад нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Банкны засаглал хариуцсан эрх бүхий этгээд нь санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Залилан нь нууцаар үгсэн тохирох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотойгоор үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Банк нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай холбоотойгоор материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа

Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлуудаас шалтгаалан Банкны үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсч болно.

- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид удирдлагад аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.

Гарын үсэг зурсан:



Даваагийн Баярмаа

Гүйцэтгэх захирал

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Баталсан:



Шаукат Тапия

Партнер

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Улаанбаатар, Монгол улс

2020 оны 3 сарын 25-ны өдөр

Мянган төгрөгөөр	Тодруулга	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
Хөрөнгө			
Бэлэн мөнгө ба төв банкинд байршуулсан мөнгө (зайлшгүй байлгах нөөцөөс бусад)	7	1,110,252,507	658,075,005
Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөц	8	291,911,405	455,072,892
Урвуу РЕПО хэлцэл	9	-	99,975,351
Бусад банкуудад байршуулсан хөрөнгө	10	906,564,709	586,137,792
Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	11	286,935,722	518,942,058
Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	12	82,697,234	105,693,688
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	13	3,306,694,312	3,183,723,744
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	14	42,387,502	34,293,822
Бусад хөрөнгө	15	100,666,998	44,826,731
Хойшлогдсон татварын хөрөнгө	32	91,018	-
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл		138,110,388	125,352,711
Биет бус хөрөнгө	16	14,370,011	14,250,326
Үндсэн хөрөнгө	17	147,748,830	130,090,247
Ашиглах эрхтэй хөрөнгө	18	6,262,751	-
Өмчлөх бусад хөрөнгө	19	151,317,600	89,901,317
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	20	57,125,324	34,777,089
Нийт хөрөнгө		6,643,136,311	6,081,112,773
Өр төлбөр			
Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	21	52,928,512	148,766,727
Харилцагчдын харилцах, хадгаламж	22	4,900,641,622	4,402,648,347
Зээлийн бусад эх үүсвэр	23	916,032,162	715,852,783
РЕПО хэлцэл	24	24,876,114	151,343,018
Орлогын татварын өглөг	32	1,444,404	4,950,542
Хойшлогдсон татварын өр төлбөр	32	-	5,306,666
Түрээсийн өр төлбөр	18	6,524,901	-
Бусад өр төлбөр	25	106,156,139	46,586,108
Хоёрдогч өглөг	26	172,027,616	92,582,956
Нийт өр төлбөр		6,180,631,470	5,568,037,147
Эзэмшигчдийн өмч			
Давуу эрхтэй хувьцаа	27	25,778,900	75,778,900
Энгийн хувьцаа	27	32,014,498	32,321,857
Нэмэгдэж төлөгдсөн капитал	27	135,171,702	127,629,293
Хуримтлагдсан ашиг		197,396,268	202,842,670
Өмчийн бусад хэсэг		72,143,473	74,502,906
Нийт эзэмшигчдийн өмч		462,504,841	513,075,626
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		6,643,136,311	6,081,112,773



Ч.МӨНХЦЭГ
ТУЗ-ийн дарга





М.ЧИМЭГМӨНХ
Санхүүгийн удирдлагын газрын захирал

Орлого Үр Дүн болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2019	2018
Хүүгийн орлого	28	556,957,598	463,853,291
Бусад адилтгах орлого	28	20,934,133	30,107,637
Хүүгийн зардал	28	(365,155,590)	(323,255,156)
Бусад адилтгах зардал	28	(851,077)	-
Хүүгийн цэвэр орлого		211,885,064	170,705,772
Зээлжих эрсдэлийн сангийн зардал	13	(135,444,583)	(66,150,713)
Зээлжих эрсдэлийн сангийн зардлын дараах хүүгийн цэвэр орлого		76,440,481	104,555,059
Хураамж, шимтгэлийн орлого	29	55,098,342	47,389,265
Хураамж, шимтгэлийн зардал	29	(17,094,328)	(12,323,356)
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз/(гарз)		2,319,394	(6,339,847)
Бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт		(3,761)	-
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн олз		15,029,328	93,418,196
Гадаад валют болон үнэт металын арилжаанаас үүссэн олз		12,585,157	15,736,921
Хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгүүдийн өөрчлөлтөөс үүссэн гарз		(288,293)	(1,293,892)
Хорогдуулсан өртгөөр хэмжих өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын хүлээгдэж буй алдагдлын сангийн зардлын буцаалт		697,526	1,069,763
Бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө хүлээгдэж буй алдагдлын сангийн зардал		990,237	(793,026)
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз		(839,402)	-
Зах зээлийн хүүгээс бага хүүтэй олгосон санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн гарз	13	(5,348,937)	(16,943,013)
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн олз/(гарз)		11,971,271	(19,049,921)
Бусад хөрөнгийн үнэ цэнийн алдагдлын сангийн зардал	15	(2,689,233)	(2,666,983)
Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз		-	(26,600,000)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийн олз		1,792,301	1,920,631
Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал		(9,559,169)	(6,546,401)
Аккредитив, баталгааны эрсдэлийн сангийн зардлын буцаалт		1,461,464	393,454
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз/(гарз)	14	3,217,996	(3,023,845)
Ногдол ашгийн орлого		96,178	1,823,177
Үйл ажиллагааны бусад орлого	30	1,024,184	14,966,586
Удирдлагын болон үйл ажиллагааны бусад зардал	31	(122,005,830)	(110,092,968)
Татварын өмнөх ашиг		24,894,906	75,599,800
Орлогын албан татварын зардал	32	(8,590,226)	(22,053,560)
Тайлант жилийн ашиг		16,304,680	53,546,240
Бусад дэлгэрэнгүй орлого:			
<i>Ирээдүйд ашиг, алдагдалд ангилагдахгүй зүйлс:</i>			
Бодит үнэ цэнийг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтаас үүссэн гарз		(8,924,616)	(10,222,176)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		1,242,104	3,000,000
Дэлгэрэнгүй орлогын тайланд шууд бүртгэсэн орлогын татвар		2,231,155	2,555,544
Бусад дэлгэрэнгүй орлого		(5,451,357)	(4,666,632)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		10,853,323	48,879,608

Банкны эздэд хамаарах										
Мянган төгрөгөөр	Тодруулга	Давуу эрхтэй хувьцаа	Хувьцаат капитал	Нэмэгдэж төлөгдсөн капитал	ББХО ҮЦ-ны дахин үнэлгээний нөөц	БДОХЗ үнэт цаасны дахин үнэлгээний нөөц	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Бусад нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт эзэмшигчдийн өмч
2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		25,778,900	26,367,593	46,583,557	40,331,226	-	3,961,909	30,132,163	218,533,691	391,689,039
СТОУС 9 рүү шилжилтийн нөлөө:										
- хүлээгдэж буй зээлжих эрсдэлийн дахин хэмжилт, татвараар цэвэршүүлсэн		-	-	-	-	-	-	-	(55,832,933)	(55,832,933)
- санхүүгийн хөрөнгийн дахин ангилал ба хэмжилт, татвараар цэвэршүүлсэн		-	-	-	(40,331,226)	(1,431,363)	-	-	41,762,589	-
2018 оны 01 сарын 01-ний дахин илэрхийлсэн үлдэгдэл		25,778,900	26,367,593	46,583,557	-	(1,431,363)	3,961,909	30,132,163	204,463,347	335,856,106
Тухайн жилийн ашиг		-	-	-	-	-	-	-	53,546,240	53,546,240
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-	-	-	(7,666,632)	3,000,000	-	-	(4,666,632)
2018 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	-	-	-	(7,666,632)	3,000,000	-	53,546,240	48,879,608
Шинээр гаргасан энгийн хувьцаа		-	5,173,444	69,826,556	-	-	-	-	-	75,000,000
Шинээр гаргасан давуу эрхтэй хувьцаа		50,000,000	-	-	-	-	-	-	-	50,000,000
Хоёрдогч өглөгийн хөрвүүлэлт		-	780,820	11,219,180	-	-	-	-	-	12,000,000
Зарласан болон төлөгдсөн ногдол ашиг		-	-	-	-	-	-	-	(8,660,088)	(8,660,088)
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		-	-	-	-	-	(106,667)	-	106,667	-
МБ-ны журмын дагуу бусад нөөц рүү шилжүүлсэн нөөц		-	-	-	-	-	-	46,613,496	(46,613,496)	-
2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		75,778,900	32,321,857	127,629,293	-	(9,097,995)	6,855,242	76,745,659	202,842,670	513,075,626
Тухайн жилийн ашиг		-	-	-	-	-	-	-	16,304,680	16,304,680
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-	-	-	(6,693,461)	1,242,104	-	-	(5,451,357)
2019 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	-	-	-	(6,693,461)	1,242,104	-	16,304,680	10,853,323
Цуцалсан энгийн хувьцаа	27	-	(5,954,264)	(81,045,736)	-	-	-	-	-	(87,000,000)
Цуцалсан давуу эрхтэй хувьцаа	27	(50,000,000)	-	-	-	-	-	-	-	(50,000,000)
Хоёрдогч өглөгийн хөрвүүлэлт	27	-	5,646,905	88,588,145	-	-	-	-	-	94,235,050
Зарласан ногдол ашиг		-	-	-	-	-	-	-	(9,009,657)	(9,009,657)
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		-	-	-	-	-	(350,676)	-	350,676	-
МБ-ны журмын дагуу бусад нөөц рүү шилжүүлсэн нөөц		-	-	-	-	-	-	3,442,600	(3,442,600)	-
Бусад шилжүүлэг		-	-	-	-	-	-	-	(9,649,501)	(9,649,501)
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		25,778,900	32,014,498	135,171,702	-	(15,791,456)	7,746,670	80,188,259	197,396,268	462,504,841

Мөнгөн Гүйлгээний Тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2019	2018
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Татварын өмнөх ашиг		24,894,906	75,599,800
Тохируулгууд:			
Зээлжих эрсдэлийн сангийн зардал	13	135,444,583	66,150,713
Бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт		3,761	-
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн (олз)/гарз		(2,319,394)	6,339,847
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн олз		(11,081,513)	(93,418,196)
Хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгүүдийн өөрчлөлтөөс үүссэн гарз		288,293	1,293,892
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз		839,402	-
Бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө хүлээгдэж буй алдагдлын сангийн зардал		(990,237)	793,026
Хорогдуулсан өртгөөр хэмжих өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын хүлээгдэж буй алдагдлын сангийн зардлын буцаалт		(697,526)	(1,069,763)
Зах зээлийн хүүгээс бага хүүтэй олгосон санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн гарз		5,348,937	16,943,013
Үндсэн хөрөнгө борлуулсны олз		1,536,773	2,501,390
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн (олз)/(гарз)		(11,971,271)	19,049,921
Бусад хөрөнгийн үнэ цэнийн алдагдлын сангийн зардал	15	2,689,233	2,666,983
Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз	17	-	26,600,000
Аккредитив, баталгааны эрсдэлийн сангийн зардлын буцаалт		(1,461,464)	(393,454)
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн (олз)/гарз	14	(3,217,996)	3,023,845
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийн олз	20	(1,792,301)	(1,920,631)
Элэгдлийн зардал	17	14,015,517	9,757,418
Хорогдуулалтын зардал	16	2,860,510	2,647,120
Данснаас хассан үндсэн хөрөнгө	17	45,682	18,591
Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал	19	9,559,169	6,546,401
Мөнгөн бусаар хүлээн авсан ногдол ашиг		-	(403,294)
Хүүгийн орлого	28	(577,891,731)	(493,960,928)
Хүүгийн зардал	28	366,006,667	323,255,156
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ		(47,890,000)	(27,979,150)
Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөцийн цэвэр (өсөлт)/бууралт		163,161,487	(60,043,603)
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн цэвэр өсөлт		(305,824,959)	(107,077,239)
Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх үнэт цаасны цэвэр бууралт		114,709,744	174,529,874
Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх өмчийн хэлбэрээрх үнэт цаасны цэвэр бууралт		9,794,053	18,184,576
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны цэвэр өсөлт		(650,176,728)	(1,200,251,752)
Бусад хөрөнгийн цэвэр (өсөлт)/бууралт		(64,213,447)	755,462
Өмчлөх бусад хөрөнгийн цэвэр (өсөлт)/бууралт		(9,559,169)	1,417,442
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн цэвэр (өсөлт)/бууралт		(20,555,934)	12,111,094
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн цэвэр өсөлт		(4,875,684)	-
Бусад банкнуудын байршуулсан хөрөнгийн цэвэр бууралт		(95,838,215)	(239,425,506)
Харилцагчдын харилцах, хадгаламжийн цэвэр өсөлт		495,714,366	935,753,814
Бусад өр төлбөрийн цэвэр өсөлт/(бууралт)		61,031,495	(9,053,792)
Татвар болон хүүгийн өмнөх үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгө		(354,522,991)	(501,078,780)
Төлсөн орлогын албан татвар		(15,262,893)	(6,035,111)
Хүлээн авсан хүү		525,560,117	475,288,525
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх хөрөнгө оруулалтаас хүлээн авсан хүү		205,299	-
Төлсөн хүү		(339,927,112)	(323,629,516)
Үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгө		(183,947,580)	(355,454,882)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2019	2018
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ			
Бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт		(4,020,651,932)	(11,354,599,126)
Бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өмчийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт		(9,012,274)	(75,173,189)
Бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого		4,260,523,837	11,534,438,662
Бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өмчийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого		87,659	46,317
Хорогдуулсан өртгөөр хэмжих өрийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт		409,233	(3,389,776)
Хорогдуулсан өртгөөр хэмжих өрийн хэлбэрээрх үнэт цаасны эргэн төлөлтөөс олсон орлого		34,161,381	21,480,911
Охин компани борлуулсны цэвэр орлого		-	519,886
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	17	(31,325,390)	(15,144,634)
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	17	847,712	6,664,120
Биет бус хөрөнгийн худалдан авалт	16	(2,980,195)	(3,217,588)
Хөрөнгө оруулалтад зарцуулсан цэвэр мөнгө		232,060,031	111,625,583
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Шинээр гаргасан энгийн хувьцаа	27	(45,000,000)	75,000,000
Шинээр гаргасан давуу эрхтэй хувьцаа	27	-	50,000,000
РЕПО хэлцлээс олсон орлого		3,439,794,977	2,065,957,687
РЕПО хэлцлийн эргэн төлөлт		(3,571,210,255)	(1,967,941,450)
Зээлийн бусад эх үүсвэрээс олсон орлого	23	395,226,792	527,864,616
Зээлийн бусад эх үүсвэрийн эргэн төлөлт	23	(89,115,105)	(453,252,951)
Түрээсийн үндсэн өр төлбөрийн эргэн төлөлт		(4,747,112)	-
Хоёрдогч өглөгөөс олсон орлого	26	80,000,000	-
Хоёрдогч өглөгийн эргэн төлөлт	26	1,732,849	(12,508)
Төлсөн ногдол ашиг		(9,009,657)	(5,178,170)
Бусад төлбөр		(9,649,500)	-
Санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгө		188,022,989	292,437,224
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө		47,056,670	(6,732,489)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт		283,192,110	41,875,436
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн тухайн тайлант хугацааны эхний үлдэгдэл		1,182,187,945	1,140,312,509
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн тухайн тайлант хугацааны эцсийн үлдэгдэл	7	1,465,380,055	1,182,187,945

Бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө шаардахгүй МИК-ТЗК-ийн хэлцлүүд нь Мөнгөн гүйлгээний тайланд ороогүй бөгөөд дэлгэрэнгүйг Тодруулга 10-с үзнэ үү.

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаанаас өмчлөх бусад хөрөнгө рүү, өмчлөх бусад хөрөнгөөс борлуулахад бэлэн эргэлтийн бус хөрөнгө болон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө рүү шилжсэн мөнгөн бус гүйлгээ нь энэ тайланд ороогүй (Тодруулга 14, 19 болон 20-с үзнэ үү).

7. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө (зайлшгүй байлгах нөөцөөс бусад)

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
Бэлэн мөнгө	104,767,167	114,855,783
Монголбанкинд байршуулсан мөнгө (заавал байлгах нөөцөөс бусад)	1,005,485,340	543,219,222
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	1,110,252,507	658,075,005

Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө (заавал байлгах нөөцөөс бусад) хөрөнгө нь барьцаа хөрөнгөөр баталгаажуулагддаг. 2019 оны 12 сарын 31 болон 2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн эрсдэлийн зэрэглэлд үндэслэн Монголбанкн дахь харилцах дансны зээлийн чанар нь “Хангалттай” бөгөөд Монголбанк нь Мүүди-с-ийн В3 үнэлгээтэй байсан.

Мөнгөн гүйлгээний тайланд тусгасан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан хөрөнгө (Тодруулга 7)	1,110,252,507	658,075,005
Гурван сараас бага хугацаатай Монголбанкны үнэт цаас (Тодруулга 11)	168,951,043	251,423,656
Бусад Банкуудад байршуулсан хөрөнгө (Тодруулга 10)	186,176,505	172,713,933
Урвуу РЕПО хэлцэл (Тодруулга 9)	-	99,975,351
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,465,380,055	1,182,187,945

Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжих зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл нь 2019 оны 12 сарын 31 болон 2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар “1-р үе шат”-д байна. Эдгээр үлдэгдлийн хүлээгдэж буй зээлийн алдагдал нь материаллаг биш хэмжээтэй тул Банк мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд ямар нэгэн зээлжих эрсдэлийн сан байгуулж хүлээн зөвшөөрөөгүй.

8 Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц	291,911,405	455,072,892
Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц	291,911,405	455,072,892

Банк нь Төв Банк буюу Монголбанкн дахь харилцах дансандаа Монголбанкнаас тавьдаг шаардлагын дагуу зайлшгүй байлгах нөөц байршуулдаг. Төв Банкн дахь байршуулдаг хөрөнгийн үлдэгдэл нь 14 хоногийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн 12.0% (2018: 12.0%)-аас багагүй байдаг.

Монголбанкны 2018 оны 3-р сарын 29-ний өдрийн тогтоолын дагуу Банк тайлант хугацаанд заавал байлгах нөөцийн 50 хувийг хангана.

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн эрсдэлийн зэрэглэлд үндэслэн Монголбанкн дахь харилцах дансны зээлжих чанар нь “Хангалттай” бөгөөд 2019 оны 12 сарын 31 болон 2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй.

Хүлээгдэж буй зээлжих эрсдэлийн санг хэмжих зорилгоор заавал байлгах нөөц нь 2019 оны 12 сарын 31 болон 2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар “1-р үе шат”-д байна.

Эдгээр үлдэгдлийн хүлээгдэж буй зээлийн алдагдал нь материаллаг бус хэмжээтэй тул Банк ямар нэгэн зээлжих эрсдэлийн сан байгуулж хүлээн зөвшөөрөөгүй.

9 Урвуу РЕПО хэлцэл

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Банкинд урвуу репо хэлцэл байгаагүй. Харин 2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар урвуу репо хэлцэл нь 9% хүүтэй, 3 хоногийн хугацаатай дотоодын банкттай хийсэн богино хугацаат хэлцэл байсан. Уг урвуу репо хэлцэл нь Монголбанкны үнэт цаасаар бүрэн баталгаажсан ба эргэн төлөлт хийгдээгүй тохиолдолд Банк гэрээгээр олгосон эрхийн дагуу тухайн үнэт цаасыг худалдан борлуулах, барьцаанд өгөх эрхтэй.

Мянган төгрөгөөр	1-р үе шат (12 сарын ХБ3А)
- Тусгай хяналттай	99,975,351
Нийт дансны үнэ	99,975,351
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	-
Дансны үнэ	99,975,351

Урвуу репо хэлцлийн хүлээгдэж буй зээлийн эрсдэлийн алдагдал нь материаллаг бус хэмжээтэй тул Банк ямар нэгэн зээлжих эрсдэлийн санг хүлээн зөвшөөрөөгүй.

10 Бусад банкуудад байршуулсан хөрөнгө

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
Бусад банкууд дахь харилцах данс		
Гадаад	175,105,319	153,173,299
Дотоод	10,776,841	19,540,634
Бусад банкуудад богино хугацаатай байршуулсан хөрөнгө		
Дотоод	-	-
Гадаад	294,345	-
Бусад банкуудад 3 сараас их хугацаатай байршуулсан хөрөнгө	720,388,204	413,423,859
Нийт бусад банкуудад байршуулсан хөрөнгө	906,564,709	586,137,792

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар бусад банкуудад байршуулсан 3 сараас их хугацаатай хөрөнгөд 180 хоногоос 2 жилийн хугацаатай харилцах дансууд багтсан. Уг хөрөнгийн томоохон өсөлт нь гадаадын санхүүгийн байгууллагаас зээл авсантай холбоотой барьцаанд байршуулсан 100 сая ам.доллартай холбоотой. (Тодруулга 23-ыг үзнэ үү).

2019 оны 12 сарын 31 болон 2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн эрсдэлийн зэрэглэлд үндэслэсэн бусад банкуудад байршуулсан хөрөнгийн зээлийн чанарын шинжилгээ болон хүлээгдэж буй зээлийн эрсдэлийн алдагдал хэмжих зорилгоор бусад банкуудад байршуулсан хөрөнгийг 3 үе шаттайгаар үнэлсэн үнэлгээг дор хүснэгтэд харуулав.

	2019 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын ХБ3А)	2018 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын ХБ3А)
Мянган төгрөгөөр		
- Маш сайн	713,235,351	142,996,216
- Сайн	106,050,640	5,748,221
- Хангалттай	77,443,459	159,395,049
- Тусгай хяналттай	10,674,661	277,998,306
Нийт дансны үнэ	907,404,111	586,137,792
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	(839,402)	-
Дансны үнэ	906,564,709	586,137,792

11 Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаас	169,387,815	365,684,251
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаас	106,342,392	119,425,772
Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаас	11,315,389	34,672,201
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	(109,874)	(840,166)
Нийт өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	286,935,722	518,942,058

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын хэмжилт болон ангиллуудыг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаас	Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаас	Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаас	Нийт
Монголбанкны үнэт цаас (а)	168,832,512	-	-	168,832,512
МИК бонд (б)	-	106,342,392	-	106,342,392
Засгийн газрын бонд (в)	555,303	-	11,315,389	11,870,692
2019 оны 12 сарын 31-нээрх нийт өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (үнэ цэнэ ба нийт дансны үнэ)	169,387,815	106,342,392	11,315,389	287,045,596
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	-	-	(109,874)	(109,874)
2019 оны 12 сарын 31-нээрх нийт өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (дансны үнэ)	169,387,815	106,342,392	11,205,515	286,935,722

2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын хэмжилт болон ангиллуудыг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаас	Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаас	Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаас	Нийт
Монголбанкны үнэт цаас (а)	365,146,307	-	-	365,146,307
МИК бонд (б)	-	111,962,492	-	111,962,492
Байгууллагын бонд (г)	-	-	23,385,734	23,385,734
Засгийн газрын бонд (в)	537,944	7,463,280	11,286,467	19,292,721
2018 оны 12 сарын 31-нээрх нийт өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (үнэ цэнэ ба нийт дансны үнэ)	365,684,251	119,425,772	34,672,201	519,782,224
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	-	-	(840,166)	(840,166)
2018 оны 12 сарын 31-нээрх нийт өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (дансны үнэ)	365,684,251	119,425,772	33,832,035	518,942,058

11 Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

(а) Монголбанкны үнэт цаас

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх Монголбанкны үнэт цаас нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон “гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон хөрөнгийг худалдах” бизнес загвартай хөрөнгө оруулалтын үнэт цаас юм.

(б) МИК бонд

Монголын ипотекийн корпорацийн бонд нь Банкнаас харилцагчидад олгосон ипотекийн зээлээр баталгаажсан ба гэрээгээр холбогдсон ипотекийн зээлтэй ижилхэн бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаасны ангилалд багтдаг. Банк нь анхны хүлээн зөвшөөрөлтөөс эхлэн ипотекийн зээлийг худалдах зорилготой байсан. Мөн энэхүү бонд нь МИК-ОССК-ийн үнэт цаасжуулах ажил гүйлгээтэй холбоотой ипотекийн зээлээр баталгаажсан “Энгийн” болон “Давуу” эрхтэй үнэт цаас (орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас “ОСЗБҮЦ”) юм.

Зөвхөн давуу эрхтэй үнэт цаасны үндсэн төлбөр бүрэн төлөгдсөн тохиолдолд энгийн эрхтэй үнэт цаасны үндсэн төлбөрийг авах боломжтой ба давуу эрхтэй үнэт цаас эзэмшигчид нь төлбөрийн хувьд давуу эрхтэй. МИК-ОССК-ийн цэвэр хөрөнгө нь дутсан тохиолдолд үүнийг давуу болон энгийн үнэт цаас эзэмшигчид хариуцна (төлбөр болон давуу эрхийн хувьтай тэнцүү хэмжээгээр).

(в) Засгийн газрын бонд

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор эзэмшиж буй “гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон хөрөнгийг худалдах” бизнес загвартай хөрөнгө оруулалтын үнэт цаас юм.

Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор эзэмшиж буй “гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах” бизнес загвартай хөрөнгө оруулалтын үнэт цаас юм.

Зайлшгүй шаарлагаар бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт нь Банк арилжааны ашиг олох зорилгоор эзэмшиж буй “хөрөнгийг худалдах” бизнес загвартай үнэт цаас юм. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед Банк Засгийн газрын бондыг бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх ангилалд хүлээн зөвшөөрсөн. Энэхүү Засгийн газрын бонд нь бодит үнэ цэнээр бүртгэгддэг бөгөөд зээлийн эрсдэлийн үнэ цэнийн бууралтыг мөн агуулна. Засгийн газрын бонд нь барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй.

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаас

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх Монголбанкны үнэт цаасны дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

	2019 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын хугацаанд ХБЗА)	2018 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын хугацаанд ХБЗА)
<i>Мянган төгрөгөөр</i>		
Монголбанкны үнэт цаас		
- Хангалтай	168,951,043	366,256,329
Хасах нь: Бодит үнэ цэнийн бууралт	(118,531)	(1,110,022)
Дансны үнэ (бодит үнэ цэнэ)	168,832,512	365,146,307

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 3 сараас бага хугацаатай Монголбанкны үнэт цаас 168,951,043 мянган төгрөг (2018: 251,423,656 мянган төгрөг) байсан ба мөнгөн гүйлгээний тайлан (Тодруулга 7)-д тусгах зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн тодруулгад орсон.

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх Засгийн газрын бондыг дор үзүүлэв:

	2019 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын хугацаанд ХБЗА)	2018 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын хугацаанд ХБЗА)
<i>Мянган төгрөгөөр</i>		
Засгийн газрын бонд		
- Хангалттай	561,586	542,973
Хасах нь: Бодит үнэ цэнийн бууралт	(6,283)	(5,029)
Дансны үнэ (бодит үнэ цэнэ)	555,303	537,944

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаасны зээлжих эрсдэлийн сан болон нийт дансны үнийн тайлант хугацааны эхэн болон эцсийн үлдэгдлийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

	Зээлжих эрсдэлийн сан 1-р үе шат (12 сарын хугацаанд ХБЗА)	Дансны үнэ 1-р үе шат (12 сарын хугацаанд ХБЗА)
<i>Мянган төгрөгөөр</i>		
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх Монголбанкны үнэт цаас		
2019 оны 01 сарын 01-нээрх	1,110,022	366,256,329
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан хөдөлгөөн:</i>		
Шинээр үүссэн ба худалдан авсан	118,531	4,055,601,043
Тайлант хугацаанд данснаас хасагдсан	(1,110,022)	(4,252,906,329)
2019 оны 12 сарын 31-нээрх	118,531	168,951,043
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх Засгийн газрын бонд		
2019 оны 01 сарын 01-нээрх	5,029	542,973
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан хөдөлгөөн:</i>		
Шинээр үүссэн ба худалдан авсан	1,254	-
Нийт дансны үнэ	6,283	542,973
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулаагүй хөдөлгөөн:</i>		
Гадаад валютын ханшийн зөрүү болон бусад хөдөлгөөн	-	18,613
2019 оны 12 сарын 31-нээрх	6,283	561,586

11 Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаасны зээлжих эрсдэлийн сан болон нийт дансны үнийн тайлант хугацааны эхэн болон эцсийн үлдэгдлийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

	Зээлжих эрсдэлийн сан 1-р үе шат (12 сарын хугацаанд ХБ3А)	Дансны үнэ 1-р үе шат (12 сарын хугацаанд ХБ3А)
<i>Мянган төгрөгөөр</i>		
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх Монголбанкны үнэт цаас		
2018 оны 01 сарын 01-нээрх	283,643	632,003,148
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан хөдөлгөөн:</i>		
Шинээр үүссэн ба худалдан авсан	1,110,023	11,239,722,329
Тайлант хугацаанд данснаас хасагдсан	(283,644)	(11,505,469,148)
2018 оны 12 сарын 31-нээрх	1,110,022	366,256,329
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх Засгийн газрын бонд		
2018 оны 01 сарын 01-нээрх	38,382	29,467,287
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан хөдөлгөөн:</i>		
Тайлант хугацаанд данснаас хасагдсан	(33,353)	(28,968,439)
Нийт дансны үнэ	5,029	498,848
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулаагүй хөдөлгөөн:</i>		
Гадаад валютын ханшийн зөрүү болон бусад хөдөлгөөн	-	44,125
2018 оны 12 сарын 31-нээрх	5,029	542,973

Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаас

Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаасны дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

	2019 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын хугацаанд ХБ3А)	2018 оны 12 сарын 31 1-р үе шат (12 сарын хугацаанд ХБ3А)
<i>Мянган төгрөгөөр</i>		
Засгийн газрын бонд		
- Хангалттай	11,315,389	11,286,467
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	(109,874)	(102,223)
Дансны үнэ (бодит үнэ цэнэ)	11,205,515	11,184,244
Байгууллагын бонд		
- Хангалттай	-	23,385,734
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	-	(737,943)
Дансны үнэ (бодит үнэ цэнэ)	-	22,647,791
Нийт хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаас (нийт дансны үнэ)	11,315,389	34,672,201
Хасах нь: Зээлжих эрсдэлийн сан	(109,874)	(840,166)
Нийт хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаас (дансны үнэ)	11,205,515	33,832,035

Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаасны зээлжих эрсдэлийн сан болон нийт дансны үнийн тайлант хугацааны эхэн болон эцсийн үлдэгдлийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Зээлийн алдагдлын сан 1-р үе шат (12 сарын хугацаанд ХБ3А)	Дансны үнэ 1-р үе шат (12 сарын хугацаанд ХБ3А)
Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх Засгийн газрын бонд		
2019 оны 01 сарын 01-нээрх	102,223	11,286,467
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан хөдөлгөөн:</i>		
Хүлээгдэж буй зээлжих эрсдэлийн сангийн хэмжилтийн загварын таамаглалд орсон өөрчлөлт	7,651	-
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	-	28,922
Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан нийт өөрчлөлт	109,874	11,315,389
Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх Байгууллагын бонд		
2019 оны 01 сарын 01-нээрх	737,943	23,385,734
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан хөдөлгөөн:</i>		
Данснаас хасагдсан	(705,177)	(21,781,922)
Хуримтлагдсан хүү	(32,766)	(1,603,812)
Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан нийт өөрчлөлт	-	-
2019 оны 12 сарын 31-нээрх нийт өөрчлөлт	109,874	11,315,389

Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаасны зээлжих эрсдэлийн сан болон нийт дансны үнийн тайлант хугацааны эхэн болон эцсийн үлдэгдлийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Зээлийн алдагдлын сан 1-р үе шат (12 сарын хугацаанд ХБ3А)	Дансны үнэ 1-р үе шат (12 сарын хугацаанд ХБ3А)
Хорогдуулсан өртгөөр хүлээн зөвшөөрөх Засгийн газрын бонд		
2018 оны 01 сарын 01-нээрх	449,616	11,260,142
<i>Тайлант хугацаан дахь зээлжих эрсдэлийн сангийн нөлөөг оруулсан хөдөлгөөн:</i>		
Хүлээгдэж буй зээлжих эрсдэлийн сангийн хэмжилтийн загварын таамаглалд орсон өөрчлөлт	(347,393)	-
Худалдсан	(8,708,657)	(436,939)	(109,409)	(3,281)	-	(305,079)	(9,563,365)
Данснаас хасагдсан	-	-	(651,898)	(110,357)	-	(19,656)	(781,911)
Тайлант жилийн элэгдэл	(3,390,412)	(255,911)	(4,753,852)	(358,296)	(998,947)	-	(9,757,418)
Шилжиж ирсэн/(шилжүүлсэн)	-	-	7,436	1,816	-	-	9,252
Худалдсан	-	285,165	109,409	3,281	-	-	397,855
Данснаас хасагдсан	-	-	673,705	89,615	-	-	763,320
Үнэ цэнийн бууралт	(26,600,000)	-	-	-	-	-	(26,600,000)
Дахин үнэлгээний цэвэр дүн	3,000,000	-	-	-	-	-	3,000,000
2018 оны 12 сарын 31-нээрх дансны үнэ	100,588,047	1,585,946	15,328,384	4,627,663	2,968,155	4,992,052	130,090,247
2019 оны 01 сарын 01-нээрх өртөг	115,434,205	3,028,891	48,718,462	7,465,253	5,654,044	4,992,052	185,292,907
Хуримтлагдсан элэгдэл	(14,846,158)	(1,442,945)	(33,390,078)	(2,837,590)	(2,685,889)	-	(55,202,660)
2019 оны 01 сарын 01-нээрх дансны үнэ	100,588,047	1,585,946	15,328,384	4,627,663	2,968,155	4,992,052	130,090,247
Нэмэгдсэн	3,740,861	731,500	23,781,906	675,861	2,395,262	-	31,325,390
Шилжиж ирсэн/(шилжүүлсэн)	-	(1,115)	4,309,290	33,422	-	(4,341,597)	-
Худалдсан	-	(121,986)	(177,242)	(20,414)	-	-	(319,642)
Данснаас хасагдсан	-	(397,228)	(2,354,793)	(239,793)	-	-	(2,991,814)
Тайлант жилийн элэгдэл	(2,907,744)	(305,640)	(8,145,581)	(470,859)	(2,185,692)	-	(14,015,516)
Шилжиж ирсэн/(шилжүүлсэн)	-	93	(4,797)	4,588	116	-	-
Худалдсан	-	80,332	177,242	16,386	-	-	273,960
Данснаас хасагдсан	-	384,600	1,531,472	228,029	-	-	2,144,101
Дахин үнэлгээний цэвэр дүн	1,242,104	-	-	-	-	-	1,242,104
2019 оны 12 сарын 31-нээрх дансны үнэ	102,663,268	1,956,502	34,445,881	4,854,883	3,177,841	650,455	147,748,830

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлсэн. Үнэлгээг хараат бус бие даасан үнэлгээний байгууллага болох М.А.Д ХХК (M.A.D LLC) болон Гэрэгэ Эстимэйт ХХК (Gerege Estimate LLC) зэрэг мэргэжлийн зэрэгтэй, ижил төрлийн болон ойролцоо байршилтай хөрөнгийг үнэлж байсан туршлагатай байгууллагуудаар үнэлүүлсэн. Үнэлгээний гол суурь нь Улаанбаатар хотод байршилтай ижил төрлийн барилга байгууламжийн зах зээлийн үнэ юм. Улмаар Банк нь 1,242,104 мянган төгрөгийн үнэ цэнийн өсөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн.

2019 оны 12 сарын 31-ний байдлаар барилга байгууламжийг элэгдэл хассан өртгийн аргаар бүртгэсэн бол дансны үнэ нь 110,059,260 мянган төгрөг (2018: MNT 93,626,138 мянган төгрөг) байх байсан.

Барилга байшингийн дансны үнийн задаргааг дор харуулав:

<i>Мянган төгрөгөөр</i>	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
Балансын тайланд тусгасан барилга байшингийн дахин үнэлсэн дүн	102,663,268	100,588,047
Өөрийн хөрөнгөнд тусгасан дахин үнэлгээний сан	7,746,670	(6,855,242)
Хуримтлагдсан ашиг руу шилжсэн дахин үнэлгээний сан	(350,676)	(106,667)
Хуримтлагдсан элэгдлийг хассан барилга байгууламжийн өртөг	110,059,262	93,626,138

18 Ашиглах эрхтэй хөрөнгө

Банк нь оффис, АТМ-н талбай, гараж болон архивын зориулалттай талбай түрээслэдэг. Түрээсийн гэрээ нь ихэвчлэн 1-5 жилийн тогтмол хугацаатай хийгддэг ба зарим нь дор дурдсаны дагуу сунгах нөхцөлтэй байдаг.

2018 оны 12 сарын 31 хүртэл үндсэн хөрөнгийн түрээс нь үйл ажиллагааны түрээсийн ангилалтай байсан бол Банк нь 2019 оны 1 сарын 1-ээс эхлэн түрээсийн хөрөнгийг ашиглах эрх нь тодорхой болсон үед ашиглах эрхтэй хөрөнгө ба холбогдох түрээсийн өр төлбөрөөр хүлээн зөвшөөрсөн.

Ашиглах эрхтэй хөрөнгийг төрлөөр нь ангилан дор үзүүлэв:

<i>Мянган төгрөгөөр</i>	Барилга	Бусад	Нийт
2019 оны 1 сарын 1-нээрх дансны үнэ	7,422,405	1,512	7,423,917
Нэмэгдсэн	2,582,021	3,124	2,585,145
Элэгдлийн зардал	(3,744,907)	(1,404)	(3,746,311)
2019 оны 12 сарын 31-нээрх дансны үнэ	6,259,519	3,231	6,262,751

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар түрээсийн өр төлбөрөөс тооцогдсон хүүгийн зардал 851,077 мянган төгрөг, түрээсийн зардалтай холбоотой НӨАТ-н зардал 312,608 мянган төгрөг байсан.

Удирдлагын болон үйл ажиллагааны зардалд богино хугацаатай түрээс багтсан ба богино хугацаат түрээсийн ангилалд багтаагүй бага үнэ цэнэтэй түрээс мөн орсон.

<i>Мянган төгрөгөөр</i>	2019 оны 12 сарын 31
Богино хугацаатай түрээсийн зардал	2,689,548
Бага үнэ цэнэтэй түрээсийн зардал	-

2019 онд нийт түрээсийн эргэн төлөлт нь 7,299,303 мянган төгрөг байсан.

Түрээсийн гэрээнд түрээслүүлэгчийн эзэмшдэг түрээсийн хөрөнгийн аюулгүй байдлын ашиг сонирхлоос бусад гэрээгээр хүлээх үүрэг байхгүй болно. Түрээслсэн хөрөнгийг зээлийн барьцаа болгон ашиглаж болохгүй.

Банкны хэд хэдэн хөрөнгийн түрээс нь сунгах болон цуцлах хугацааны сонголттой байдаг. Эдгээр нь Энэхүү сонголт нь Банкны үйл ажиллагаанд ашиглагдаж буй хөрөнгийн уян хатан байдлыг нэмэгдүүлэхэд ашигладаг. Түрээсийн гэрээний хугацааг сунгах болон цуцлах сонголтын дийлэнх эрхийг зөвхөн Банк эзэмшдэг.

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар түрээсийн хугацааг цуцлах эсвэл сунгах нөхцлийг хэрэгжүүлэх нь тодорхой ба үүнтэй холбоотойгоор 165,584 мянган төгрөгийн (хямдруулаагүй) ирээдүйн мөнгөн урсгал түрээсийн өр төлбөрийн дүнд багтсан.

19 Өмчлөх бусад хөрөнгө

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
Бодит үнэ цэнээр илэрхийлэх санхүүгийн хөрөнгө	131,581,132	35,687,446
Өртгөөр бүртгэсэн санхүүгийн бус хөрөнгө	25,814,241	62,348,741
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан	(6,077,773)	(8,134,870)
Нийт өмчлөх бусад хөрөнгө	151,317,600	89,901,317

Өмчлөх бусад хөрөнгө гэдэг нь хугацаа хэтэрсэн зээлийн өрөнд хураагдсан барьцаа хөрөнгө болох үл хөдлөх хөрөнгийг хэлнэ. Банкны зүгээс эдгээр хөрөнгийг ойрын хугацаанд зарж борлуулах төлөвлөгөөтэй байгаа. Үнэт цаас зэрэг санхүүгийн хөрөнгө хэлбэрээр түр хугацаагаар авсан барьцаа хөрөнгийг СТОУС-н хэмжилтийн зорилгоор тэдгээрийг өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт гэж ангилж, бодит үнэ цэнээр нь хэмждэг. Эдгээр хөрөнгийг бүртгэхдээ анхны бичилтийг борлуулах зардлыг хассан бодит үнээр нь хүлээн зөвшөөрсөн.

2019 онд Банкны удирдлагын шийдвэрийн дагуу 126,392,250 мянган төгрөгийн (2018: MNT 98,226,084 мянган төгрөг) өмчлөх бусад хөрөнгийг хугацаа хэтэрсэн зээлийн өрөнд хураан авч, 75,217,941 мянган төгрөгийн (2018: MNT 31,165,516 мянган төгрөг) өмчлөх бусад хөрөнгийг борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгө рүү дахин ангилсан.

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө нь Банкны хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг барагдуулах явцад хураан авсан 3 компанийн (өмчийн үнэт цаас) хувьцаа юм. Одоогийн байдлаар Банк нь эдгээр 3 компанийн нэгнийх нь хувьцааг зарахаар хэлэлцээр хийж байна.

Өртгөөр бүртгэсэн санхүүгийн бус хөрөнгө нь хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг барагдуулах явцад хураан авсан үндсэн хөрөнгө юм. Дээрх үнэ цэнийн бууралтын сан нь зөвхөн санхүүгийн бус хөрөнгөтэй холбоотой.

2019 болон 2018 онд өмчлөх бусад хөрөнгөд хураан авсан санхүүгийн бус барьцаа хөрөнгийн үнэ цэнийн бууралтын санд гарсан өөрчлөлтийг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2019	2018
01 сарын 01-ний өдрөөрх өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан	8,134,870	2,401,216
Тайлант жилд байгуулсан үнэ цэнийн бууралтын сан	13,134,432	6,546,401
Борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгөөс шилжиж ирсэн хөрөнгийн сан	290,376	1,579,785
Тайлант жилд төлөгдөхгүй хэмээн данснаас хасагдсан	(15,481,905)	(2,392,532)
12 сарын 31-ний өдрөөрх өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан	6,077,773	8,134,870

20 Борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгө

124

Борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгөд өмнө нь хугацаа хэтэрсэн зээлийн өрөнд хураан авсан өмчлөх бусад хөрөнгөд бүртгэлтэй байсан үл хөдлөх хөрөнгүүд багтана. Удирдлагын зүгээс ангилал шилжүүлэх бүрд борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгийг худалдах төлөвлөгөө гаргасан. Банк эдгээр хөрөнгүүдийг борлуулахын тулд худалдан авагчийг идэвхтэй хайж байгаа ба борлуулалтыг 12 сарын дотор хийж дуусгахаар ажиллаж байна.

Борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгийн үндсэн ангиллуудыг дор харуулав:

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
Орон сууц ба байшин	37,137,820	22,160,668
Барилга байгууламж	3,000,000	6,515,813
Оффис ба худалдааны зориулалттай газар	16,942,504	5,985,115
Тоног төхөөрөмж	-	100,219
Бусад	45,000	15,274
Нийт борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгө	57,125,324	34,777,089

21 Бусад банкнуудын байршуулсан хөрөнгө

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
Бусад банкнуудын байршуулсан богино хугацаат хөрөнгө	20,070,762	10,421,840
Бусад банкнуудын байршуулсан урт хугацаат хөрөнгө	32,857,750	138,344,887
Нийт бусад банкнуудын байршуулсан хөрөнгө	52,928,512	148,766,727

Бусад банк, санхүүгийн байгууллагуудын байршуулсан хөрөнгө нь дотоодын болон гадаадын банкнуудын Банкинд гадаад болон дотоодын валютаар үүсгэсэн харилцах болон хадгаламжийн дансуудаас бүрдэнэ. Бусад банкнуудын байршуулсан хөрөнгийн бууралтын дийлэнх хувь хэмжээ нь Монгол Улсын Хөгжлийн Банк болон Өвөр Монголын Банкны урт хугацаат хөрөнгөтэй холбоотой.

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар богино хугацаат харилцах, хадгаламжид дотоод болон гадаад банкнуудын байршуулсан жилийн 6.8%-с 12% (2018: 2%-с 8.5%)-н хүүтэй, 30-с 180 хоног (2018: 90-с 255)-ийн анхны дуусгавар хугацаатай харилцах, хадгаламжууд орно.

22 Харилцагчийн харилцах, хадгаламж

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
Хувь хүмүүс	2,683,544,463	2,537,012,206
- Харилцах данс	205,586,435	223,296,003
- Хугацаагүй хадгаламж	433,531,162	449,762,246
- Хугацаат хадгаламж	2,044,426,866	1,863,953,957
Аж ахуйн нэгж	1,415,945,338	1,206,238,193
- Харилцах данс	1,001,280,367	806,226,749
- Хугацаагүй хадгаламж	59,107,295	53,246,389
- Хугацаат хадгаламж	355,557,676	346,765,055
Төрийн болон хувьцаат компани	749,455,811	600,166,091
- Харилцах данс	598,852,742	421,317,586
- Хугацаагүй хадгаламж	26,940,128	162,976,504
- Хугацаат хадгаламж	123,662,941	15,872,001
Бусад	51,696,010	59,231,857
- Харилцах данс	33,757,181	29,505,266
- Хугацаагүй хадгаламж	858,825	476,317
- Хугацаат хадгаламж	17,080,004	29,250,274
Нийт харилцагчийн харилцах, хадгаламж	4,900,641,622	4,402,648,347

22 Харилцагчийн харилцах, хадгаламж (үргэлжлэл)

Монгол Улсын Иргэний хуулийн дагуу Банк нь харилцах, хадгаламж эзэмшигчдийн хадгалуулсан мөнгийг шаардсан үед нь эргүүлэн төлөх үүрэг хүлээсэн байдаг. Хэрэв хадгаламж эзэмшигч хугацаатай хадгаламжаа хугацаанаас нь өмнө буцаан татсан тохиолдолд гэрээнд өөрөөр заагаагүй бол Банк хүүг хугацаагүй хадгаламжийн хүүгээр тооцож олгоно.

Одоогийн байдлаар Банкны удирдлага нь харилцагчдын харилцах, хадгаламжийг эдийн засгийн салбарын төвлөрлөөр нь хяналт хийдэггүй. Иймээс үүнтэй холбоотой мэдээллийг санхүүгийн тайлангуудад тусгаагүй. 2019 оны 12 сарын 31-ний өдрөөр 30 том харилцагчаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн нийт дүн 1,457,335,939 мянган төгрөг (2018: MNT 1,237,360,831 мянган төгрөг) бөгөөд нийт харилцах хадгаламжийн 30% (2018: 20%-г бүрдүүлж байна.

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар буцаах эрхгүй Банкны баталгааны барьцаа болгон 30,671,623 мянган төгрөг (2018: MNT 24,303,006 мянган төгрөг)-н хадгаламжийг харилцагчдаас байршуулсан.

23 Зээлийн бусад эх үүсвэр

	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
<i>Мянган төгрөгөөр</i>		
(а) Төслийн зээлийн эх үүсвэр		
Төслийн зээлийн эх үүсвэр /Төгрөг/	228,664,832	283,821,469
Төслийн зээлийн эх үүсвэр /Доллар/	307,940	394,699
Төслийн зээлийн эх үүсвэр /Евро/	180,286	351,848
Нийт төслийн зээлийн эх үүсвэр	229,153,058	284,568,016
(б) Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр		
Гадаадын банкнаас авсан эх үүсвэр /Доллар/	538,666,774	270,858,492
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр		
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр /Доллар/	109,553,747	122,442,026
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр /Евро/	35,429,480	21,410,285
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр /Иен/	2,110,565	13,577,630
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр /Юань/	1,118,538	2,996,334
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр /Фунт Стерлинг/	-	-
Нийт гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр	686,879,104	431,284,767
Нийт (а+б)	916,032,162	715,852,783

(а) Төслийн зээлийн эх үүсвэр

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
Засгийн газрын үнэ тогтворжуулах хөтөлбөр		
Орон сууцжуулах хөтөлбөр	132,474,795	161,558,852
Бусад төслийн эх үүсвэр	1,320,500	1,321,079
КФВ Банкны төслийн эх үүсвэр	851,287	1,782,219
Монгол Улсын Хөгжлийн Банкны төсөл		
Үндэсний ноолуурын үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	42,886,928	36,127,923
ҮХААЯам арьс, шир боловсруулах төслийн эх үүсвэр	5,385,350	9,919,768
Мах боловсруулах үйлдвэрлэлийг өргөжүүлэх төслийн эх үүсвэр	2,905,297	3,955,772
Бусад төслийн эх үүсвэр	1,425,390	4,808,919
Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төслийн эх үүсвэр	-	7,719,637
Монгол Улсын Засгийн газар болон ЖАЙКА-н хамтарсан төсөл		
Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	9,921,098	14,235,098
Бусад Засгийн газрын төсөл		
Хөдөө Аж Ахуй болон Хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	29,963,289	18,911,045
Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	1,652,842	2,923,663
Бусад төслийн эх үүсвэр	307,940	403,123
Оюутны хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	53,158	128,509
40,000 айлыг орон сууцжуулах хөтөлбөрийн эх үүсвэр	5,184	7,726
Хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих төслийн эх үүсвэр	-	20,016,730
Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төслийн эх үүсвэр	-	747,953
Нийт төслийн зээлийн эх үүсвэр	229,153,058	284,568,016

Монгол Улсын Засгийн газар, Төв Банк болон гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэрийн гол нөхцөлүүдийг дор дурдав.

Эдгээр зээлийн эх үүсвэрийн дийлэнх нь Монгол Улсын Засгийн газрын эсвэл зээл олгогчийн тодорхойлсон тусгай зориулалттай (хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг зорилтод харилцагчдад олгох) зээлүүд байдаг. Иймээс эдгээр эх үүсвэрийн хүүний хувь нь бага буюу Банк нь өөр зээлдэгчээс энгийн нөхцөлөөр эх үүсвэр татах хүүнээс доогуур байдаг. Эдгээр бусад зээлийн эх үүсвэрүүдийн ихэнх нь жилийн 1.2%-с 13.15%-н хүүтэй, харин эдгээр эх үүсвэрээс олгож буй зээлүүдийн ихэнх нь жилийн 5%-с 13%-н хүүтэй. Удирдлагын зүгээс эдгээр зээлсэн эх үүсвэрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн олзыг хүлээн зөвшөөрөх эсхийг бодож үзсэн ба тусгай зах зээлийн шинжийг хангаж байгаа учраас эдгээр эх үүсвэр болох харилцагчдад олгосон зээлээс ямар нэгэн анхны хүлээн зөвшөөрөлтийн олз, гарз бүртгэхгүй гэж үзсэн. Томоохон төсөл хөтөлбөрүүдэд Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө бүхий салбарт (эдийн засгийг тэлэх) зориулсан Монгол Улсын Хөгжлийн Банкны санхүүжилтүүд багтана. Эдгээр хөтөлбөрүүдийг дор товчхон дурдвал:

Орон сууцны зээлийг санхүүжүүлэх Засгийн газрын хөтөлбөрийн дагуу Банк 2014, 2015 болон 2016 онд 4%-н хүүтэй эх үүсвэрийг Монголбанкнаас хүлээн авсан. Энэ хөтөлбөрт тусгай шаардлага хангасан (80 квадрат метрээс бага хэмжээтэй байр, худалдан авах үнийн дүнгийн 30% тэнцэх урьдчилгаа, тухайн Банк болон бусад банкин дахь зээлийн түүх сайн гэх мэт) шинэ болон хуучин олгогдсон зээлүүдийг дахин санхүүжүүлэх боломжтой зээлүүд багтана.

Ийнхүү Банк нь зээлдүүлэгчийн шаардлагыг хангасан зээлдэгч нарт 8%-н хөнгөлөлттэй зээлийг олгох боломжтой болсон ба энэхүү хүүний түвшинг Монголбанкнаас тогтоож өгсөн тул олгож буй зээлийн хүүг Банк тодорхойлох эрхгүй. Хөтөлбөрийн дагуу олгогдох зээлийн саналыг болон 8%-с доош олгосон зээлийн дахин санхүүжилтийг Банкнаас хэлэлцэж батлах ба Банк зээлийн эрсдэлийг мөн үүрэх юм.

2018 онд Банк нь Монгол Улсын Хөгжлийн Банкаар дамжуулан түүхий эд материалын үйлдвэрлэлийг бий болгох зорилгоор Засгийн газрын “Үндэсний ноолуурын үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр”-т оролцож байгаа. Уг эх үүсвэр нь жилийн 10%-н хүүтэй, 2019 оны 12 сарын 15-ны өдөр дуусгавар болно. Банк нь уг төслийн хүрээнд жилийн 12%-с 13%-н хөнгөлөлттэй хүүтэй, зах зээлийн эргэлтийн хөрөнгийн зээлийг харилцагчдад олгодог. 2019 онд уг хөтөлбөрийн хугацаа дууссан боловч талууд 2021 оны 12 сарын 27-ны өдрийг хүртэл хугацааг сунгасан.

23 Бусад зээлийн эх үүсвэр (үргэлжлэл)**(а) Төслийн зээлийн эх үүсвэр (үргэлжлэл)**

2014 оны 7 сараас хойш Банк нь Монгол Улсын Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй “Арьс, ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих” зорилготой Засгийн газрын өөр нэг төсөлд оролцож байна. Энэхүү хөтөлбөрийн нөхцөлийн дагуу Банк нь уг эх үүсвэрийг Монгол Улсын Хөгжлийн Банкнаас жилийн 5%-н хүүгээр авч, харилцагчдад жилийн 7%-н хүүтэй олгодог. Бүх зээлдэгчдийг Хүнс, Хөдөө Аж Ахуйн яамнаас батлах ба Банк энэхүү зээлийн эрсдэлийг үүрдэг.

Түүнчлэн Банк Монгол Улсын Хөгжлийн Банк болон арилжааны банкуудаар дамжуулах Засгийн Газрын “Монгол Улсын экспортыг дэмжих, импортыг орлох зорилготой 888 хөтөлбөр”-т оролцож байгаа. Уг гэрээний дагуу Банк нь 5 жилийн хугацаатай, жилийн 3%-с 5% хүртэлх хүүтэй эх үүсвэр авч жилийн 7%-с 9% хүртэлх хөнгөлөлттэй хүүтэй зээл олгож байна. Банк нь дээрх тогтоосон босго хүүгийн хүрээнд зээлийн хүүг тодорхойлох эрхтэй бөгөөд холбогдох зээлийн эрсдэлийг хариуцна. 2019 онд уг хөтөлбөр дуусаж, Банк нь гэрээний дагуу эх үүсвэрийн төлөх ёстой бүх үлдэгдлээ бүрэн төлж барагдуулсан.

2017 оны 02 сарын 10-нд Засгийн Газраас хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих төслийн хөтөлбөрт оролцож байгаа. Төслийн хүрээнд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор хувь хүмүүст жижиг болон дунд хэмжээний зээлийг 2 жилийн хугацаатай 3%-н хүүтэй олгох эрхтэй санхүүжилтийг Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газраас хүлээн авсан. Банк нь энэхүү зээлийн эрсдэлийг үүрнэ. 2019 онд уг хөтөлбөр дуусаж, Банк нь гэрээний дагуу эх үүсвэрийн төлөх ёстой бүх үлдэгдлээ бүрэн төлж барагдуулсан.

Банк Монгол Улсын Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй Засгийн газраас санхүүжилттэй хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хөтөлбөрт оролцож байгаа. Уг хөтөлбөрийн хүрээнд Банк нь хүлэмжийн аж ахуй, сүү, сүүн бүтээгдэхүүн, оёдол, ноолууран бүтээгдэхүүний технологийг сайжруулах болон ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг жижиг, дунд бизнесийг санхүүжүүлэх зорилготой Монгол Улсын Хөгжлийн Банктай гэрээнд гарын үсэг зурсан. Энэ гэрээний дагуу Банк жилийн 5.13%-с 5.7% хүртэлх хүүтэй эх үүсвэр авч гэрээнд заасны дагуу жилийн 8%-н хөнгөлөлттэй хүүтэй зээлийг харилцагчдад олгосон. Банк энэхүү зээлийн эрсдэлийг мөн үүрнэ.

Мөн Засгийн газрын хэрэгжүүлж буй Монгол Улсын экспортыг дэмжих, импортыг орлох зорилготой хөтөлбөрийн хүрээнд Банк Монгол Улсын Хөгжлийн Банктай жижиг, дунд бизнесийн төслүүдийг дэмжих гэрээнд гарын үсэг зурсан. Уг хөтөлбөрийн хүрээнд Банк жилийн 6%-н хүүтэй, 2019 оны 03 сарын 05-ны өдөр хүртэлх хугацаатай эх үүсвэрийг авсан. Банк зорилтод харилцагчдад зээл олгохдоо жилийн 9% хүртэлх хүүг тогтоох эрхтэй. 2019 онд уг хөтөлбөр дуусаж, Банк нь гэрээний дагуу эх үүсвэрийн төлөх ёстой бүх үлдэгдлээ бүрэн төлж барагдуулсан.

Категори	Зээл олгогч	Төслийн нэр	Валют	Олгосон огноо	Дуусах огноо	2019 оны 12 сарын 31-ний өдрөөрх зээлийн дүн /тухайн валютаар/	2019 оны 12 сарын 31-ний өдрөөрх зээлийн дүн /төгрөгөөр/
Засгийн газрын үнэ тогтворжуулах хөтөлбөр	Монголбанк	Орон сууцжуулах хөтөлбөр	Төгрөг	6/14/2013	12/25/2020	132,474,795	132,474,795
	Монголбанк	Бусад төслийн эх үүсвэр	Төгрөг	2/24/2015	5/9/2020	1,320,500	1,320,500
	Монголбанк	КФВ Банкны төслийн эх үүсвэр	Төгрөг	5/16/2013	12/27/2021	671,000	671,000
	Монголбанк	КФВ Банкны төслийн эх үүсвэр	Евро	12/11/2012	12/27/2020	59	180,287
Монгол Улсын Хөгжлийн Банкны төсөл	Монгол Улсын Хөгжлийн банк	Үндэсний ноолуурын үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	Төгрөг	7/5/2018	12/27/2021	42,886,928	42,886,928
	Монгол Улсын Хөгжлийн банк	ҮХААЯам арьс, шир боловсруулах төслийн эх үүсвэр	Төгрөг	8/22/2014	6/25/2021	5,385,350	5,385,350
	Монгол Улсын Хөгжлийн банк	Мах боловсруулах үйлдвэрлэлийг өргөжүүлэх төслийн эх үүсвэр	Төгрөг	3/25/2016	2/28/2020	2,905,297	2,905,297
	Монгол Улсын Хөгжлийн банк	Экспортыг дэмжих, импортыг орлох төслийн эх үүсвэр /300 тэрбум төгрөг хүртэл/	Төгрөг	9/28/2015	11/7/2020	1,425,390	1,425,390
ЗГ болон Японы ОУ-ын хамтын ажиллагааны агентлагийн хамтарсан төсөл	ЖАЙКА	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	Төгрөг	6/12/2009	6/1/2028	9,921,098	9,921,098
Засгийн газрын бусад төсөл	Засгийн газар	Хөдөө аж ахуй болон хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	Төгрөг	2/10/2011	10/1/2025	29,963,289	29,963,289
	Засгийн газар	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	Төгрөг	6/12/2015	1/10/2021	1,652,842	1,652,842
	Засгийн газар	Оюутны хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	Төгрөг	11/30/2016	11/30/2026	53,158	53,158
	Засгийн газар	40,000 айлыг орон сууцжуулах хөтөлбөрийн эх үүсвэр	Төгрөг	2/27/2008	1/19/2022	5,187	5,184
	Засгийн газар	Бусад төслийн эх үүсвэр	Доллар	4/1/2010	5/1/2027	113	307,940

(б) Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр

Гадаадын банкнаас авсан эх үүсвэрт гадаадын банк, санхүүгийн байгууллагаас тус бүр 2018 оны 09 сарын 27-нд авсан 60 сарын хугацаатай 100,000 мянган ам.доллар, 2019 оны 03 сарын 28-нд авсан 60 сарын хугацаатай 100,000 мянган ам.долларын зээл болон 2017 оны 09 сарын 26-нд авсан 97 сарын хугацаатай 7,500 мянган ам.долларын зээлүүд багтана. Уг зээлүүд нь тухайн банкин дахь Банкны харилцах дансаар баталгаажсан (Тодруулга 10).

2019 онд Банк нь 7,500 мянган ам.долларын зээлийн 1,339 мянган ам.долларыг эргүүлэн төлсөн.

Банк нь өөрийн харилцагчийн худалдааны зээлийг санхүүжүүлэх зорилгоор гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас худалдааны зээлийн шугам авсан. 2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 100,102,203 мянган төгрөгийн (2018: MNT 159,380,055 мянган төгрөг) зээлийн шугамыг ашиглаж мөн тэр хэмжээний зээлийг харилцагчдад олгосон. Ийм төрлийн эх үүсвэрийн хугацаа нь 4 хүртэлх жил байдаг бөгөөд харилцагчдаас орж ирэх мөнгөн урсгалын хугацаа болон гадаадын банк, санхүүгийн байгууллагад эргэн төлөх мөнгөн урсгалын хугацаа нь таарч байна. Харилцагч зээлээ төлж чадахгүй тохиолдолд Банк зээлийн эрсдэлийг хариуцдаг. Худалдааны эх үүсвэрийн өсөлт нь бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас болон гадаадын банкнаас шинээр Доллар болон Еврогоор авсан санхүүжилттэй холбоотой.

Эдгээр гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эх үүсвэрүүд нь гэрээний дагуу хүлээсэн үүрэгтэй ба 2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар ямар нэгэн биелүүлэх шаардлагатай гэрээгээр хүлээсэн үүрэг зорчигдөөгүй.

24 РЕПО хэлцэл

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар дотоодын банк, санхүүгийн байгууллагаас авсан Repo хэлцэлд 11% хүү (2018: 11%-с 13%)-тэй, 28 хоног (2018: 2-с 28 хоног)-ийн анхны дуусгавар хугацаатай Repo хэлцлүүд орно. Эдгээр Repo хэлцлүүд нь Монголбанкны үнэт цаасаар бүрэн баталгаажсан. Дэлгэрэнгүйг Тодруулга 11-с харна уу.

25 Бусад өр төлбөр

Бусад өр төлбөрийг дэлгэрэнгүйг дор үзүүлэв

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
Хорогдуулсан өртгөөр хэмжих бусад санхүүгийн өр төлбөр:	100,127,218	29,437,983
Буцаах нөхцөлтэй МИК-д худалдсан зээлтэй холбоотой өр төлбөр	71,974,148	3,299,435
Гүйлгээний өр төлбөр	20,171,704	15,906,110
Бусад	6,025,535	5,503,688
Дансны өглөг	1,955,831	4,728,750
Бусад санхүүгийн бус өр төлбөр:	6,028,921	17,148,125
Орлогын албан татвараас бусад татварын өглөг	2,521,925	5,251,595
Аккредитив, баталгааны эрсдэлийн сан	1,937,760	3,399,224
Ажилтнуудад өгөх өглөг	1,430,948	5,363,580
Ногдол ашгийн өглөг	-	3,133,726
Бусад	138,288	-
Нийт бусад өр төлбөр	106,156,139	46,586,108

2019 онд Банк 8%-н орон сууцны зээлийг буцаах нөхцөлтэй худалдах МИК-ийн мөнгөжүүлэх ажил гүйлгээнд нэг удаа оролцсон. Банк МИК-д 70 тэрбум төгрөгийн 8%-н орон сууцны зээлийн багцаа зарж 16.5%-н хүүтэй эх үүсвэр авсан. Эдгээр МИК-д худалдсан 8%-н орон сууцны зээлтэй холбоотой эрсдэл, өгөөжийг Банк хариуцна.

Гүйлгээний өр төлбөрийн өсөлт нь 2019 оны 12 сарын сүүлчийн өдрүүдэд харилцагчийн хүсэлтийн дагуу 2020 оны 01 сарын эхээр бусад банкууд руу хийгдсэн шилжүүлгийн гүйлгээтэй холбоотой. Иймээс харилцагчийн данснаас уг гүйлгээнүүдийн дүн хасагдаж бусад өр төлбөрийн хэсэг болох "Гүйлгээний төлбөр"-ийн тусгай дансанд 2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар орсон ба 2020 оны 01 сард Банк хоорондын тооцоогоор хийгдэж дууссан.

Банк зөвлөх үйлчилгээнээс 138,287 мянган төгрөгийн хойшлогдсон орлогыг хүлээн авсан. СТОУС 15-т заасны дагуу Банк нь зөвлөх үйлчилгээний ажил гүйлгээний үнийг гүйцэтгэлийн үүрэг тус бүрд хуваарилна.

Бусад санхүүгийн өр төлбөрийн дийлэнх нь тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор хийгддэг ба санхүүгийн бус бүх өр төлбөр нь шинж чанарын хувьд богино хугацаатай байдаг.

26 Хоёрдогч өглөг

Мянган төгрөгөөр	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
Голомт Файнэншил Группээс авсан хоёрдогч өглөг	172,027,616	92,582,956
Нийт	172,027,616	92,582,956

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх хоёрдогч өглөг:

Мянган төгрөгөөр	Дуусах огноо	Валют	Хүү /жилийн/	Тухайн валютаарх нэрлэсэн үнэ
Голомт Файнэншил Групп (I)	31/12/2024	Төгрөг	12.6%	80,000,000
Голомт Файнэншил Групп (II)	31/12/2024	Төгрөг	12.6%	80,000,000
Голомт Файнэншил Групп (III)	31/12/2024	Төгрөг	12.6%	12,000,000

Голомт Файнэншил Групп ХХК-с авсан хоёрдогч өглөг (I,II)

2019 оны 12 сарын 31-ний өдөр Банк нь Голомт Файнэншил Групп ХХК-с 5 жилийн хугацаатай 160 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөг авсан. Гэрээний гол нөхцөлүүдийг дор дурдав:

- (а) Зээлийн хүү нь жилийн 12.6%.
- (б) Зээл нь 2024 оны 12 сарын 31-ний өдөр үндсэн дүн болон хуримлагдсан хүүгийн хамт бүрэн төлөгдөнө.

Голомт Файнэншил Групп ХХК-с авсан хоёрдогч өглөг (III)

2019 оны 12 сард Банк Голомт Файнэншил Групп ХХК-с 5 жилийн хугацаатай 12 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөг авсан. Гэрээний гол нөхцөлүүдийг дор дурдав:

- (а) Зээлийн хүү нь жилийн 12.6%.
- (б) Зээл нь 2024 оны 12 сарын 31-ний өдөр үндсэн дүн болон хуримлагдсан хүүгийн хамт бүрэн төлөгдөнө.

Хувьцаа эзэмшигчид 2018 болон 2019 онд өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор анх эдгээр хоёрдогч өглөгүүдийг байршуулсан. 2019 оны 12 сарын 31-ний өдөр энгийн хувьцаа болон давуу эрхтэй хувьцаанаас хоёрдогч өглөг рүү буцаан шилжүүлсэн.

2019 оны 12 сарын 31 болон 2018 оны 12 сарын 31-ний өдрөөр эдгээр хоёрдогч өглөгүүдэд гэрээний дагуу заавал биелүүлэх шаардлагатай санхүүгийн болон бусад хүлэсэн үүрэг байхгүй.

27 Хувьцаат капитал

Хувьцааны тоо ширхэгээс бусад дүн нь Мянган төгрөгөөр	Нийт гаргасан хувьцаа	Энгийн хувьцаа	Нэмэгдэж төлөгдсөн капитал	Давуу эрхтэй хувьцаа	Нийт
2018 оны 01 сарын 01	26,367,593	26,367,593	46,583,557	25,778,900	98,730,050
Шинээр гаргасан хувьцаа	5,173,444	5,173,444	69,826,556	50,000,000	125,000,000
Хоёрдогч өглөгийн хөрвүүлэлт	780,820	780,820	11,219,180	-	12,000,000
2018 оны 12 сарын 31	32,321,857	32,321,857	127,629,293	75,778,900	235,730,050
2019 оны 01 сарын 01	32,321,857	32,321,857	127,629,293	75,778,900	235,730,050
Цуцалсан хувьцаа	(5,954,264)	(5,954,264)	(81,045,736)	(50,000,000)	(137,000,000)
Хоёрдогч өглөгийн хөрвүүлэлт	5,646,905	5,646,905	88,588,145	-	94,235,050
2019 оны 12 сарын 31	32,014,498	32,014,498	135,171,702	25,778,900	192,965,100

Банкны гаргасан хувьцаат капиталын нэрлэсэн үнээр бүртгэсэн дүн нь 32,014,498 мянган төгрөг (2018: MNT 32,321,857 мянган төгрөг) байсан.

Нэмэгдэж төлөгдсөн капитал нь шинээр гаргасан хувьцааг борлуулахад нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн төлбөр юм.

2019 онд нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 5,646,905 ширхэг энгийн хувьцаа шинээр гаргасан.

27 Хувьцаат капитал (үргэлжлэл)

Энгийн хувьцаа

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Банк нь нийт 32,014,498 ширхэг (2018: MNT 32,321,857 ширхэг) нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй (2018: 1,000 төгрөг) энгийн хувьцаа гаргасан. Голомт Файнэншил Групп ХХК-с авсан 25 сая ам.долларын хоёрдогч өглөг энгийн хувьцаанд хөрвөсөн ба нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнийн дүнгээс илүү төлөгдсөн төлбөрийг нэмэгдэж төлөгдсөн капиталаар хүлээн зөвшөөрсөн.

Магадлан баталгаажуулах аудитын үр дүнгээр Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар 45 тэрбум төгрөгийн энгийн хувьцааны зөвшөөрлийг цуцалж, 42 тэрбум төгрөгийн энгийн хувьцааны хөрөнгө оруулалтыг хоёрдогч өглөгт шилжүүлсэн.

2019 онд гаргасан хувьцааг дор хүснэгтээр үзүүлэв:

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Нэрлэсэн үнэ	Нэгж хувьцааны захиалгын үнэ	Огноо
Голомт Файнэншил Групп ХХК	5,646,905	1,000	16,688	10/22/2019
Голомт Файнэншил Групп ХХК	(2,245,367)	1,000	13,361	12/31/2019
Бодь Интернэшнл ХХК	(2,928,077)	1,000	15,368	10/22/2019
Голомт Файнэншил Групп ХХК	(780,820)	1,000	15,368	12/31/2019

2019 оны 10 сарын 22-нд хоёрдогч өглөгийг нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 5,646,905 ширхэг хувьцааг нэгж бүрийг нь 16,687,91 төгрөгийн захиалгын үнээр энгийн хувьцаанд хөрвүүлж Голомт Файнэншил Групп ХХК-д олгосон. Энгийн хувьцаа гаргахтай холбоотойгоор хувьцааны нэмж төлөгдсөн капитал дансанд 88,588,145 мянган төгрөг орсон. Шинээр гаргасан энгийн хувьцаа нь Банкны одоо байгаа энгийн хувьцаатай ижил түвшинд эрэмбэлэгдэнэ.

2019 оны 12 сарын 31 болон 2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх хувьцаа эзэмшигчдийн хувийг дор харуулав:

Хувьцаа эзэмшигч	2019 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
	Хувиар	Хувиар
Голомт Файнэншил Групп ХХК	86.63%	77.69%
Бодь Интернэшнл ХХК	0.00%	9.06%
Свисс Мо Инвестмент Ай Жи	8.22%	8.14%
Голомт Инвестмент ХХК	4.06%	4.02%
Ажилчдын хувьцаа	1.09%	1.08%
Нийт	100%	100%

Давуу эрхтэй хувьцаа

2013 оны 12 сарын 19-ний өдөр гаргасан 15 сая ам.доллар бүхий 25,778,900 мянган төгрөгийн давуу эрхтэй хувьцааг Ноён Зоригт (Ноён Баясгалангийн бизнес хамтрагч) эзэмшдэг ба 2013 оны 12 сарын 26-ны өдөр давуу эрхтэй хувьцааны гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон.

Давуу эрхтэй хувьцаа нь хугацаагүй болон ногдол ашиг хуримтлагддаггүй бөгөөд гэрээнд давуу эрхийн хувьцааг ТУЗ-н зөвшөөрөл дээр үндэслэн энгийн хувьцаанд хөрвүүлэх эрхтэй гэж заасан.

Банк нь 2018 оны 06 сарын 22-ны өдөр хугацаагүй болон ногдол ашиг хуримтлагддаггүй 50,000,000 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй давуу эрхтэй хувьцааг Голомт Файнэншил Групп ХХК-д гаргасан ба Монголбанкны шийдвэрийн дагуу уг давуу эрхтэй хувьцааг хоёрдогч өглөг рүү хөрвүүлсэн.

28 Хүүгийн орлого ба зардал

Мянган төгрөгөөр	2019	2018
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого		
Хорогдуулсан өртгөөр хэмжих харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	470,513,477	389,853,131
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаас	41,537,995	45,938,702
Хорогдуулсан өртгөөр хэмжих бусад банкуудад байршуулсан хөрөнгө	20,652,385	10,664,550
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	18,536,242	11,832,603
Хорогдуулсан өртгөөр хэмжих өрийн үнэт цаас	5,138,380	5,223,007
Хорогдуулсан өртгөөр хэмжих урвуу репо хэлцэл	579,119	341,298
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон нийт хүүгийн орлого	556,957,598	463,853,291
Бусад ижил төстэй орлого		
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	10,475,532	10,422,164
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх өрийн үнэт цаас	10,458,601	19,685,473
Бусад ижил төстэй нийт орлого	20,934,133	30,107,637
Нийт хүүгийн орлого	577,891,731	493,960,928
Хүүгийн зардал		
Харилцагчдын харилцах, хадгаламж	(309,233,601)	(271,060,624)
Зээлийн бусад эх үүсвэр	(39,129,879)	(28,154,692)
Хоёрдогч өглөг	(6,259,246)	(8,618,672)
Бусад банкнудын байршуулсан хөрөнгө	(5,593,306)	(9,437,394)
Репо хэлцэл	(4,939,558)	(5,983,774)
Нийт хүүгийн зардал	(365,155,590)	(323,255,156)
Бусад ижил төстэй зардал		
Түрээсийн зардал	(851,077)	-
Нийт ижил төстэй зардал	(851,077)	-
Нийт хүүгийн болон ижил төстэй зардал	(366,006,667)	(323,255,156)

Цэвэр хүүгийн орлого 211,885,064 170,705,772
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны хүүгийн орлогын өсөлт нь 2019 онд харилцагчдад олгосон зээлийн өсөлттэй холбоотой. Түүнчлэн, бэлэн мөнгө болон Төв Банкнд байршуулсан хөрөнгийн хүүгийн орлого болох 14,047,899 мянган төгрөг (2018: 10,563,116 мянган төгрөг) нь Монголбанкны журмын дагуу бүх банкуудад олгосон Монголбанкнд байршуулсан заавал байлгах нөөцийг 2019 онд хангаж байсантай холбоотой урамшуулал юм.

Үнэ цэнэ нь буурсан харилцагчдад олгосон зээлээс хүлээн зөвшөөрсөн хүүгийн орлого нь ойролцоогоор 8,200,000 мянган төгрөг (2018: 13,500,000 мянган төгрөг) байсан. Удирдлагын зүгээс эдгээр үнэ цэнэ нь буурсан зээлүүд нь бүрэн төлөгдөх ба илүү барьцаа зээлүүд гэж үзсэн. Мөн СТОУС-н дагуу эргэн төлөгдөхгүй гэж үзсэн зээлийн хүүний орлогыг 2019 болон 2018 оны орлого, зардалд хүлээн зөвшөөрөөгүй.

29 Хураамж, шимтгэлийн орлого

Мянган төгрөгөөр	2019	2018
Хураамж, шимтгэлийн орлого		
Карттай холбоотой шимтгэл хураамж	30,182,400	25,517,747
Гуйвуулга ба бусад үйлчилгээний хураамж	14,782,946	11,311,608
Баталгаа болон бусад бичиг цаастай холбоотой шимтгэл, хураамж	5,236,275	5,735,161
Дансны үйлчилгээний шимтгэл хураамж	4,108,079	3,979,242
Брокер болон бусад үйлчилгээний хураамж	788,642	845,507
Нийт хураамж, шимтгэлийн орлого	55,098,342	47,389,265
Хураамж, шимтгэлийн зардал		
Картын гүйлгээний зардал	(13,044,239)	(9,289,774)
Банкны үйлчилгээний зардал	(2,646,484)	(2,352,103)
Онлайн гүйлгээний зардал	(855,456)	(559,770)
Брокер болон бусад үйлчилгээний зардал	(548,149)	(121,709)
Нийт хураамж, шимтгэлийн зардал	(17,094,328)	(12,323,356)
Хураамж, шимтгэлийн цэвэр орлого	38,004,014	35,065,909

30 Бусад үйл ажиллагааны орлого

Мянган төгрөгөөр	2019	2018
Данснаас хасагдсан зээлийн эргэн төлөлт	1,753,453	15,650,555
Үндсэн хөрөнгө борлуулсны олз/(гарз)	(1,536,773)	(2,501,390)
Бусад	807,504	1,817,421
Нийт бусад үйл ажиллагааны орлого	1,024,184	14,966,586

31 Удирдлага ба үйл ажиллагааны зардал

Мянган төгрөгөөр	Тодруулга	2019	2018
Ажилчдын зардал		47,180,146	44,649,282
Мэдээлэл, зөвлөх үйлчилгээ болон бусад мэргэжлийн үйлчилгээний зардал		24,467,538	21,216,368
Үндсэн хөрөнгийн элэгдэл	17	14,015,516	9,757,418
Зар сурталчилгаа, маркетингийн үйлчилгээ		4,596,148	3,405,405
Харилцаа холбооны зардал		4,214,423	3,801,841
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийн зардал	18	3,746,311	-
Програм хангамж болон биет бус хөрөнгийн хорогдол	16	2,860,510	2,647,120
Богино хугацаат түрээсийн зардал		2,689,548	6,441,230
Орлогын албан татвараас бусад татварын зардал		2,049,702	1,988,797
Харуул хамгаалалтын зардал		1,827,825	1,549,515
Зээлийн төлбөр цуглуулалтын зардал		1,728,379	1,774,199
Тээврийн зардал		1,413,818	1,183,079
Ашиглалтын зардал		1,216,332	1,013,836
Аяллын зардал		1,124,938	1,281,742
Сайн дурын болон даатгалын зардал		745,739	579,993
Хүлээн авалтын зардал		689,375	803,560
Хандив		20,771	23,351
Бусад		7,418,811	7,976,232
Нийт удирдлага ба үйл ажиллагааны зардал		122,005,830	110,092,968

Мянган төгрөгөөр	2019	2018
Ажилчдын зардал дараахаас бүрдэнэ:		
Цалин хөлс, урамшуулал	40,489,040	39,104,231
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	5,226,212	4,173,690
Ажилчдын тэтгэмж	643,356	539,207
Ажилчдын сургалт	623,391	795,651
Тэтгэврийн сан	198,147	36,503
Нийт ажилчдын зардал	47,180,146	44,649,282

32 Орлогын албан татвар

(а) Орлогын албан татварын зардлын бүрэлдэхүүн

Тайлант жилийн орлого, зарлагад бүртгэсэн орлогын албан татварын зардлыг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2019	2018
Тайлант жилийн орлогын албан татвар	11,756,756	5,131,443
Хойшлогдсон орлогын татвар	(3,166,530)	16,922,117
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	8,590,226	22,053,560

(б) Татварын зардал ба ашиг, алдагдал хоорондын холбогдох татварын хэмжээгээр тооцсон тохируулга

Банк нь татварын өмнөх ашгийг татвар ногдохгүй орлого болон татвараас хасагдахгүй зардлаар тохируулга хийх замаар орлогын албан татварын зардлыг тодорхойлдог. Банк нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу 3 тэрбум төгрөг (2018: 3 тэрбум төгрөг) хүртэлх татвар ногдох орлогоос 10 хувийн, 3 тэрбум (2018: 3 тэрбум төгрөг)-аас давсан дүнгээс 25 хувь (2018: 25 хувь)-ийн орлогын албан татвар төлдөг.

Мянган төгрөгөөр	2019	2018
Хуулиар заасан хувиар тооцсон татварын зардал (2019: 25%; 2018: 25%)	6,223,727	18,899,950
Татварын зорилгоор татвар ногдохгүй орлого, татвараас хасагдахгүй зардлын татварын нөлөө:		
- Бага хувиар татвар ногдуулах орлогын нөлөө	(450,000)	(450,000)
- Татвараас чөлөөлөгдөх орлого	(565,048)	(3,373,744)
- Өөр хувиар татвар ногдох орлого	(24,044)	(410,568)
- Татвараас хасагдахгүй зардал	3,004,994	1,396,340
- Өмнөх тайлант хугацаанд ашиглагдаагүй татварын алдагдлын хэрэгжээгүй хэсэг	-	5,324,836
- Бусад	400,597	666,746
Тайлант жилийн орлогын албан татварын зардал	8,590,226	22,053,560

(в) Түр зөрүүгийн нөлөөгөөр тодорхойлсон хойшлогдсон татвар

СТОУС болон Монгол Улсын татварын зохицуулалт хоорондын ялгаатай байдал нь хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн данс хооронд түр зөрүү үүсгэдэг.

32 Орлогын албан татвар (үргэлжлэл)

(в) Түр зөрүүгийн нөлөөгөөр тодорхойлсон хойшлогдсон татвар (үргэлжлэл)

2019 оны 25%-р татвар ногдуулдаг түр зөрүүний хөдөлгөөнөөс үүдэлтэй нөлөөний дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2019 оны 01 сарын 01	Ашиг, алдагдал	Бусад дэлгэрэнгүй орлого	2019 оны 12 сарын 31
Татвараас чөлөөлөгдөх/(татвар ногдох) түр зөрүүгийн татварын нөлөө болон хойшлогдсон татварын алдагдал:				
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа – 90 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй зээлийн хүүгийн орлого	(9,850,031)	1,467,901	-	(8,382,130)
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлт	(2,414,557)	1,025,982	-	(1,388,575)
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өмчийн үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлт	3,032,665	-	2,231,154	5,263,819
Хорогдуулсан өртөг болон бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөх үнэт цаасны зээлжих эрсдэлийн сан	488,805	(430,132)	-	58,673
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн зээлжих эрсдэлийн сан	-	209,850	-	209,850
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	(29,145,005)	603,540	-	(28,541,465)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	12,782,841	(3,170,837)	-	9,612,004
Урьдчилсан орлого – зээл олголтын шимтгэл	2,737,249	(373,393)	-	2,363,856
Барилга байгууламжийн үнэ цэнийн бууралт	11,034,541	(305,963)	-	10,728,578
Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралт, хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлт болон борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт	1,912,404	4,091,206	-	6,003,610
Зээл ба урьдчилгаатай холбоотой анхны гарз болон дахин бүтэцлэгдсний гарз	4,559,226	125,928	-	4,685,154
Бусад	(444,804)	(77,553)	-	(522,357)
Нийт хойшлогдсон татварын хөрөнгө/(өглөг)	(5,306,666)	3,166,529	2,231,154	91,017

2018 оны 25%-р татвар ногдуулдаг түр зөрүүний хөдөлгөөнөөс үүдэлтэй нөлөөний дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2017 оны 12 сарын 31	СТОУС 9 рүү шилжилтийн өмч дэх нөлөө	2018 оны 01 сарын 01	Ашиг, алдагдал	Бусад дэлгэрэнгүй орлого	2018 оны 12 сарын 31
Татвараас чөлөөлөгдөх/(татвар ногдох) түр зөрүүгийн татварын нөлөө болон хойшлогдсон татварын алдагдал:						
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа – 90 хоногоос дээш хугацаа хэтрэлтэй зээлийн хүүгийн орлого	(10,514,987)	-	(10,514,987)	664,956	-	(9,850,031)
Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлт	(99,338)	(13,920,863)	(14,020,201)	11,605,644	-	(2,414,557)
Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх өмчийн үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	477,121	477,121	-	2,555,544	3,032,665
Хорогдуулсан өртөг болон бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрөх үнэт цаасны зээлжих эрсдэлийн сан	-	557,989	557,989	(69,184)	-	488,805
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлт	(13,443,742)	13,443,742	-	-	-	-
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	(8,818,365)	-	(8,818,365)	(20,326,640)	-	(29,145,005)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	6,302,458	18,052,989	24,355,447	(11,572,606)	-	12,782,841
Урьдчилсан орлого – зээл олголтын шимтгэл	1,532,880	-	1,532,880	1,204,369	-	2,737,249
Барилга байгууламжийн үнэ цэнийн бууралт	5,039,406	-	5,039,406	5,995,135	-	11,034,541
Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралт, хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлт болон борлуулах зориулалттай эргэлтийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт	-	-	-	1,912,404	-	1,912,404
Ирээдүйд шилжүүлэгдэх татварын алдагдал	5,400,541	-	5,400,541	(5,400,541)	-	-
Ирээдүйд шилжүүлэгдэх татварын алдагдлын хэрэгжүүлэлт	5,324,836	-	5,324,836	(5,324,836)	-	-
Бусад	(274,760)	-	(274,760)	4,389,182	-	4,114,422
Нийт хойшлогдсон татварын хөрөнгө/ (өглөг)	(9,551,071)	18,610,978	9,059,907	(16,922,117)	2,555,544	(5,306,666)

